



БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2019

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол:

ХАНА ХЭРЭМ БУС ГҮҮР БАРИХ НЬ



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Sustainable
Development
Goals



Global
Education
Monitoring
Report

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2019

**Шилжилт хөдөлгөөн,
дүрвэлт ба боловсрол:**

ХАНА ХЭРЭМ БУС ГҮҮР БАРИХ НЬ

Боловсрол 2030 Инчоны тунхаглал, үйл ажиллагааны хүрээнд Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн үүргийг тодорхойлохдоо “ТХЗ-уудын ерөнхий хэрэгжилтийг хянан үзэх, тоймлон дүгнэх ажлын хүрээнд үүрэг хүлээсэн холбогдох талуудыг үндэсний болон олон улсын стратегийн хэрэгжилтийг тайлагнах” хариуцлагын хамт “ТХЗ 4 болон боловсролын асуудлыг тусгасан холбогдох бусад ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, тайлагнах механизм болно” гэжээ.

Энэхүү хэвлэлд ашигласан тодорхойлолт, нэр, хаяг болон бусад материалын танилцуулга нь аливаа улс орон, газар нутаг, хот, бүс нутгийн хууль эрх зүйн байдал, түүний эрх бүхий байгууллага, удирдлага, эсхүл түүний хил хязгаарыг тогтоох, хязгаарлах талаар ЮНЕСКО-ийн зүгээс ямар нэг байр суурь илэрхийлж буй хэрэг биш болно.

Уг тайланд дурдсан баримтуудын сонголт, танилцуулга, түүнчлэн илэрхийлэгдэж байгаа үзэл бодол, байр суурийн хувьд Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан боловсруулах баг хариуцлага хүлээх бөгөөд энэ нь ЮНЕСКО-ийн байр суурийг илэрхийлээгүй бөгөөд байгууллагын хувьд тийм үүрэг хүлээгээгүй болно. Энэ тайланд илэрхийлсэн үзэл бодол, байр суурийн талаарх ерөнхий хариуцлагыг тайлан боловсруулах багийн захирал хүлээнэ.

Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайланг боловсруулсан баг

Захирал: Манос Антонинис

Даниель Ейприл, Билал Баракат, Мэдлен Барри, Николь Белла, Анна Кристина Д’Аддио, Глен Хертеленди, Сибастьян Хайне, Приядаршани Жоши, Катаржина Кубацка, Кейт Линкинс, Лейла Луйпис, Кассиани Литрангомитис, Аласдайр МкВиллиам, Анисса Мечтар, Клаудин Мүкизва, Юки Мураками, Карлос Алфонсо Обрегон Мелгар, Жудит Рандрианатоавина, Кейт Редман, Мария Рожнов, Анна Ева Русжиевич, Уилл Смит, Роза Видарте, Лема Зекря.

Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан нь жил тутмын хараат бус хэвлэл юм. Энэхүү тайланг боловсруулах ажлыг засгийн газрууд, олон талт хөгжлийн агентлагууд болон хувийн сангуудын нэгдэл санхүүжүүлж, ЮНЕСКО-ийн зүгээс зохих дэмжлэг үзүүлж, зохицуулалт хийсэн болно.



Энэхүү хэвлэлийг (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>) лицензийн дагуу ашиглахаар Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) Нээлттэй хандалтад байршуулсан болно. Хэрэглэгчид энэхүү хэвлэлийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-ийн Нээлттэй хандалтын сан (<http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en>)-гийн хэрэглэх нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Одоо эзэмшиж буй лиценз нь тус хэвлэлийн эхийн агуулгад онцгой эрхтэйгээр хамаарна. ЮНЕСКО-д хамаарагдах эсэх нь тодорхой бус аливаа материалыг ашиглах тохиолдолд дараах хаягаар зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай: publication.copyright@unesco.org эсвэл UNESCO Publishing, 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP France.

Хэвлэлийн англи нэр: Global Education Monitoring Report Summary 2019: Migration, displacement and education: Building bridges, not walls

Энэхүү хэвлэлийг дараах байдлаар эх сурвалж болгон ашиглаж болно: ЮНЕСКО. 2018. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй 2019: Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол – Хана хэрэм бус гүүр барих нь. Парис, ЮНЕСКО.



Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу:

Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан боловсруулах баг

с/о UNESCO, 7, place de Fontenoy 75352 Paris 07 SP, France

Цахим хаяг: gemreport@unesco.org
Утас: +33 1 45 68 07 41
www.unesco.org/gemreport <https://gemreportunesco.wordpress.com>

Хэвлэлтийн дараа илэрсэн аливаа алдаа, хасагдсан зүйлийг www.unesco.org/gemreport холбоос дахь цахим хувилбарт залруулах болно.

© UNESCO, 2018
Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно.
Эхний хэвлэл
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагаас 2018 онд хэвлүүлэв.

Хаяг: 7, Place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France

Эх бичвэрийг ЮНЕСКО
График дизайныг FNI 360
Эх бэлтгэлийг ЮНЕСКО

ED-2018/WS/51

Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн цувралууд

2017/8 Боловсролд хариуцлагатай хандах нь: Бидний үүрэг амлалтын биелэлт

2016 Хүмүүс, гараг дэлхийн төлөөх боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь

Бүх нийтийн боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн цувралууд

2015 Бүх нийтийн боловсрол 2000-2015: Ололт амжилт ба сорилтууд

2013/4 Сургахуй ба суралцахуй:
Бүх нийтийн төлөө чанарыг ахиулах нь

2012 Залуучууд ба үр чадвар: Хөдөлмөрт нийцсэн боловсрол

2011 Далд хямрал: Зэвсэгт мөргөлдөөн ба боловсрол

2010 Эмзэг бүлгийнхэнд хүрэхүй

2009 Тэгш бус байдлыг даван туулах нь:
Засаглал яагаад чухал вэ

2008 Бүх нийтийн боловсрол 2015 онд:
Бид хийж амжих уу

2007 Бат бөх суурь: Бага насны хүүхдийн асаргаа ба боловсрол

2006 Аж төрөхийн тулд бичиг үсэгт тайлагдахуй

2005 Бүх нийтийн боловсрол: Чанарыг чанд сахихуй

2003/4 Жендер ба Бүх нийтийн боловсрол:
Тэгш байдалд хүрэх өөрчлөлт

2002 Бүх нийтийн боловсрол: Дэлхий зөв чиглэлд явж байна уу

Хавтасны зургийг: Рашди Сарраж/Ойрхи Дорнод дахь Палестин дүрвэгсдийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусламжийн агентлаг

Тайлбар: Палестины дүрвэгч сурагчид, НҮБ-ын Тусламжийн агентлагийн дэмжлэгтэй байгуулагдсан Газа дахь сургуулийн хоёрдугаар улирлын эхний өдөр.

Инфографикийг Housatonic Design Network

Тайлангийн хураангуй болон холбогдох бүх материалыг <http://bit.ly/2019gemreport> цахим хуудаснаас татаж авах боломжтой.

ӨМНӨХ ҮГ

Хүмүүс үргэлж илүү сайн боломжуудыг эрэлхийлж эсвэл аюулаас зайлсхийж нэг газраас нөгөө рүү шилжин нүүдэллэсээр ирсэн. Эдгээр шилжилт хөдөлгөөн нь боловсролын тогтолцоонд асар их нөлөө үзүүлдэг. 2019 оны Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан нь дэлхийн өнцөг булан бүрт тулгарч буй эдгээр асуудлыг нарийвчлан судлах эхний алхам болж байна.

Олон улсын байгууллагуудаас Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжилт хөдөлгөөний талаарх даян дэлхийн гэрээ, Дүрвэгсдийн талаарх даян дэлхийн гэрээ гэсэн хоёр чухал олон улсын баримт бичгийг эцэслэн боловсруулж буй үед энэхүү тайлан нь цаг үеэ олсон ажил болж байна. Урьд өмнө байгаагүй энэ хоёр гэрээ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилго 4-т тусгасан боловсролын талаарх олон улсын үүрэг амлалтын хамт шилжин суурьшигчид, дүрвэгчдийн боловсролын асуудлуудад анхаарал хандуулах хэрэгцээ шаардлагыг онцгойлон анхаарч байна. Энэхүү БХШД-ийн тайлан нь бидний хүсэл зорилгыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бодлого боловсруулагчдын хувьд нэн чухал лавлах болох юм.

Одоогийн байдлаар хууль эрх зүй, бодлого журмууд нь шилжин суурьшигч, дүрвэгч хүүхдүүдийн эрхийг үгүйсгэж, хэрэгцээ шаардлагуудыг нь үл ойшоох байдлаар тэднийг анхаарлын гадна орхигдуулж байна. Шилжин суурьшигчид, дүрвэгчид болон дотооддоо дүрвэгчид дэлхий дээрх хүн амын хамгийн эмзэг бүлэгт тооцогдох ба тэдний дунд ядуусын хороололд амьдарч буй хүмүүс, амьдралаа залгуулах зорилгоор улирал даган нүүдэллэгсэд болон түр саатуулах байранд буй хүүхдүүд багтаж байна. Гэвч аюулгүй орчноор хангаж, сайн сайхан ирээдүйг амлах ёстой сургуульд тэднийг суралцуулахаас ихэнхдээ шүүд татгалздаг.

Шилжин суурьшигчдын боловсролыг үл ойшоох нь хүний чадамжийг ашиглах чухал боломжийг алдахад хүргэдэг. Заримдаа энгийн бичиг цаасны ажил, тоон мэдээллийн дутмаг байдал эсвэл хүнд суртал, тогтолцооны зохицуулалтгүй байдлын улмаас олон иргэн хохирч үлддэг. Хэдий тийм ч өндөр чадвартай, хүсэл зорилго дүүрэн шилжин суурьшигчид, дүрвэгчдийн боловсролд хөрөнгө оруулах нь тэднийг хүлээн авч буй орнууд төдийгүй тэдний эх орных нь хөгжил, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой.

Дан ганц боловсрол олгоно гэдэг нь хангалттай бус. Шилжин суурьшиж буй тэдгээр иргэдийн тусгай хэрэгцээнд сургуулийн орчин зохицон нийцэж, шаардлагатай дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Цагаач, дүрвэгчдийг хүлээн авагч орны хүн амтай нэгэн сургуульд суралцуулах нь нийгмийн эв зетэй байдлыг хөхиүлэн дэмжих чухал эхлэл юм. Хэдий тийм ч хичээл зааж буй байдал, хичээлийн явцад хэрэглэж буй хэл болон ялгаварлан гадуурхалт нь тэднийг сургуулиас хөндийрөхөд хүргэдэг.

Сайтар мэргэшсэн багш нар цагаач, дүрвэгч суралцагчдыг тэгш хамруулахад нэн чухал үүрэгтэй хэдий ч ихэнх тохиолдолд нийгэм-сэтгэлзүйн хувьд дэмжлэг шаардлагатай сурагчидтай олон хэл, олон соёл бүхий ангид хичээл ороход тэдэнд ч мөн дэмжлэг хэрэгтэй.


Аливаа зүйлсийн олон янз байдлыг хөхиүлэн дэмжсэн, шүүмжит сэтгэлгээг хөгжүүлсэн, өрөөсгөл хуучинсаг хандлагыг үгүйсгэсэн, сайтар боловсруулсан сургалтын хөтөлбөр маш чухал бөгөөд энэ нь анги танхимаас гаднах орчинд ч цаашид түгэн дэлгэрэх эерэг үр нөлөө үзүүлдэг. Заримдаа сурах бичгүүд шилжилт хөдөлгөөний талаар хоцрогдсон дүрслэл, ойлголтыг агуулж, тэгш хамруулах хүчин чармайлтыг нураадаг. Мөн олон сургалтын хөтөлбөр байнгын шилжин суурьшиж буй иргэдийн амьдралын хэв маягт нийцэхүйцээр хангалттай уян хатан байж чадахгүй байна.

Үйлчилгээний цар хүрээг тэлэх, тэгш хамралтыг баталгаажуулахад хөрөнгө санхүүжилт шаардлагатай бөгөөд шилжин суурьшигчдыг хүлээн авагч олон орон дангаараа энэхүү шаардлагыг хангаж чаддаггүй. Хүмүүнлэгийн тусламж нь ихэвчлэн хязгаарлагдмал бөгөөд урьдчилан тооцоолох боломжгүй байдаг тул одоогоор хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна. Боловсрол хүлээх боломжгүй хэмээх шинэ сан нь хамгийн эмзэг бүлгийнхний зарим хэсэгт хүрэх чухал механизм юм.

Энэхүү тайлангаар дамжуулан илгээх гол санаа нь маш тодорхой: шилжин нүүдэллэж буй иргэдийн боловсролд зарцуулах хөрөнгө оруулалт нь бүхимдал, үймээн самуунд хүргэх зам тавих болон нийгмийн эв нэгдэл, энх тайван байдалд хүргэх зам барих хоорондын ялгавраар тодорхойлогдох болно.

Одри Азулэй

ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал



ӨМНӨХ ҮГ

Боловсролын хяналт шинжилгээний 2019 оны дэлхийн тайланг олон улсын цагаач иргэдээс бүрдсэн баг боловсруулсан ба багийн гишүүдийн дөрөв нь дүрвэгчдийн хүүхдүүд байлаа. Хүмүүс шилжилт хөдөлгөөн, дүрвэлт болон шилжин суурьшигчдыг өөр, өөр өнцгөөс хардаг гэдгийг тэд үгүйсгэсэнгүй. Тэдний судалгаагаар боловсрол нь тэдгээр үзэл бодлыг нээлттэй ярилцахад нь тусалснаар бүх хүнд илүү олон боломжийг олгож болох цар хүрээг харуулсан юм.

Шилжин суурьшигчид, дүрвэгчид болон тэднийг хүлээн авагч нутгийн иргэдийн хувьд мэдэх, мэдэхгүй асуудлууд байдаг. Гэсэн ч зарим иргэдийн мэдэж буй асуудал нь ердөө гачигдал болон түүнээс зугтаах хэрэгцээ байдаг; тэд нөгөө талд боломж байх эсэхийг мэдэхгүй. Хүлээн авч буй нутаг орны иргэд өөр хувцас өмссөн, өөр зан заншилтай, өөр аялгаар ярих шинэ хөршүүд нь тэдний амьдралыг өөрчлөх эсэх эсвэл хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй байж болно.

Шилжилт хөдөлгөөнийг дэг журамтай болон дэг журамгүй байдлын аль алианаар тодорхойлдог. Улс орнууд хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулахыг чармайдаг ч урьдчилан төлөвлөгдөөгүй шилжилт хөдөлгөөний үргэлжилсэн үрсгалтай тулгарч болзошгүй байдаг. Ийм шилжилт хөдөлгөөний улмаас шинэ зөрчил тэмцэл үүсч болох ч зарим тохиолдолд шилжин суурьшигч иргэдийн эх орон болон тэднийг хүлээн авч буй улс орон аль аль нь үр ашгийг нь хүртсэн явдал их байдаг.

Шилжилт хөдөлгөөний үед бид хүсэл зорилго, албадлагын аль алиныг мэдэрдэг. Зарим хүмүүс ажиллаж, сурах зорилгоор идэвхтэйгээр шилжин нүүж байхад зарим нь хавчилга дарамтаас зугтаах эсвэл амьжиргаанд нь аюул заналхийлэл учирсны улмаас хүчээр дүрвэхэд хүрдэг. Хүлээн авч буй орны иргэд, улс төрчид шилжин суурьшигчдыг хүчээр эсвэл сайн дураар, хууль ёсоор эсвэл хууль бусаар, аз завшаан эсвэл аюул заналхийлэл, үр ашиг эсвэл дарамт болохоор шилжин ирсэн эсэх талаар маргаж болох юм.

Найрсгаар хүлээн авах эсвэл бухимдан үгүйсгэхийн аль аль нь тохиолддог. Зарим хүмүүс шинэ орчиндоо дасан зохицож байхад зарим нь чаддаггүй. Тэдэнд туслах хүмүүс байхад тэднийг гадуурхахыг хүсдэг нь ч мөн байдаг.

Тиймээс бид шилжин суурьшигчид, дотооддоо дүрвэгчдийн асуудал дэлхийн өнцөг булан бүрт анхаарлын төвд тавигдаж буйг харж байна. Эдгээр асуудлын талаар олон ч шийдвэр гаргах шаардлага бий. Шилжилт хөдөлгөөний үед тохиромжтой хариу арга хэмжээ авах шаардлага тулгарч байна. Бид саад бэрхшээлийг улам нэмэх эсвэл итгэлцлийг бий болгож, тэгш хамруулж, найдвар төрүүлэхийн тулд саад бэрхшээлийг даван туулж болно.

Олон улсын түвшинд Нэгдсэн үндэстний байгууллагаас шилжилт хөдөлгөөн, дүрвэгчдийн асуудалд тулгарч буй сорилт бэрхшээлүүдэд үрт хугацааны шийдэл олох зорилгоор улс үндэстнүүдийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхийн төлөө ажиллаж байна. 2016 онд болсон дүрвэгч, цагаачдын талаарх НҮБ-ын Дээд хэмжээний уулзалтын үеэр миний бие зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, зуучлалын үйлчилгээ үзүүлэх, сайн засаглалыг бий болгох, хуулийг дээдлэх, нийгмийн эрх тэгш оролцоо бүхий эдийн засгийн өсөлтийг бий болгоход хөрөнгө оруулах талаар уриалга гаргасан. Мөн цагаачдын хувьд тулгарч буй эрх тэгш бус асуудлыг шийдвэрлэхийн тулд нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулахыг зөвлөсөн.

Боловсролын үйлчилгээ үзүүлнэ гэдэг нь зөвхөн боловсролын асуудал эрхэлсэн ажилтан, албан хаагчдын ёс зүйн үүрэг хариуцлага бус харин шилжин суурьшиж буй хүн амын өсөн нэмэгдэж буй сонирхол хэрэгцээг хангах практик шийдэл юм хэмээн тус тайлан бидэнд сануулж байна. Боловсрол нь шилжилт хөдөлгөөний үед үзүүлэх хариу арга хэмжээний үндсэн чухал хэсэг байх ёстой ба шилжин суурьшигчид, дүрвэгчдийн талаарх даян дэлхийн хоёр гэрээнд тусгагдсанаар энэ нь цаг үеэ олсон асуудал болсныг харуулж байна.

Боловсрол эзэмшихийг нь үгүйсгэх нь тэдгээр иргэдийг хувьд эмзэг байдалд хүргэх, бухимдалыг нь төрүүлэх үр дагаварт хүрч болзошгүй юм. Боловсролыг буруу замаар олгосноор түүхийг гуйвуулж, үл ойлголцолд хүргэх эрсдэлтэй.

Гэвч боловсрол нь эдгээр тохиолдлуудад мөн гүүр болж болох талаар тайланд дурдсанчлан Канад, Чад, Колумби, Ирланд, Лебанон, Филиппин, Турк болон Уганда улсын маш олон урам зориг өгсөн жишээнээс харж болно. Боловсрол нь хүмүүсийн хамгийн сайхан чанаруудыг ил гаргаж, өрөөсгөл ойлголт, хуучинсаг үзэл, ялгаварлан гадуурхалтыг шүүмжит сэтгэлгээ, эв нэгдэл, нээлттэй байдлаар солиход хүргэж чадна. Мөн боловсрол нь зовж шаналсан нэгэнд тусламжийн гараа сунгаж, эерэг боломжийг чин сэтгэлээсээ эрэлхийлсэн хүмүүст амжилтын гаргаагаа эхлүүлэх боломжийг олгодог.

Энэхүү тайланд үндсэн бэрхшээл болсон асуудал болох багш нарт тэгш хамруулах боловсролыг практикт хэрэгжүүлэхэд хэрхэн дэмжлэг үзүүлэх асуудлыг хөндсөн. Тайланд хүмүүнлэг энэрэнгүй үзэл, урт хугацаанд үргэлжилж буй шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг тусгасан. Миний зүгээс тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг анхааралдаа авч, хэрэгжүүлэхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна.

Эрхэмсэг хатагтай (The Rt Hon)
Хелен Кларк
БХШД-ийн тайлангийн Зөвлөх Хорооны дарга



Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол

Дэлхий даяар шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн талаарх сэтгэл хөдөлгөм түүхүүд өрнөсөөр. Хүсэл зорилго, итгэл найдвар, айдас хүйдэс, горьдлого, ухаалаг байдал, амжилт, золиос, эр зориг, тэвчээр, санаа зовнилын түүхүүд нь бидэнд “шилжилт хөдөлгөөн хүн төрөлхтөний нэр төр, аюулгүй байдал, сайн сайхан ирээдүйн төлөөх урам зоригийн илэрхийлэл” болдог талаар сануулж байна. ‘Энэ нь нийгэм хэмээх бүрэлдэхүүний хэлтэрхий, хүн төрөлхтөний гэр бүлийн нэг хэсэг юм.’ Хэдий тийм боловч шилжилт хөдөлгөөн, дүрвэлт нь ‘улс үндэстэн, нийгэм дотор болон эдгээрийн хооронд үүсэх зөрчлийн эх үүсвэр болдог... Сүүлийн жилүүдэд цөхрөнгөө барсан цагаачид, дүрвэгчид олноор нүүдэллэж байгаа нь шилжилт хөдөлгөөний өргөн хүрээнд бий болох эерэг үр нөлөөг бууруулсан’.

Бүх нийтийн сайн сайхан байдлын төлөө хамтдаа хүлээх үүрэг хариуцлагыг албан ёсоор Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт баталсан байхад шилжилт хөдөлгөөн, дүрвэлт нь орчин цагийн нийгэмд сөрөг хариу үйлдэл үзүүлсээр байна. Эдгээр нөхцөл байдлыг оппортунистууд буруугаар ашиглаж, гүүр бус хана хэрэм босгох байдлаар ашиг хонжоо олж болно хэмээн харж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал дахь үндсэн үүрэг амлалт болох боловсролын гүйцэтгэх үүргийг “улс үндэстнүүд, арьс өнгө, шашны бүлгүүдийн дунд ойлголцол, хүлээцтэй байдал, нөхөрлөлийг дэмжин түгээх” хэмээн заасан байгаа нь асуудлын зангилаа болж байна.

Энэхүү тайлан нь шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн асуудлыг олон үндэстний бүрэлдэхүүн бүхий анги танхим, сургуулийн орчин, орон нутаг, хөдөлмөрийн зах зээл болон нийгмийн хүрээнд бодит байдалтай нүүр тулан ажиллаж буй багш нар, боловсролын удирдах ажилтнуудын нүдээр дүрслэн үзүүлж байна. Дэлхий дээрх боловсролын тогтолцоонууд ‘тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжиж’, ‘хэнийг ч орхигдуулахгүй байх’ үүрэг амлалтын хүрээнд нэгдээд байна. Бүх суралцагчдад өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд тэдний гарал үүсэл, хэн байхаас үл хамааран боловсролын тогтолцоо нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцэн өөрчлөгдөх хэрэгтэй болоод байна. Боловсролын тогтолцоо нь тэрчлэн цагаач, дүрвэгч хүн ам олон, цөөнөөс үл хамааран улс орнуудад адил тулгарч буй сорилт болох шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн нөлөөнд уян хатан байж, сайтар дасан зохицох нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой.

Тус тайланд иргэдийн бүх төрлийн шилжилт хөдөлгөөнийг авч үзсэн. Дунджаар найман хүн тутмын нэг нь дотооддоо шилжин суурьшиж байна. Энэхүү шилжилт хөдөлгөөн нь нэн ялангуяа эрчимтэй хотжиж буй бага, дунд орлоготой орнуудын шилжин суурьшиж буй иргэд болон шилжихгүйгээр орон нутагтаа үлдэж буй хүмүүсийн боловсролын хувьд ихээхэн нөлөөлж байна. 30 хүн тутмын нэг нь төрж өссөн нутаг орноосоо өөр улс оронд амьдарч байна. Олон улсын шилжин суурьшигчдын бараг гуравны хоёр нь өндөр орлоготой орнуудад суурьшжээ. Ихэнх нь ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжин суурьшсан байхад зарим нь боловсрол эзэмших зорилгоор нүүсэн байна. Олон улсын шилжилт хөдөлгөөн нь тэдгээр иргэдийн үр хүүхдүүдийн боловсролд мөн нөлөө үзүүлж байна. 80 хүн тутмын нэг нь зөрчилдөөн самуун эсвэл байгалийн гамшгийн улмаас улс дотроо эсвэл хилээс гадагш шилжин суурьшиж байна. Эдгээр хүмүүсээс арван хүн тутмын ес нь бага, дунд орлоготой орнуудад амьдарч байна. Эдгээр хүмүүсийг хүлээн авагч улс орны боловсролын тогтолцоонд хамруулах нь нэн чухал хэдий ч шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн онцлог байдлаас шалтгаалан нөхцөл байдал өөр, өөр байна.

Шилжилт хөдөлгөөн болон дүрвэлт нь шилжин суурьшиж буй, нүүлгүй үлдэж буй эсвэл шилжин суурьшигчид, дүрвэгчдийг хүлээн авч буй болон хүлээн авч болох бүх талд нөлөөлөх ээдрээтэй, хоёр талт харилцаагаар дамжуулан боловсролтой холбогдож байна (Хүснэгт 1). Амьдралын мөчлөгийн хүрээнд хүмүүс шилжилт хөдөлгөөнийг боловсролд зориулах хөрөнгө оруулалт, суралцах үйл явцаас түр завсарлах, туршлага хуримтлуулах болон эцсийн үр дүнг тодорхойлогч үндсэн хүчин зүйл хэмээн цэгнэж ойлгодог. Боловсролын хөгжил доогуур түвшинтэй газар нутгаас шилжин ирж буй хүүхдүүд өөрсдийн төрөлх орон нутагт нь байхгүй боломжийг эдлэх боломжтой болдог. Үүнтэй зэрэгцэн шилжин ирж буй хүүхдүүдийн сурлагын амжилт нь тухайн орны үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад ихэвчлэн хоцрогдолтой байдаг.

ХҮСНЭГТ 1:**Боловсрол ба шилжилт хөдөлгөөн хоорондын харилцааны талаарх зарим жишээ**

		Шилжилт хөдөлгөөн/дүрвэлтийн боловсролд үзүүлэх үр нөлөө	Боловсролын шилжилт хөдөлгөөн/дүрвэлтэд үзүүлэх үр нөлөө
Үндсэн улс орон	Шилжин суурьшигчид	<ul style="list-style-type: none"> Шилжилт хөдөлгөөн нь ядуусын хороолол дахь үйлчилгээнд саад бэрхшээл учруулдаг. Боловсролын тогтолцоо нь улирал даган эсвэл байнгын давтамжтайгаар шилжин нүүдэллэх хүн амын хэрэгцээ шаардлагад нийцэх хэрэгтэй болдог. 	<ul style="list-style-type: none"> Боловсрол өндөр байх тусам шилжин нүүдэллэх магадлал өндөр.
	Шилжилгүй үлдсэн хүмүүс, ар гэр	<ul style="list-style-type: none"> Шилжилт хөдөлгөөн нь хөдөө орон нутгийн хүн амын тоог цөөрүүлж, боловсролын үйлчилгээг бэрхшээлтэй болгодог. Шилжин суурьшигчдын гадаадаас ар гэртээ шилжүүлж буй мөнгөн гуйвуулга нь орон нутгийн түвшинд боловсролд нөлөө үзүүлдэг. Эцэг эх нь өөр улсад байх нь хүүхдэд нөлөө үзүүлдэг. Цагаачлалын хэтийн төлөв нь боловсролд хөрөнгө оруулах байдлыг бууруулдаг. Шинэ хөтөлбөрүүд шилжин суурьшигчдыг хүсэл зорилготой болгож бэлтгэдэг. 	<ul style="list-style-type: none"> Боловсролтой иргэд (түхэйлбал, өндөр боловсролтой эрдэмтэд, мэргэжилтнүүд г.м) цагаачлах нь зарим орон нутаг, салбарын хөгжилд сөрөг үр дагавар үзүүлдэг.
Хүлээн авагч улс орон	Цагаачид ба дүрвэгчид	<ul style="list-style-type: none"> Цагаачид, тэдний үр хүүхдийн боловсролын амжилт нутгийн иргэдээс хоцрогдолтой байдаг. Дүрвэгчдийг үндэсний боловсролын тогтолцоонд хамруулах шаардлагатай. Дүрвэгчдийн боловсрол эзэмших эрхийг хангах шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> Цагаачдын боловсролын түвшин хэт өндөр байх тохиолдолд тэдний үр чадварыг бүрэн зөвшөөрөхгүй эсвэл бүрэн дүүрэн ашиглахгүй байх ба тэдний амьжиргаанд өөрчлөлт ордог. Дээд боловсролыг олон улсын чанартай болгох нь оюутны шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг.
	Нутгийн оршин суугчид	<ul style="list-style-type: none"> Олон үндэстний суралцагч бүхий анги танхимд сайтар мэргэшсэн багш нар, шинээр ирэгсдэд туслах болон тэднийг тусгаарлахаас хамгаалсан зорилтот хөтөлбөр болон дэлгэрэнгүй мэдээллийн сан байх шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> Албан болон албан бус боловсрол нь уян хатан нийгмийг бүрдүүлж, хуучинсаг үзэл, ялгаварлан гадуурхалт түгэхийг бууруулдаг.

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн улмаас боловсролын тогтолцоо нь шилжин суурьшигчид төдийгүй тэдний ард үлдсэн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцэн өөрчлөгдөх шаардлагатай болдог. Улс орнууд шилжин суурьшигчид, дүрвэгчдийн хуулиар олгогдсон боловсрол эзэмших эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг амьдралд бодитоор хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэд ядуусын хороололд чихцэлдэн амьдарч буй иргэд, нүүдэлчид болон дүрвэгчийн албан ёсны зөвшөөрлөө хүлээж буй иргэдийн онцлог хэрэгцээнд тааруулан боловсролын үйлчилгээг хүргэх шаардлагатай. Боловсролын тогтолцоо нь тэгш хамруулсан байж, тэгш боломжийн төлөөх үүрэг амлалтыг биелүүлэх хэрэгтэй. Багш нар олон үндэстний иргэд болон шилжилт хөдөлгөөн, нэн ялангуяа дүрвэлтээс үүдсэн сэтгэл зүйн эмгэгтэй

“

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн улмаас боловсролын тогтолцоо нь шилжин суурьшигчид төдийгүй тэдний ард үлдсэн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцэн өөрчлөгдөх шаардлагатай болдог.

”

байгаа суралцагчидтай ажиллахад бүрэн бэлтгэгдсэн байх ёстой. Цагаач, дүрвэгчдийн үр чадварыг үр дүнтэй ашиглахын тулд тэдний мэргэшил болон өмнө нь сурч мэдсэн зүйлсийг нь хүлээн зөвшөөрөх явдлыг орчин үеийн түвшинд хүргэснээр урт хугацааны хөгжил дэвшилд ихээхэн үр нөлөө үзүүлэх болно.

Боловсрол нь мөн шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн хэмжээ болон тэдгээрийн талаарх ойлголтод асар их нөлөөлдөг. Боловсрол нь шилжин нүүдэллэх, илүү сайн сайхан амьдралыг эрэлхийлсэн эрлийг цэнэглэх шийдвэрийн голлох хүчин зүйл

болдог. Боловсрол нь шилжин суурьшигчдын үзэл хандлага, хүсэл эрмэлзлэл, итгэл үнэмшил болон шинээр очсон газартаа дасан зохицож, өөриймсөг болоход нь нөлөөлдөг. Анги танхимд олон үндэстний суралцагч нэмэгдэх нь тухайн нутгийн үндсэн суралцагчдын (нэн ялангуяа ядуу, нийгэмд гадуурхагдсан бүлгийнхний) хувьд ч мөн сорилт бэрхшээлийг бий болгодог хэдий ч бусад соёл, түршлагаас суралцах олон боломжийг бүрдүүлдэг. Сөрөг үзэл хандлагын талаарх асуудлуудын тухай мэдрэмжтэй байдлаар оруулсан сургалтын хөтөлбөр юу юунаас илүү шаардлагатай болоод байна.

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт нь улс төрийн халуун сэдэв болж байна. Мөн боловсрол нь иргэдэд асуудлыг шүүмжит сэтгэлгээнд тулгуурлан ойлгоход нэн чухал юм. Түүнчлэн, боловсрол нь мэдээллийг боловсруулах, ялангуяа даяаршиж буй дэлхий ертөнцөд чухал болох эв зетэй нийгмийг бий болгох явдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдий тийм ч боловсрол нь тэсвэр тэвчээрээс илүү өргөн хүрээтэй асуудлыг хөндөж, анхаарал хандуулахгүй байгаа асуудлыг ил гаргаж ирэх ёстой хэвээр байна; боловсрол нь хуучинсаг үзэл, хэвшмэл ойлголт болон ялгаварлан гадуурхалтай тэмцэх чухал арга хэрэгсэл юм. Гэвч зарим тохиолдолд боловсрол нь цагаач, дүрвэгчдийн талаарх ойлголт дүрслэлийг сөрөг, дутуу дулимаг, хэт дөвийлгөсөн эсвэл няцаасан байдлаар олон нийтэд түгээж байна.

2019 оны Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланд шилжилт хөдөлгөөн, дүрвэлт болон боловсролын талаарх дэлхий дахинд бий болсон баримтуудыг тоймлон үзэж, дараах асуултуудад хариулт олохыг зорьлоо:

- Хүн амын шилжилт хөдөлгөөн нь боловсролын хүртээмж болон чанарт хэрхэн нөлөөлдөг вэ? Шилжин суурьшигч болон дүрвэгч хувь хүмүүсийн хувьд эдгээр нь ямар хамааралтай вэ?
- Боловсрол нь шилжин суурьшигч иргэдийн амьдралд болон хүлээн авагч орны иргэдийн хувьд ямар өөрчлөлтийг авчирч болох вэ?

БОХ 1:**Шилжин суурьшиж, дүрвэж буй иргэд болон тэднийг хүлээн авч буй хүн амын боловсрол, бусад хэрэгцээнд дэлхий нийтээрээ анхаарал хандуулах боллоо**

Шилжин суурьшиж, дүрвэж буй иргэд болон тэднийг хүлээн авч буй хүн амын боловсрол, бусад хэрэгцээнд орон нутаг, үндэсний бөгөөд олон улсын түвшинд анхаарал хандуулахын тулд санхүүжилт босгох болон төрөл бүрийн үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай. Дэлхий дахинаа энэхүү чиглэлийг баримталж байна. 2016 оны 9 дүгээр сард НҮБ-ын 193 гишүүн орон хариуцлага хамтран хүлээх механизмыг бэхжүүлэх, сайжруулах зорилгоор Дүрвэгч, цагаачдын талаарх Нью Йоркийн тунхагт нэгдэн гарын үсэг зурсан нь цагаачид, дүрвэгчдийн талаарх даян дэлхийн хоёр гэрээг боловсруулах үйл явцыг урагшлуулсан явдал болсон билээ.

Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжилт хөдөлгөөний талаарх даян дэлхийн гэрээний төсөлд тус тайланд авч үзсэн ихэнх асуудлыг тусгасан. Үүнд суурь үйлчилгээний хүртээмж, тухайлбал сургуулиар олгох болон сургуулиас гадуурх боловсролын асуудлуудыг хөндсөн байна. Гэрээ нь цагаач, дүрвэгч иргэдийн үр чадварыг хүлээн зөвшөөрөхөд ихээхэн анхаарал хандуулж буйн зэрэгцээ боловсролыг шилжилт хөдөлгөөнд

оролцож буй иргэдийн хувьд боломжуудыг бий болгодог хэмээх эерэг мэдээллийг агуулсан байна. Гэвч тус гэрээ нь заавал дагаж мөрдөх нөхцөлгүй тул улс орнууд үүрэг амлалтаа хэрхэн хэрэгжүүлэхийг нээлттэй үлдээсэн.

Дүрвэсэн иргэдэд боловсрол олгохдоо тэдэнд шинэ орчинд дасан зохицох, удаан үргэлжилсэн дүрвэлтээс үүдсэн асуудлуудыг даван туулахад туслах зорилгоор нэмэлт дэмжлэг үзүүлэх хэрэгтэй болдог. Цагаачид, дүрвэгчдийг хүлээн авагч орнуудад дүрвэгчдийн боловсрол эзэмших эрхийг НҮБ-ын Дүрвэгчдийн статустай холбогдох 1951 оны конвенцээр баталгаажуулсан хэдий ч Дүрвэгчдийн талаарх даян дэлхийн гэрээнд тус үүрэг амлалтыг дахин сэргээхээр зорьж байна. Гэрээний төслийн эцсийн хувилбарт боловсролын талаарх хоёр цогцолборыг тусгахдаа санхүүжилт болон тус санхүүжилтийг тодорхой бодлого журмуудыг дэмжихэд ашиглах талаар анхаарсан байна. Энэ нь тэгш хамруулах талаарх үндэсний бодлогыг боловсруулах хэрэгцээ шаардлагыг илүү тодорхой болгож байна.

Дотоодын шилжилт хөдөлгөөн

Ойролцоогоор 763 сая хүн төрж өссөн нутгаасаа өөр газар амьдарч байна. Байнгын эсвэл түр зуурын, хот хөдөөгийн хооронд эсвэл хот хөдөө дотроо явагддаг зэрэг олон төрлийн шилжилт хөдөлгөөн дотроос хөдөөнөөс хот суурин газрыг чиглэсэн, улирлын чанартай эсвэл тойрог давтамжтай шилжилт хөдөлгөөн нь боловсролын тогтолцоонд хамгийн том сорилт бэрхшээлийг бий болгож байна.

“ Ойролцоогоор 763 сая хүн төрж өссөн нутгаасаа өөр газар амьдарч байна.

” Өндөр орлоготой орнуудад хөдөө орон нутгаас хот суурин газрыг чиглэсэн томоохон шилжилт хөдөлгөөн нь 19 - 20 дугаар зууны дунд үе хүртэлх эдийн засгийн өсөлтийг бий болгосон бол өнөөдөр дотоодын хүн амын хамгийн том шилжилт хөдөлгөөн нь дундаж орлоготой орнууд тухайлбал, Хятад болон Энэтхэгт голлон явагдаж байна. Сахар орчмын Африкт хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь хотын хөгжлийн төлөвлөлтөд бэрхшээл учруулж байна.


Шилжилт хөдөлгөөний хувь насны хувьд ялгаатай хэдий ч хориод насныхан хамгийн олноор шилжилт хөдөлгөөнд оролцож байна. Боловсролын талаас авч үзвэл дотоодын шилжилт хөдөлгөөний үр нөлөөнд өртсөн бага боловсролын түвшний хүүхдүүд харьцангуй цөөн, харин дунд боловсролын түвшний суралцагчид арай олон байна. Гэвч хот суурин газрын боловсролын чанар илүү байгаа нь залуу үеийнхний хувьд шилжилт хөдөлгөөн хийх гол шалтгаан нь болж байна. Тайланд улсад залуучуудын 21% нь боловсролын чанарын асуудлаас шалтгаалан шилжин суурьшсан гэжээ.

Иргэдийн боловсролын түвшин өндөр байх тусам боловсролынхоо үр шимийг хүртэх гэж хаа нэг тийшээ шилжин суурьших магадлал өндөр байдаг (Зураг 1). Боловсролын ачаар олж авсан давуу эрх, хүсэл тэмүүлэл нь илүү цалин хөлс авах боломжоос үл хамааран хөдөө орон нутгийг орхиход нөлөөлдөг. 53 улс оронд шилжин суурьших магадлал нь боловсрол огт эзэмшээгүй иргэдтэй харьцуулахад бага боловсролтой иргэдийн хувьд хоёр дахин өндөр, дунд боловсролтой иргэдийн хувьд гурав дахин өндөр, харин дээд боловсролтой иргэдийн хувьд дөрөв дахин өндөр байна.

ЗУРАГ 1:

Боловсролын түвшин өндөр байх тусам шилжин суурьших магадлал өндөр байна

Шилжилт хөдөлгөөний хувь боловсролын түвшингээр, сонгогдсон орнуудад, 5 жилийн интервалаар, 1999–2010 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig2_3
Эх сурвалж: Bernard et al. (2018).



Огт боловсролгүй иргэдтэй харьцуулахад хөдөө орон нутгаас хот суурин газарт шилжин суурьших магадлал

Шилжилт хөдөлгөөн боловсролын үр дүнг бүх нийтийн хувьд биш зөвхөн зарим иргэдийн хувьд нэмэгдүүлдэг

Хөдөө орон нутагт боловсролын хүртээмж доогуур орнуудын хувьд хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь боловсролын ололт амжилтыг нэмэгдүүлдэг. Индонези улсад түүвэрт хамрагдсан хөдөө орон нутагт төрсөн насны нэг бүлгийнхний хувьд хүүхэд байхдаа хот руу шилжсэн иргэд хөдөө орон нутагтаа үлдсэн иргэдтэй харьцуулахад гурван жил илүү сургуульд суралцсан байна.

Хэдий тийм ч шилжин суурьшигч хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ адил түвшинд боловсролын үр шимийг хүртэж чадахгүй байх талтай. Бразил улсын зүүн хойд бүс нутагт 2000/01 онд төрсөн өсвөр насныхны хувьд дунд сургуульд байхдаа шилжин суурьшсан суралцагчдыг орон нутагтаа үлдсэн үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад анги дэвшилтийн хувь доогуур үзүүлэлттэй байсан байна. Дотоодын шилжилт хөдөлгөөний нөлөөллийн улмаас хүүхдүүдийн боловсрол эзэмших боломжууд хууль ёсны эрх нь тогтворгүй байхаас эхлээд ядуурал, засгийн газрын зүгээс зохих анхаарал тавихгүй байх, эсвэл гадуурхалт болон хуучинсаг хэвшмэл ойлголт, хандлага зэрэг шалтгааны улмаас хүссэн хэмжээнд олдохгүй байх талтай.

ДОТООДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ НЬ БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖИД НӨЛӨӨЛДӨГ

Олон улс оронд хотжилтын тогтворгүй байдал, хот хөдөөгийн тэнцвэрт бус байдал үүсэхээс болгоомжлон шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тавьснаар зарим тохиолдолд шилжин суурьшигчдыг боловсролын үйлчилгээнд хамрагдахад бэрхшээл учруулж байна. Вьетнамын хо-хау тогтолцоо нь шилжин суурьшигчдын улсын сургуульд суралцах эрхийг хязгаарласан бөгөөд хөдөөнөөс хотыг зорьсон ядуу иргэд үйлчилгээний чанар муутай улсын сургууль бүхий газарт очиж суурьшдаг. Саяхны шинэчлэлээр эдгээр хязгаарлалтуудыг хүчингүй болгосон ч өмнөх бодлогын улбаа нь түр зуурын оршин суугчийн статустай шилжин суурьшигчдын хувьд боловсрол эзэмших боломжийг алдагдуулсан хэвээр байна.

Хятадын хүкоү бүртгэлийн системийн дагуу иргэд бүртгэлтэй төрсөн газартаа нийгмийн үйлчилгээнд хамрагдах ёстой тул хөдөө орон нутгаас шилжин ирсэн өрхийн хүүхдүүд улсын сургуульд хамрагдах боломжгүй байсан. Харин сүүлийн жилүүдэд хууль журамд чухал өөрчлөлтүүдийг оруулсан байна. 2006 онд засгийн газраас орон нутгийн удирдлагуудад шилжин ирж буй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах үүрэг өгсөн бол 2008 онд хөдөө орон нутгаас шилжин ирсэн хүүхдүүдийг улсын сургуульд үнэ төлбөргүй суралцуулах шийдвэр гаргажээ. 2014 онд оршин суугаа газрын бүртгэл болон нийгмийн үйлчилгээнд хамрагдах асуудлыг салангид байдлаар шийдвэрлэхээр болж, 2016 оноос хойш ихэнх томоохон хотоос бусад бүх газарт хязгаарлалтуудыг улам багасгахыг зөвлөсөн байна.

Гэсэн хэдий ч шилжин суурьшигчдын хувьд боловсролын үйлчилгээнд хамрагдахад нь бэрхшээл тулгарсан хэвээр байна. Бичиг цаас бүрдүүлэх болон сургуульд хамрагдахтай холбоотой бусад шаардлага нь боловсролын хүртээмжийг хязгаарлах талтай. Бээжин хотод шилжин ирэгсэд улсын сургуульд элсэн суралцахын тулд таван гэрчилгээтэй байх шаардлагатай. Багш нар шилжин ирсэн хүүхдүүдэд ялгавартай ханддаг бөгөөд шилжин ирсэн хүүхдүүдийн ихэвчлэн суралцдаг албан ёсны зөвшөөрөлгүй сургуулийн багш нар цалин бага авдаг бөгөөд тэдэнд ажлын баталгаа байхгүй төдийгүй эцэг эхчүүд эдгээр сургуулиуд дахь багш нарын чанарын талаар үргэлж гомдол гаргадаг байна.

ҮЛДЭЖ ХОЦОРСОН ХҮҮХДҮҮД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД БЭРХШЭЭЛТЭЙ ТУЛГАРДАГ

Шилжилт хөдөлгөөн нь эцэг эхийн аль нэг эсвэл гэр бүлийн бусад гишүүдтэй үлдсэн олон сая хүүхдийн боловсролд нөлөө үзүүлж байна. Камбоджид эцэг эхээсээ тусдаа үлдсэн хүүхдүүд, ялангуяа охидын хувьд сургуулиас завсардах магадлал өндөр байна.

Хятад улсын 2015 оны Гэр бүлийн хөгжлийн тайланд хөдөө орон нутагт эцэг эхээсээ тусгаарлагдан үлдсэн хүүхдүүд 35%-тай байгаа тухай дурджээ. Эдгээр хүүхдүүдийн сайн сайхан байдал болон боловсролд үзүүлэх шилжилт хөдөлгөөний үр нөлөөний талаарх баримтууд олон янз байна. Зарим судалгаа хүүхдүүдийн сурлагын амжилтад эерэг нөлөөтэй байгааг харуулж байхад зарим нь эдгээр хүүхдүүдийн хувьд үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад сурлагын амжилт доогуур бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал илүү их байгааг харуулж байна.

2016 оноос Хятад улс эцэг эхээсээ тусгаарлагдан үлдсэн хүүхдүүдийн халамж асаргааг сайжруулахад чиглэсэн бодлого журмуудыг хэрэгжүүлж эхэлсэн ба тэдгээрийн хүрээнд орон нутгийн засаг захиргаанаас эцэг эхчүүдийг хүүхдүүдээ асран хамгаалагчтай үлдээх шаардлага тавихыг уриалсан. Эдгээр хүүхдүүдийг дотуур байртай сургуулиудад суралцуулах нь үндсэн стратеги болох хэдий ч тэдгээр нь боловсон хүчин дутмаг, тоног төхөөрөмж

“ 2012 онд ойролцоогоор 17.2 сая 5-17 насны хүүхэд ажил олгогчийн гэрт цалинтай эсвэл цалингүй гэрийн ажил эрхэлж байсны гуравны хоёр нь охид байжээ.

муутай байдаг. Хүүхдүүдийн сайн сайхан байдлыг сайжруулахад удирдах ажилтнуудад удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээрх сургалт шаардлагатай байна.

Дотуур байртай сургуулиуд зарим оронд түгээмэл байдаг ч эдгээр сургууль болон сурагчдын талаарх статистик мэдээлэл дутмаг байдаг. Уганда улсад 13 хүртэлх насны дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн эзлэх хэмжээ 15%-тай байхад ахлах сургуулийн сүүлийн жилүүдэд энэ нь 40% хүртэл нэмэгддэг байна.

УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН БОЛОВСРОЛЫН БОЛОМЖУУДАД НӨЛӨӨЛДӨГ

Ядуу иргэдийн хувьд амьдрах стратеги нь болсон улирлын чанартай шилжилт хөдөлгөөн нь боловсрол эзэмших үйл явцыг саатуулж, хүүхдүүдийг хөдөлмөр эрхлэх болон ажлын байран дээрх болзошгүй аюул эрсдэлд өртөхөд хүргэж болзошгүй. Энэтхэг улсын долоон хотын хувьд түр шилжин суурьшиж буй хүүхдүүдийн 80% нь ажлын байрныхаа ойролцоо сургуульд хамрагдах боломжгүй бөгөөд 40% нь хөдөлмөр эрхлэх явцад хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байсан талаар судалгаа харуулж байна. Энэтхэг улсын үндэсний засгийн газрын саяхны санаачлагаар шилжин суурьшиж буй хүүхдүүдийг сургуульд хамруулахын тулд элсэлтийг уян хатан байлгах, нүүдлийн боловсролын үйлчилгээ үзүүлэх, шилжүүлэн явуулж буй болон хүлээн авч буй муж улсуудын хоорондын зохицуулалтыг сайжруулах зэргээр дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч хэрэгжилтэд олон тооны сорилт бэрхшээл тулгарсаар байна. 2010-2011 онд Ражастан мужийн тоосго шатаах үйлдвэрт хэрэгжүүлсэн түршилтын хөтөлбөрийн явцад багш нар

болон суралцагчид олноороо хичээл тасалж байсан нь заах болон сурах нөхцөл боломж муу бөгөөд сурагчид хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагатай байсантай холбоотой нь харагджээ.

ДОТООДОО ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ХҮҮХДҮҮД БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ХАСАГДАХ ЭРСДЭЛД ӨРТӨМТГИЙ БАЙДАГ

2012 онд ойролцоогоор 17.2 сая 5-17 насны хүүхэд ажил олгогчийн гэрт цалинтай эсвэл цалингүй гэрийн ажил эрхэлж байсны гуравны хоёр нь охид байжээ. Залуу охид, тухайлбал Перу улсын Лима хотод гэрийн ажил хийхийг хөдөөг орхиж, боловсрол эзэмших арга зам хэмээн үздэг ч тэд ажлын ачааллын улмаас боловсрол эзэмшиж чадахгүйд хүрдэг байна.

Африкийн олон улс оронд түгээмэл байдаг стратеги нь хүүхдийг түр үрчлэн авч халамжлах асралт гэр бүлийн үйлчилгээ юм. Сенегаль улсад хүүхдүүдийн ойролцоогоор 10% нь асралт гэр бүлийн үйлчилгээнд хамрагдаж байжээ. Хөвгүүд боловсролд анхаарал ихээр хандуулдаг өрхүүдэд хуваарилагдах магадлалтай бөгөөд ах, эгч, дүү нараасаа илүү боловсрол эзэмшиж байхад охид хүлээн авч буй айлын гэрийн ажлыг хийх магадлал дөрөв дахин өндөр бөгөөд боловсролын зорилгоор асралт гэр бүлийн үйлчилгээнд хамрагдах нь харьцангуй бага байжээ.

НҮҮДЭЛЧИД, МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭНД АНХААРАЛ ХАНДУУЛАХГҮЙ БАЙНА

Нүүдэл суудал нь нүүдэлчид, малчдын амьдралын өвлөн уламжлагдсан бодит хэсэг бөгөөд тэдэнд чиглэсэн аливаа үйл ажиллагаа нь тэдний эрэлт хэрэгцээг тусгасан байх шаардлагатай. Эдгээр өрхийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалт бага бөгөөд улирлын онцлогоос шалтгаалан хэлбэлзэж, тэднийг үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад бичиг үсэг болон тоо тооллын чадвараа хөгжүүлэхэд бэрхшээлтэй тулгарах хандлагатай байдаг. Монгол улсад малчдын хүүхдүүдийг сургадаг сумын дотуур байртай сургуулиудын санхүүжилт хангалтгүй байдгаас үүдэн үйл ажиллагаа нь суларч, улмаар малчин болон малчин бус өрхийн хүүхдүүдийн сурлагын амжилтад ялгаа бий болсон.

Нүүдэлчин, малчин хүн ам олонтой олон улс орон засгийн газартаа тусгайлсан газар, хороо эсвэл зөвлөлийг ажиллуулдаг. Тухайлбал, Судан улсад Нүүдэлчдийн боловсрол хариуцсан газар байдаг. Эдгээр байгууллагын үйл ажиллагаа нь боловсролын үйлчилгээг улирлын онцлог, нүүдлийн амьдрал ахуйд нийцүүлэхэд чиглэдэг бөгөөд суурин болон хөдөлгөөнт сургуулиудыг ажиллуулдаг нь зарим жишээ юм.

Нигерийн хойд хэсэгт амьдардаг алмажири хэмээн нэрлэгддэг исламын шашны мэдлэгтэй олон тооны шилжин суурьшигч суралцагчид бол нүүдэлчин малчид юм. Кано мужид 700 уламжлалт багш нарт чиглэн үйл ажиллагааны хүрээнд эдгээр хүмүүстэй хамтран шашны бус хичээл заах багш нарыг сонгох зэрэг ажлыг хэрэгжүүлжээ.

Суралцагчид хэзээ ч, хаана ч нэг сургуулиас гарч, нөгөө сургуульд суралцаж болох сургуулиудын сүлжээ нь хэрэгжүүлж болохуйц шийдэл хэдий ч суралцагчдын шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цаг алдалгүй хийдэг үр дүнтэй бүртгэлийн систем шаардлагатай. Кени, Сомали зэрэг зарим орон багш нарыг нүүдэлчидтэй хамт нүүдэллэж, боловсролын үйлчилгээ үзүүлэх явуулын багшаар ажиллуулж эхлээд байна.

Нүүдэлчин хүн амд чиглэсэн боловсролын үйлчилгээ нь тэдний амьдралын хэв маягийг сайтар ойлгон, хүндэтгэсэн байдлаар тэдэнд хүрэх ёстой. Нүүдлийн амьдралын хэв маягт нийцүүлсэн техник, мэргэжлийн боловсрол нь нүүдэлчдэд илүү тохиромжтой байх талтай. НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага нь Джибути, Этиоп, Кени, Өмнөд Судан болон Уганда улсад 2012 оноос мал аж ахуйн чиглэлийн сургуулиудад суралцаж буй нүүдэлчин иргэдтэй мал аж ахуйн менежментийн үр ашиг болон цаг уурын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

НУТГИЙН УУГУУЛ ИРГЭД ХОТ СУУРИН ГАЗАР ОНЦЛОГ ШИНЖ БАЙДЛАА ХАДГАЛАХАД БЭРХШЭЭЛТЭЙ ТУЛГАРЧ БАЙНА

Олон газарт нутгийн уугуул иргэдэд чиглэсэн боловсролын үйлчилгээ нь сургуульд олгох боловсролоор дамжуулан тэднийг хүчээр үүсгах бодлогыг хэрэгжүүлсээр ирсэн. Энэхүү хуучны тогтолцоо нь ядуурал, хот суурин газар луу чиглэсэн шилжилт хөдөлгөөнтэй хамт соёл устан алга болох, хэл мартагдах байдал болон ялгаварлан гадуурхалтад хүргэж байна. Эквадор, Мексик болон Перу улсын хот суурин газар дахь залуу үеийнхэн хөдөө орон нутаг дахь үе

тэнгийнхэнтэй нь харьцуулахад уугуул хэлээрээ ярих нь үлэмж багасжээ.

Уугуул иргэдийн эрхийн талаарх зохицуулалтын тогтолцоо нь хот суурин газарт амьдардаг уугуул иргэдэд хамаарал багатай байдаг. Канад улсын уугуул иргэдийн 50 гаруй хувь нь хот суурин газар амьдардаг. Хот суурин газарт амьдардаг нутгийн уугуул хүн амд хийсэн дүн шинжилгээ нь боловсрол нь тэдний амьдралын чанарыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг илтгэн харуулж, соёлын хувьд тохиромжтой сургалтын хөтөлбөр, практик үйл ажиллагаа нь сургуулийн өмнөх боловсролын үр дүнг сайжруулж байгааг олж тогтоосон байна.

Шилжилт хөдөлгөөн нь хот, тосгодын боловсролын бодлого төлөвлөгчдөд бэрхшээл учруулдаг

Хөдөө орон нутгийн хүн ам цөөрснөөр ялангуяа, өндөр орлоготой улс орнуудад боловсролын бодлого төлөвлөгчид санхүүгийн нөөцийн үр ашигтай хуваарилалтыг шилжин суурьшилтын нөлөөнд өртсөн хүн амын сайн сайхан байдалтай тэнцвэржүүлэх шаардлагатай тулгардаг. 1990-2015 онуудад Финлянд улс 50 хүртэлх суралцагчтай сургуулиудын 80% (нийт 1600 гаруй сургууль)-ийг хаах эсвэл нэгтгэх арга хэмжээ хэрэгжүүлсэн. Хотжилт болон төрөлт буурсан явдал нь дунд орлоготой орнуудын хувьд ижил төстэй бэрхшээлүүдийг бий болгож байна. Оросын Холбооны Улсын хөдөө орон нутгийн сургуулиудын тоо 2000-2015 онд 45,000-аас 26,000 хүртэл буурчээ. Хятад улсад хөдөөний бага сургуулиуд 2000-2010 онд 52%-аар буурсан байна.

Засгийн газрууд санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулиудыг нэгтгэх асуудлуудыг авч үзэхдээ эдгээр сургуулиудын олон нийтэд гүйцэтгэх үүрэг, бусад үр нөлөөг зайлшгүй тодорхойлох нь зүйтэй. 2015 оны ПИСА олон улсын суралцагчдын үнэлгээний хөтөлбөр (ПИСА/PISA)-ийн тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээ нь жижиг сургуулиудын суралцагчид сахилга бат, хичээлд хоцрох болон хичээл таслах асуудлууд бага гаргадгийг харуулжээ. Сургуулиудыг нэгтгэх ажлыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд холбогдох бүх талтай зөвлөлдөх болон зардлын асуудлыг авч үзэх шаардлагатай. Литвийн Засгийн газар хөдөөгийн жижиг бага сургуулиудыг хэвээр үлдээх эн тэргүүний арга хэмжээнүүдийг тодорхойлж, сургуулиудын аюулгүй тээвэрлэлтэд зориулан хэдэн зуун шинэ автобусыг нийлүүлжээ.

Зарим орнуудад хөдөөгийн сургуулиудыг бэхжүүлэх зорилгоор хөрөнгө нөөцийг хамтран хэрэглэж, сургалтын үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхийг дэмждэг. Чили улсад хөдөөгийн багш нарыг уулзаж, нийтлэг бэрхшээлүүдээ ярилцан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх 374 бичил мэдээллийн төвийг ажиллуулдаг. 2011 оноос хойш Хятадын Засгийн газар хөдөөгийн жижиг сургуулиудын үндсэн засвар, шинэчлэлд оролцох болсны зэрэгцээ төрийн бус

байгууллагууд (ТББ), орон нутгийн иргэд болон сургуулиуд мэдээлэл, нөөцөө хуваалцах сүлжээг байгуулсан.

ЯДУУСЫН ХОРООЛОЛ ДАХЬ ЦАГААЧДАД БОЛОВСРОЛЫН БОЛОМЖ ХОМС БАЙДАГ

Дор хаяж 800 сая хүн ядуусын хороололд амьдарч байна. Үндэсний статистик, тооцооллын аргачлалууд энэхүү тоог багаар тооцоолсон байж магадгүй. Ядуусын хорооллын олон оршин суугч хөдөөнөөс хот руу шилжин ирэгсэд бөгөөд тэд боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна. Ядуусын хорооллын оршин суугчдыг албадан нүүлгэх, нүүлгэн суурьшуулах нь сургууль завсардалтын түвшинг нэмэгдүүлж, хичээлийн ирцийг бууруулдаг. 2016 онд Бангладеш улсад ядуусын хорооллын сургууль завсардсан дунд сургуулийн насны өсвөр насныхны хувь хот суурин газрын бусад дүүргийнхээс хоёр дахин өндөр байсан.

Хотжилтын талаарх хэлэлцүүлэг мэтгэлцээн нь орон байр, ус хангамж, эрүүл ахуйн бэрхшээлтэй асуудлуудад голчлон анхаарал хандуулдаг тул ядуусын хороолол дахь боловсролын үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулахыг эн тэргүүний зорилго гэж тодорхойлдоггүй. Ядуусын хорооллын оршин суугчдын төлөөх олон улсын сүлжээ нь 30 гаруй улс оронд мэдээлэл цуглуулдаг боловч боловсролын чиглэлээрх мэдээлэл хязгаарлагдмал байна.

Улсын сургуулиуд дутмаг газарт байгуулагдсан хувийн сургуулиуд бүртгэлгүй байдаг нь ядуусын хороолол дахь боловсролын үйл ажиллагааг дутуу тооцоолоход нөлөөлж магадгүй. Кенийн Кибера дүүрэгт албан ёсны мэдээллээр 100 сургууль бүртгэлтэй байдаг бол нээлттэй зураглалын төслийн хүрээнд 330 сургуулийг олж тогтоосон байна. Ядуусын хороолол дахь цорын ганц хувилбар болох хувийн сургуулиуд хууль эрх зүйн хувьд зохицуулалт муу бөгөөд мэргэшээгүй багш, ажилтнуудыг ажиллуулдаг байна. Найроби хотын ядуусын хороолол дахь багш нарын чанарыг сайжруулах санаачлагын үр дүнд суралцагчдын бичиг үсэгт тайлагдалт болон тоо тооллын чадвар сайжирчээ.

Боловсрол нь хотжилтын талаарх мэтгэлцээний хүрээнд ядуусын хорооллын хувьд эн тэргүүнд авч үзэх асуудал байх ёстой. Өөрсдийн эзэмшлийн бус газар нутагт шилжин ирж суурьшиж буй иргэдэд зориулан боловсролын дэд бүтэц байгуулахад засгийн газрууд ихэвчлэн хөрөнгө оруулах хүсэлгүй байдаг тул тэдний оршин суух эрхийг баталгаажуулах болон бусад эрхийг хамгаалах нь тэднийг боловсролын үйлчилгээнд хамруулахад чиглэсэн үндсэн алхам болж байна. Аргентин улсад шилжин суурьшигчдад газар эзэмших эрх олгосон явдал нь урт хугацаанд боловсролын хувьд сайн үр дүнд хүргэсэн байна.

Бүртгэл, баримт бичигт тавигдах хатуу чанд шаардлагууд нь шилжин суурьшигчдын боловсролд үр өгөөж өгөх боломжтой нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд хамрагдахад саад болдог. Кени улсын ядуусын хороололд хот суурин газрын нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдахын тулд иргэний баримт бичиг шаарддаг. Үүний улмаас Кенийн иргэн гэдгээ нотлох боломжгүй эсвэл хүүхэд толгойлсон өрхийн урьдчилсан сонгогдсон дүрвэгчдийн 5% нь тус хөтөлбөрт хамрагдах боломжгүй болжээ.

Олон улсын шилжилт хөдөлгөөн


Иргэд ажил, амьдралын илүү сайн боломжуудыг эрэлхийлэн шилжин суурьшигдаа шинэ тогтолцоонд дасан зохицох, хууль эрх зүй болон захиргааны шинжтэй саад бэрхшээлүүд, хэлний бэрхшээл болон болзошгүй ялгаварлан гадуурхалтыг даван туулах шаардлагатай болдог. Цагаачид, шилжин суурьшигчдыг хүлээн авагч орнуудын боловсролын тогтолцоо нь шинээр ирэгсдийг хамруулахад шаардлагатай нэмэлт зардлуудыг шийдвэрлэх асуудалтай тулгардаг.

2017 онд 258 сая олон улсын шилжин суурьшигч байсан нь дэлхийн хүн амын 3.4%-ийг эзэлж байна. Тэдний ойролцоогоор 64% нь өндөр орлоготой орнуудад амьдарч байсан бөгөөд тэдгээр орнуудад 2000 онд цагаач иргэд нийт хүн амын 10%-ийг эзэлж байсан нь 2017 онд 14% болж өсчээ. Кувейт, Катар болон Арабын Нэгдсэн Эмират зэрэг Персийн булангийн улс орнуудад цагаачид нийгмийн томоохон бүлгийг бүрдүүлдэг.

Коста Рика, Кот-д’Ивуар, Малайз, Өмнөд Африк зэрэг дундаж орлоготой орнуудад цагаачдын эзлэх хувь дэлхийн дунджаас хоёроос гурав дахин өндөр байна. Эсрэгээр гадагшаа цагаачлагч иргэдийн хувь нь хүн амынхаа 5%-аас дээш түвшинд байгаа улс орнуудад Албани, Гүрж, Ямаик, Киргизстан, Никарагуа багтаж байна. Цагаачдын хамгийн том бүлэг нь Мексикээс АНУ-ыг зорьсон иргэд бөгөөд удаах нь зүүн Европоос баруун Европ, хойд Африкаас өмнөд Европ, өмнөд Азиас Персийн буланг зорьсон цагаачдын бүлгүүд байна.

ЗУРАГ 2:

ЭЗХАХБ-ын гишүүн ихэнх оронд 15 настай таван суралцагч тутмын нэг нь цагаачдын нэг буюу хоёрдугаар үеийнхэн байна. 15 настай суралцагчдын тархалт гарал үүслээр, сонгогдсон улс орноор, 2015 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig3_4

Тэмдэглэл: Тус зурагт тоо мэдээлэл бүхий боловч цагаач гэр бүлээс гаралтай суралцагчийн хувь өндөртэй дараахь таван орон, онцгой бүсийг хамруулаагүй: БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонконг, Люксембург, Хятадын Макао, Катар, Арабын Нэгдсэн Эмират Улс.

Эх сурвалж: БХШД-ийн тайлангийн багийн дүн шинжилгээ нь 2006, 2015 оны ПИСА (PISA), 2015 оны ТИМСС (TIMSS) судалгаанд үндэслэсэн.

2015 оны байдлаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудад 15 настай суралцагчдын дор хаяж тавны нэг нь цагаач эсвэл цагаач гэр бүлээс гаралтай байжээ (Зураг 2). Тус тайланд ашигласан тоон мэдээллээр өндөр орлоготой орнуудын дунд сургуулийн 80%-д цагаач гэр бүлээс гаралтай суралцагчид хамгийн багадаа 5%, сургуулиудын 52%-д нь цагаач гаралтай сурагчид дор хаяж 15%-ийг эзэлж байжээ

Шилжилт хөдөлгөөн боловсролд нөлөөлөхийн зэрэгцээ түүний үр нөлөөнд мөн ордог

“

2000 онд олон улсын түвшинд цагаачлалын үзүүлэлт дээд боловсролтой иргэдийн хувьд 5.4%, дунд боловсролтой иргэдийн хувьд 1.8% ба бага боловсролтой иргэдийн хувьд 1.1% байсан байна.

Шилжин суурьшигчид бол санаандгүй сонгосон хүн амын бүлэг биш. Цагаач бус иргэдтэй харьцуулахад тэд боловсрол өндөртэй байгаа нь тэдэнд илүү мэдээлэл хүртэх, эдийн засгийн боломжуудад хариу үйлдэл үзүүлэх, үр чадвараа хөрвүүлэн ашиглах, цагаачлахдаа хөрөнгө мөнгө зарцуулах зэрэг бололцоог олгодог. 2000 онд олон улсын түвшинд цагаачлалын үзүүлэлт дээд боловсролтой иргэдийн хувьд 5.4%, дунд боловсролтой иргэдийн хувьд 1.8% ба бага боловсролтой иргэдийн хувьд 1.1% байсан байна.

”

Цагаачлах үе дэх боловсрол эзэмшсэн байдал нь цагаачид хил нэвтрэх үеийн нөхцөл байдлаас мөн хамаардаг байна: АНУ дахь Эль Сальвадор, Гаити, Мексик болон Никарагуа улсаас ирсэн бичиг баримтгүй цагаачид түр зуурын гэрээтэй иргэдтэй харьцуулахад дунджаар өндөр боловсролтой боловч албан ёсны оршин суугч иргэдтэй харьцуулахад боловсролын түвшин доогуур байсан байна.

Боловсрол эзэмших болон боловсролын амжилтад цагаачлалын үзүүлэх үр нөлөөг ойлгоход үндсэн хоёр харьцуулалтыг авч үздэг. Эхнийх нь цагаачилсан болон цагаачлаагүй иргэдийн хооронд хийх харьцуулалт боловч эдгээр бүлгүүд цагаачлах шийдвэрээс өөр олон зүйлээр ялгаатай (тухайлбал, гадагшаа цагаачилсан иргэд эх орондоо үлдсэн бол илүү өндөр боловсролтой болох боломжтой байх магадлалтай). Хоёр дахь нь цагаачид болон нутгийн уугуул иргэдийн харьцуулалт боловч тэд цагаачлалын статусаас гадна өөр олон зүйлээр ялгаатай. Зарим тохиолдолд тодорхой цагаачлалын бодлого журмуудын хүрээнд авч үзэхэд цагаач иргэд нутгийн уугуул иргэдээс өндөр боловсролтой хэмээн ойлгогдох талтай; харин бусад тохиолдолд цагаачид чанар муутай сургуулиуд бүхий ядуу дүүрэгт амьдарч байгаа нь тэдний үр хүүхдүүдийн боловсролд хамрагдах болон үзүүлэх амжилт нь тааруу байх хүчин зүйл болдог.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН НЬ АРД ҮЛДЭЖ ХОЦРОГСДЫН БОЛОВСРОЛД НӨЛӨӨЛДӨГ

Шилжин ирэгсэд ихэвчлэн үр хүүхдээ ар гэртээ үлдээдэг. Филиппин улсад ойролцоогоор 1.5 саяас 3 сая хүртэлх хүүхдийн дор хаяж аав, ээжийнх нь нэг цагаач байдаг байна. Цагаач иргэдийн ар гэртээ илгээдэг мөнгөн гуйвуулгын боловсрол дахь нөлөө нь шийдвэрлэх ач холбогдолтой байж болох талтай.

2017 онд дэлхий нийтэд айл өрхүүд 613 тэрбум ам.долларыг олон улсын мөнгөн гуйвуулгаар хүлээж авсан бөгөөд үүний 466 тэрбум ам.долларыг бага, дунд орлоготой улс орнуудын өрхүүд хүлээн авсан нь албан ёсны хөгжлийн тусламжийн хэмжээнээс гурав дахин их юм. Энэтхэг болон Хятад улс бодит дүнгээр хамгийн өндөр мөнгөн гуйвуулга хүлээж авсан боловч Киргизстан болон Тонга улс энэ төрлийн мөнгөн гуйвуулгын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар тэргүүлж байна.

Онолын хувьд мөнгөн гуйвуулга нь боловсролд эерэг болон сөрөг үр нөлөөтэй. Орлогын эх үүсвэрийн төрлийн нэмэгдүүлэх нь үр ашгаа даатгасантай адил боломж бий олгодог: айл өрхүүд боловсролд зориулах зардлаа танах магадлал бага болдог. Гэвч нэмэлт орлого өрхийн зарцуулалтыг нэмэгдүүлдэг хэдий ч боловсрол нь бусад зардлуудтай өрсөлдөж, хүүхдүүд гэр бүлийн цагаачилсан гишүүдийн хөдөлмөрийг орлоход хүрч, эцэг эхийн хувь

нэмэр, оролцоо дутагдах нь боловсролд саад учруулдаг. Гадаадад бага, дунд түвшний чадвар шаарддаг хөдөлмөр эрхэлсэн ч өндөр ашигтай ажилладаг тул мөнгөн шилжүүлэг нь боловсролын түвшнээ нэмэгдүүлэх шаардлагагүй байдлыг өөгшүүлсэн 'цагаачлалын соёл'-ыг бий болгоход хүргэх үр дагавартай.

Бодит амьдрал дээр олон улсын мөнгөн шилжүүлэг нь өрхийн боловсролд зориулсан зардлыг дунджаар 35%-аар нэмэгдүүлсэн талаар Сахар орчмын Африк, Төв, Өмнөд болон Зүүн өмнөд Азийн 18 улс оронд хийсэн цогц судалгаа харуулж байна. Мөнгөн шилжүүлгийн үр нөлөө нь Латин Америкт улам өндөр байсан байна (53%).

ТХЗ-ын хүрэх үр дүн 10.в-д мөнгөн гуйвуулгын шилжүүлгийн шимтгэлийг дунджаар 3%-аас доогуур байлгахыг уриалсан. Энэ нь одоогийн дунджаар 7.1% байна. Уламжлалт банкуудын шилжүүлгийн шимтгэл 11% буюу хамгийн өндөр байгаа бөгөөд Африкийн зарим дамжуулагч байгууллагууд 20%-аас ч дээш шимтгэл авдаг. Өрхийн боловсролд зориулах зардлыг өрхийн нийт зардлын 4% гэж үзвэл шилжүүлгийн шимтгэлийг 3% хүртэл бууруулах нь өрхүүд жилд 1 тэрбум ам.долларыг боловсролд нэмж зарцуулах боломжийг олгоно.

Цагаачид ар гэртээ шилжүүлэх мөнгөн гуйвуулгын шимтгэлийг



Мөнгөн гуйвуулгын боловсролд үзүүлэх ерөнхий үр нөлөө нь эерэг байдаг талаар хэд хэдэн судалгааны үр дүн харуулж байна. Филиппин улсад олон улсын мөнгөн гуйвуулга 10%-аар нэмэгдэхэд сурагчдын ирц арваас дээш хувиар нэмэгдэж, хүүхдийн хөдөлмөр долоо хоногт гурваас илүү цагаар буурсан байна. Мөн үр нөлөө нь хүйсийн хувьд ялгаатай байна. Йордан улсад мөнгөн гуйвуулга нь заавал эзэмших боловсролын дараагийн шатанд хамрагдахад зөвхөн эрэгтэйчүүдийн хувьд эерэг нөлөөтэй байжээ.

Эерэг үр дүн ялангуяа, цагаачдын онцлог нөхцөл байдал тухайлбал, боловсролын хамрагдалт бага нөхцөл байдалтай хамааралтай гарсан байж болох юм. Ур чадварын хувьд доогуур ангилал бүхий цагаачдын хувьд шилжин суурьшилт нь боловсролын эцсийн үр дүнд сөрөг нөлөөтэй талаар баримтууд мөн бий. Гватемала улсад олон улсын мөнгөн шилжүүлгийн дүнд сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн сурлагын үзүүлэлтүүд сайжирсан хэдий ч сургуульд хамрагдалт ихээхэн буурсан хэмээн үзжээ. Мексикийн хөдөө орон нутагт эцэг эхээсээ тусдаа үлдсэн сурагчдын хувьд мөнгөн шилжүүлгийн улмаас сурлагын амжилт нь буурсан байна.

ШИЛЖИН СУУРЬШИГЧИД ОЧСОН ОРОНДОО БОЛОВСРОЛЫН ХУВЬД ХОХИРОЛ АМСДАГ

Шилжин суурьшсан улс орнуудад цагаачид боловсрол эзэмшихээ эрт зогсоодог. 2017 онд Европын Холбооны улсуудад 18-24 насны үугуул иргэдийн 10%, гадаадад төрсөн иргэдийн 19% сургуулиа эрт орхисон байна. Сургууль завсардалт тухайн улсад шилжиж ирсэн үеийн наснаас шалтгаалахын зэрэгцээ суралцагчид заавал эзэмших боловсролын эхний, дунд эсвэл төгсөлтийн шатанд элсэн суралцсанаас шалтгаалан эцсийн үр дүн нь харилцан адилгүй байна. АНУ-д 7 насандаа ирсэн Мексикийн цагаачдын 40% нь дунд боловсролыг дүүргээгүй бол тус үзүүлэлт 14 насандаа ирсэн цагаачдын хувьд 70% байна.

Гэвч цагаачдын боловсролын байдал нь тухайн нутгийн иргэд болон улс орондоо үлдсэн иргэдтэй харьцуулахад маш хурдан сайжирдаг. Германд дунджаас доогуур боловсролтой эцэг эхтэй уугуул иргэд цагаач иргэдтэй харьцуулахад илүү удаан хугацаанд амжилт гаргасан байна. Латин Америк, Карибын 10 орноос 8-д нь цагаач иргэдийн хүүхдүүд цагаач бус эцэг эхийн хүүхдүүдтэй харьцуулахад боловсролын үйлчилгээнд дунджаар 1,4 жил илүү хамрагдсан байна.

Боловсролын амжилт дахь ялгаатай байдал нь үе дамжин үргэлжилж байна. 2015 оны ПИСА судалгаанаас харахад 15 настай сурагчдаас цагаачдын эхний үеийнхний 49%, хоёр дахь үеийнхний 61% нь үнших, математик болон байгалийн шинжлэх ухааны хичээлүүдэд хамгийн багадаа хоёрдугаар түвшинд байсан бол уугуул иргэдийн 72% нь ийм түвшинд хүрсэн байна. Канад, Герман, Итали улсад уугуул иргэд нь цагаачдын хоёр дахь үеийнхэнтэй харьцуулахад ялангуяа дээд боловсролын түвшинд илүү олноор суралцаж байна.

Зургаан орон дахь Турк цагаачдын хоёр дахь үеийг харьцуулахад Герман улс дахь цагаачдын ердөө 5%, Франц дахь цагаачдын 37% нь их, дээд сургуульд суралцаж байв. Франц улс дахь тогтсон хүчин зүйлс тухайлбал, сургуулийн өмнөх боловсролд эрт хамрагддаг, дунд сургуульд сурагчдыг чадварын ангиллаар нилээн сүүлд хуваарилдаг, чадварын ангилал доогуур суралцагчид ч дээд боловсролд хамрагдах боломжтой зэрэг нь дээрх том ялгааг тайлбарлахад дөхөмтэй юм.

Цагаачид нийгэм, эдийн засгийн хувьд доогуур статустай байгаа нь ЭЗХАХБ дахь цагаачдын суралцахуйн ялгаатай байдлын 20%-ийг тайлбарлаж байна; харин Франц, Грек зэрэг зарим оронд энэ нь 10 орчим хувь байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын цагаач суралцагчид уугуул иргэдтэй харьцуулахад анги улирах нь хоёр дахин их байна.

Цагаачлал болон иргэншлийн талаарх бодлогууд нь сургуульд суралцахад саад учруулдаг

Боловсрол эзэмших эрх, үл ялгаварлан гадуурхах талаарх ерөнхий зарчмуудыг Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Талаарх Олон Улсын Гэрээ болон Хүүхдийн Эрхийн Конвенцид тус тус баталгаажуулсан байдаг. Шилжилт хөдөлгөөний талаарх тусгайлсан олон улсын гэрээнд цагаач, дүрвэгчдэд боловсролын хувьд тухайн улсын иргэний адил хандахыг уриалдаг бөгөөд өнөөгийн байдлаар бараг бүх улс цагаачдыг илгээдэг ч дөрвөн улс тутмын ердөө нэг нь энэхүү гэрээг соёрхон баталсан байна. Бодит амьдрал дээр хязгаарлалт бүхий цагаачлалын бодлогууд, уялдаагүй хууль, дүрэм, журмууд болон хүлээн авагч улсын баримт бичгийн талаарх чанд хатуу шаардлагууд нь энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулдаг.

Хятад, Грек зэрэг зарим улсын үндсэн хуульд иргэдийн боловсрол эзэмших эрхийг хязгаарласан байдаг. Зарим улсын үндэсний хэмжээний хуулиудад үндсэн хуулиар баталгаажуулсан боловсрол эзэмших эрхийг үл ойшоосон байдаг. Кипр болон Словак улсад сургуулиуд хүчин төгөлдөр баримт бичиггүй гэр бүлүүдийг цагаачлалын албанд мэдэгдэх үүрэг хүлээсэн байдаг. Өмнөд Африкт 2002 онд баталсан цагаачлалын хуулиар баримт бичиггүй цагаачдыг сургуульд элсэн суралцахыг хориглосон байдаг.

Гадаадад төрсөн хүн амын боловсрол эзэмших эрхийг баталгаажуулсан хууль эрх зүй нь боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлдэг. Аргентин улсад 2006 оны Үндэсний Боловсролын Хуулиар бүх оршин суугчдын боловсрол эзэмших эрхийг баталгаажуулсан байдаг. Словак улсын бага боловсролын хуулиар аливаа улсын харьяалалгүй иргэдийн боловсрол эзэмших эрхийг шууд хүлээн зөвшөөрсөн байдаг.

Тэгш хамруулалтыг дэмжсэн хууль эрх зүйн хүрээ нь бүс нутгийн эсвэл орон нутгийн түвшин дэх ялгаварлан гадуурхал бүхий бодит үйл ажиллагаанаас зайлшгүй урьдчилан сэргийлэх боломжгүй байдаг. Сургуулиуд төрсний гэрчилгээ, өмнө нь эзэмшсэн боловсролын талаарх тодорхойлолт, улсын бүртгэлийн баримт бичиг эсвэл оршин сууж буй газрын тодорхойлолт зэргийг хүүхдүүдийг сургуульд элсүүлэхдээ шаарддаг. 2010 онд 5000 байсан Гаитигийн цагаачдын тоо 2017 онд 105,000 болтол нэмэгдсэн Чили улсад бодлого журмын дагуу бүх хүүхэд улсын сургуульд

үнэ төлбөргүй хамрагдах ёстой ч бодит амьдрал дээр сургуульд суралцуулах эсэхийг орон нутгийн засаг захиргааны ажилтнууд шийдвэрлэдэг. Узбекистан улсын сургуулийн удирдлагууд хүүхдийг сургуульд элсүүлэхийн өмнө оршин суугаа газрын тодорхойлолт, үндэсний хэл дээрх паспорт эсвэл бусад баримт бичгийг ихэвчлэн шаарддаг.

Албан ёсоор тодруулга хийх нь сургуулийн ажилтнуудад хуулиар бүрэн баримт бичиг шаарддаггүй талаар ахин бататгасан мэдээлэл өгөх бөгөөд үндэсний хууль эрх зүйн хүчтэй тогтолцоо нь хувь иргэдэд гомдол мэдүүлэх боломжийг олгодог. 2014 онд Итали, Турк улс сургуульд элсэн суралцахад баримт бичиг заавал шаардахгүй байх тухай тайлбар гаргасан. Франц улсад сургуульд суралцуулах асуудлыг ялгаварлан гадуурхсан байдлаар шийдвэл эцэг эхчүүд байцаагч эсвэл шүүхэд хандаж өргөдөл гаргаж, залруулах арга хэмжээ авахыг шаардах боломжтой байдаг.

Өнөөг хүртэл бичиг баримтгүй цагаачид сургуульд элсэн суралцахад саад бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна. АНУ-д 2014 онд 11 сая цагаач хууль бусаар оршин сууж байсан бөгөөд хүчээр нутаг буцаах болзошгүй эрсдэлийн улмаас хүүхдүүдэд сургуульд суралцуулдаггүй байсан байж болзошгүй: 2017 оны 2 дугаар сард Нью Мексик мужийн сургуулиуд ихтэй Лас Крус хотод цагаачлалын гэнэтийн шалгалтын дараагаар хичээл таслалт 60%-аар нэмэгджээ. 2012 оны Цагаач Хүүхдүүдийг Хүндэтгэн Үзэх хөтөлбөрийн хүрээнд хүүхэд насандаа цагаачлан ирсэн бичиг баримтгүй 1.3 сая залуучуудад хүрч ажиллан, тэднийг хүчээр нутаг буцахаас хамгаалж, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгосон байна. Тус хөтөлбөрийн хүрээнд эдгээр залуучууд албан ёсны зөвшөөрөлтэй болсонтой холбогдуулан дунд сургууль төгсөлтийн жин 15%-аар нэмэгдсэн тооцоо гарчээ.

Асран хамгаалагчгүй насанд хүрээгүй цагаач иргэд мөлжлөгт өртөх эрсдэлтэй байдаг бөгөөд тэдний боловсролын хэрэгцээг ихэнх тохиолдолд хангаж чаддаггүй. Тэдний тоо дэлхий даяар 2010-2011 онд 66,000 байснаас 2015-2016 онд 300,000 болж өссөн. Австрали, Грек, Индонези, Малайз, Мексик, Науру болон Тайланд зэрэг улс дахь цагаачдын саатуулах байранд байрлаж буй хүүхэд, залуучуудад боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал эсвэл огт байдаггүй. 2011-2016 онд Итали улсад цагаачлан ирсэн 86,000 насанд хүрээгүй хүүхдүүдийн ойролцоогоор 73% нь асран хамгаалагчгүй байжээ. Тэдний эрхийг хамгаалах зорилгоор 2015, 2017 онуудад тусгай хууль, журам баталсан боловч тун цөөхөн хувь нь сургуульд тогтмол суралцаж байна.

Бичиг баримтгүйн улмаас дэлхий даяар ямар ч улсын харьяалалгүй 10 сая иргэд саад бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд тэдний зарим нь цагаачдын үр удам байна. Аль ч улсын харьяалалгүй 700,000 иргэд бүхий Кот-д'Ивуар улсад сургуульд ороход иргэншлийн нотолгоо шаарддаг. Үндэстний харьяалалгүй болсон хэдэн мянган Гаитигийн цагаачид бүхий Доминиканы Бүгд Найрамдах Улсад 2012 онд 6-13 насны хүүхдүүдийн бага боловсролын хамрагдалтын цэвэр жин Гаитид төрсөн хүүхдүүдийн хувьд 52%, өөр улсад төрсөн цагаачдын хувьд 82% байсан байна.

Боловсролын талаарх бодлогууд нь цагаачдын сургуульд хамрагдалтыг дэмжих боломжтой

Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан хөтөлбөрүүд, хэл сурахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд, суралцагчдыг чадвараар нь анги бүлэгт хуваарилах, сонгон суралцуулах болон тусад нь суралцуулах талаарх бодлого журмууд нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйлс билээ.

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрүүдэд цагаач хүүхдүүдийг хамруулснаар тэдний хувьд үндсэн суурь тавигддаг. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 15 настай цагаач сурагчийн унших чадварын оноо нь дунджаар сургуульд нэгээс илүү жил хамрагдсантай дүйцэх онооноос нэг оноогоор илүү байсан. Бичиг баримтгүй цагаачдын хувьд бага насны хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрт хамрагдах нь бэрхшээлтэй байх талтай: АНУ-д бичиг баримтгүй 3-4 насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нь бичиг баримттай цагаачид болон уугуул иргэдийнхээс доогуур байна.

Хэлний үр чадвар дутагдалтай байх нь нийгэмших, харилцаа холбоо тогтоох, шинэ газарт дасан зохицоход саад болж, ялгаварлан гадуурхагдах эрсдэлийг нэмэгдүүлдэг тул боловсрол эзэмшихэд сул тал болдог. 2012 онд 23 өндөр орлоготой орнуудад бичиг үсэгт тайлагдалтын түвшин доогуур үзүүлэлттэй цагаачдын эхний үеийн суралцагчдын 53% нь сургуулиас гадуурх бичиг үсгийн боловсрол олгох нэмэлт сургалтад хамрагджээ.

Бэлтгэл ангийн үргэлжлэх хугацаа нь Бельги, Франц, Литва улсад нэг жил байдаг бол Грект дөрвөн жил байдаг. Герман улсад ‘тавтай морилно уу’ хэмээх нэртэй ангиудад цагаач гаралтай суралцагчдад зориулсан тусгайлсан хэлний хичээлийг нилээн эрчимтэй байдлаар заадаг. Испани улсад бүс нутгууд дараахь гурван загварын аль нэгийг хэрэгжүүлдэг - суралцагчийг өдрийн тодорхой цагт хамруулах түр хугацааны хичээлүүд, бүтэн өдрийн хичээлүүд, болон хэл суралцахыг заахаас эхлээд гэр бүл, сургуулийн хооронд харилцаа холбоо үүсгэх хүртэл үйл ажиллагаа хэрэгжүүлдэг олон үндэстний суралцагчдын ангиуд. Цагаач хүүхдүүдийг урт хугацаагаар тусад нь суралцуулах нь төсвийн алдагдал болон бэрхшээлтэй байдлыг нэмэгдүүлдэг тул засгийн газрууд ийм арга хэмжээнээс татгалзах нь зүйтэй.

Ур чадварт тулгуурлан анги бүлэгт хуваарилахыг эрт хийх нь цагаач суралцагчдын хувьд таагүй байдлыг үүсгэж, боломжуудыг хязгаарласнаар тэгш бус байдлыг үүсгэж улмаар суралцагчийн нийгмийн гарал үүсэл болон сурлагын амжилт хоорондын хүчтэй хамаарал үүсэхэд хүргэдэг. Итали улсад мэргэжлийн сургууль төгсөгч цагаач иргэдийн 33%, техник мэргэжлийн сургууль төгсөгч цагаач иргэдийн 13%-тай харьцуулахад ерөнхий боловсролын сургууль төгссөн цагаач иргэдийн 59% нь их, дээд сургуульд шилжин суралцсан байна.

Цагаач суралцагчид хотын захын дүүргүүдийн сургалтын стандарт, сурлагын үзүүлэлтүүд доогуур түвшинтэй сургуулиадад төвлөрөх хандлагатай байдаг. Нутгийн уугуул суралцагчид илүү чинээлэг дүүргүүд рүү шилжих нь тусгаарлах үзэгдлийг улам хурцатгаж байна. Их Британи дахь цагаач суралцагчид эмзэг бүлгийн уугуул суралцагчидтай нэг сургуульд хамрагдах магадлал өндөр. Цагаач суралцагчдын эзлэх хувь өндөр байх нь эмзэг бүлгийн нутгийн оршин суугчдын боловсролын үр дүнд сөргөөр нөлөөлөх талтай. Норвегид нэгэн сургуульд нутгийн уугуул иргэдийн сургууль завсардалт 3%-аар нэмэгдсэн нь цагаач суралцагчдын эзлэх жин 10%-аар нэмэгдсэнтэй холбоотой байжээ.

Ялган тусгаарлахтай тэмцэх зорилгоор улс орнууд янз бүрийн аргачлалыг ашигладаг. Итали улсад 2010 оны албан ёсны журмаар анги танхим дахь эхний үеийн цагаачдын эзлэх хувийг 30% хэмээн тогтоосон. Бодит амьдрал дээр бага ангиудын 17% нь тус хязгаарыг давсан байв. Франц, Германы сургуулиуд дахь тусгаарлалтыг хязгаарлах бодлого журам, шинэчлэлээс үл хамааран эцэг эхчүүд сургуулийн удирдлагуудад шалтаг тоочсоны улмаас сургуулиуд эцэг эхчүүдийн сонголтын дагуу шашин эсвэл гадаад хэлний хичээлийг тусгаарласан ангиудаар зааж байна. Берлин дэх дөрвөн дүүргийн 108 бага сургуулийн хамран сургах тойрогт хийсэн судалгаанаас үзэхэд таван сургууль тутмын нэгд цагаач гаралтай суралцагчийн тоо нь тухайн хамран сургах тойрогт амьдардаг хүүхдүүдийн тооноос хоёр дахин их байжээ.

ЗАРИМ ЗАСГИЙН ГАЗРУУД ЦАГААЧ СУРАЛЦАГЧ ОЛОНТОЙ СУРГУУЛИУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛДЭГ

Цагаач, дүрвэгч суралцагч олонтой сургуулиудад санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөр байдаг. Хувьсах зардалд суурилсан санхүүжилт нь суралцагчдын эмзэг байдалтай холбоотой хүчин зүйлсийг үндэслэн дээрх сургуулиудад нэмэлт нөөцийг хуваарилах замаар тэгш боломжийг нэмэгдүүлэхийг зорьдог. Зарим хөтөлбөрүүд сургуулийн санхүүжилтэд цагаачдыг бие даасан тодорхой хүчин зүйл хэмээн тусгадаг. Литвад сургуулийн төсөвт үндэсний цөөнхийн бүлгийн суралцагчид нэмэлт 20%-ийн санхүүжилт, цагаач суралцагчийн сургуульд хамрагдах эхний жилд 30%-ийн нэмэлт санхүүжилтийг тусгадаг байна.

Дээр дурдсан жишээнүүд онцгой тохиолдлууд бөгөөд цагаач, дүрвэгч суралцагчдад зориулсан нэмэлт шууд бүс санхүүжилтийг бий болгох хэрэгтэй. Цагаачдын дунд түгээмэл бэрхшээлүүд болох сургуульд хэрэглэгддэг хэлний мэдлэг муу байх болон амьдарч буй дүүргийнхээ түвшинд нийгэм-эдийн засгийн хувьд гачигдалтай тулгардаг асуудлуудыг харгалзан үзэж санхүүжилтийг олгож болох юм. Англи (Их Британийн Вант Улс) улсын боловсролын зардал тооцоолох шинэ аргачлалд цагаачдад зориулсан тусгайлсан санхүүжилтийг үгүй болгосон ч ‘гачигдал’, ‘өмнөх боловсролын түвшин доогуур’ эсвэл ‘англи хэлийг нэмэлт хэл байдлаар суралцаж буй’ зэрэг хүчин зүйлсийг үндэслэн нэмэлт санхүүжилтийг хуваарилдаг болсон байна.

Цагаач, дүрвэгч суралцагчдад дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай нэмэлт нөөцүүдийг сургуулиудад ихэвчлэн зардлын тооцооллын аргачлалаас гадуурх хүрээнд олгодог. Данийн Засгийн газраас цагаач өрхүүд болон сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургууль, өрхийн зөвлөх ажилтан ажиллуулах зэрэг үйл ажиллагаанд зориулан 3 сая орчим ам.долларын санхүүжилтийг 2008-2011 онд тусгайлан хуваарилсан байна.

Зарим улс орнууд боловсролын санхүүжилтийн аргачлалаас гадуурх хүрээнд хэлний хөтөлбөрүүдэд чиглэсэн дэмжлэг үзүүлдэг. АНУ-ын Англи хэл Эзэмших Хөтөлбөрийн хүрээнд англи хэл суралцагсдын эзлэх хувиас хамааран муж улсын тэтгэлэгт санхүүжилтийн аргачлалаар жил бүр 740 орчим сая ам.долларыг хуваарилдаг. Сургуулиуд тус санхүүжилтийг хэлний хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэдэг. Тэрчлэн энэ санхүүжилт нь цагаач суралцагчид болон тэдний гэр бүлтэй ажиллахад бэрхшээлтэй тулгардаг багш нарт дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг байна.

Цагаач, дүрвэгч суралцагчдад чиглэсэн зорилтот дэмжлэг нь сургууль болон сургуулийн удирдлагын бүтцийн түвшинд тулгарч буй бэрхшээлийг авч үзэхгүй байх талтай. Боловсролын түвшин багатай цагаач, дүрвэгч иргэд ихэвчлэн сургуулийн удирдлагуудын хувьд хүний нөөц султай дүүргүүдэд олноор амьдардаг. Хэрэгцээ шаардлага бүхий сургуулиудад багш нарыг татах урамшууллыг сургуулийн үндсэн төсвөөс гадуур олоход бэрхшээлтэй. Мөн АНУ-ын жишээнээс харахад улс төрийн шийдвэрүүд нь түр зуурын эсвэл төсвөөс гадуурх санхүүжилтээр хөтөлбөрүүдийг дэмжихэд томоохон нөлөөтэй байдаг.

БИЧИГ ҮСГИЙН БОЛОН ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ НАСАНД ХҮРСЭН ЦАГААЧ, ДҮРВЭГЧИЙГ ТЭГШ ХАМРУУЛАХ НЭГЭН ТУЛГУУР БОЛОХ НЬ

Цагаач, дүрвэгч иргэдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин маш ялгаатай байна. Герман дахь орогнол хүсэгчдийн дунд 2016 онд хийсэн судалгаанаас үзэхэд тэдний 15% нь бичиг үсэг мэдэхгүй, 34% нь латин үсэгт тайлагдсан, 51% нь өөр бусад бичиг үсгийн мэдлэгтэй байв. Насанд хүрэгчдийн бичиг үсэг мэдэх явдал нь цагаачид, дүрвэгчдийн ая тухтай байх, дасан зохицох мэдрэмж болон бусадтай харилцах, өдөр тутмын хэрэгцээ шаардлага хангах үр чадварыг нэмэгдүүлдэг. Хүлээн авагч орны хэлний мэдлэг өндөр байх нь ажлын боломжуудыг нэмэгдүүлэх, өндөр цалин орлоготой болох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сайн дураараа хамрагдах зэрэг боломжийг нэмэгдүүлдэг. Гэвч насанд хүрсэн цагаач, дүрвэгчдэд чиглэсэн олон нийтэд бичиг үсгийн чадвар олгох томоохон хөтөлбөрүүд ховор байна.

Хөтөлбөрүүд нь цагаач, дүрвэгчдийн олон янз байдлыг тусгасан уян хатан байх ёстой бөгөөд сургалтын эрчимтэй байдал, агуулга болон цагийн хуваарийг ялгаатай тогтоох нь зүйтэй. Төрөлх хэлний бичиг үсгийн чадваргүй суралцагчид нилээд бэрхшээлтэй тулгардаг. Нэгэн судалгаанд албан боловсрол огт эзэмшээгүй эсвэл боловсролын түвшин багатай иргэд хоёр дахь хэлээр унших суурь түвшинд хүрэхийн тулд найм дахин удаан байдаг талаар дурдсан байна. Финлянд улсад суралцах хурд удаан байгааг бичиг үсгийн чадваргүй насанд хүрэгчдэд зориулсан сургалтын хугацаа хэт богино байгаатай холбон тайлбарладаг.

Ийм суралцагчдад туслахын тулд багш нар цагаачдын өдөр тутамд тулгардаг сорилт бэрхшээлүүдийг тусгасан сургалтын материалыг ашиглах үр чадвартай байх хэрэгтэй болдог. Вена хотын AlfaZentrum für MigrantInnen хөтөлбөрт суралцагчид ойлгохыг хүссэн материалаа ажлын байр болон гэрээсээ авчирдаг.

Насанд хүрэгчдэд төрөлх хэлээр нь хичээл заах нь бичиг үсэг шинээр сурахад нь дэмжлэг болдог үр дүнтэй аргуудын нэг болно. Норвеги улсад насанд хүрэгчдийн сургалтын төвүүд боловсролын түвшин өндөртэй цагаач суралцагчдыг бичиг үсгийн чадвар эзэмших анхан шатны хөтөлбөрүүдэд туслах ажилтнаар ажиллуулах байдлаар хамтран ажиллаж эхэлсэн нь багш, суралцагчдын хоорондын үл ойлголцол бүхий бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Санхүүжилт дутмаг байх нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт үүсгэдэг ба ялангуяа, Их Британийн Нэгдсэн Вант Улсын жишээнээс харахад засгийн газрын хөрөнгө нөөц, дэмжлэг нь бодлоготойгоо нийцдэггүй тохиолдолд ийм бэрхшээл үүсэж байна. Хувь хүмүүс ялангуяа эмэгтэйчүүд ядуурал, аюулгүй байдлын талаарх зовиол болон соёлын хувьд тохиромжтой хөтөлбөрүүд дутагдалтай байдаг зэргээс үүдэн сургалтанд хамрагдахаас татгалздаг.

Шинээр ирэгсэд үндэс угсаа, хэл нэгтэй хүмүүс ихээр амьдардаг дүүрэгт бөөнөөр суурьших нь шинэ хэлээр ярилцах

Боломжийг багасгаснаар хэл сурах явцыг сааруулдаг. Тэрчлэн түр хугацаагаар шилжин ирсэн хүмүүс шинэ хэл сурах хүсэл зориггүй байдаг.

Хэлний хөтөлбөрүүд нь уян хатан, соёлын хувьд мэдрэмжтэй бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүний нөөц сайтай байх шаардлагатай. Цагаач, дүрвэгч иргэдийг төлөвлөлт болон хичээл заах үйл ажиллагаанд оролцуулах нь мөн ач холбогдолтой байдаг. Шинэ Зеландад цагаач иргэдэд зориулсан хөтөлбөр боловсруулахад засгийн газраас үрд өмнөх болон одоогийн дүрвэгчидтэй тэдний хүсч буй хөтөлбөрийн онцлог шинж чанар болон хөтөлбөрт хамрагдахад тулгарах саад бэрхшээлүүдийн талаар зөвлөлддөг.

Цагаачид, дүрвэгчдийн хувьд шилжин ирэхэд нь хөдөлмөр эрхлэлт нь эн тэргүүнд тавигдах асуудал тул тэднийг бусадтай нэгтгэх болон хэл сурах явдлыг хөдөлмөр эрхлэхтэй нь уялдуулж болох юм. Кабо Вердед амьдардаг Африк гаралтай цагаач иргэдийн бичиг үсгийн чадвар болон сургалтыг дэмжих хөтөлбөр нь бичиг үсгийн сургалт, португал хэл болон компьютер дээр ажиллах, мужаан зэрэг техник мэргэжлийн сургалтыг багтаадаг. Герман улсын Засгийн газрын интеграцчилсан сургалт герман хэлний хичээлийн 600 цагийг багтаадаг бөгөөд хэлний ур чадварын хувьд Б1 түвшинд хүрсэн дүрвэгчид ажил мэргэжлийн чиглэлээрх хэлний сургалтын шалгуурт тэнцдэг.

ШИЛЖИН СУУРЬШИГЧДАД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ХЭРЭГТЭЙ БАЙДАГ

Иргэд нь цагаачлах хандлага өндөртэй орнуудад санхүүгийн боловсролын түвшин доогуур байдаг ба үр чадвар муу шилжин суурьшигчид, буцаж буй цагаач, дүрвэгчид залилан, санхүүгийн аливаа хэлбэрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй байдаг. Нэн ялангуяа, тэдний амьдарч буй орны санхүү, нийгмийн халамжийн тогтолцоо болон мөнгөн гүйвуулгын сувгууд эхэндээ тэдэнд ойлгомжгүй байдаг.

ЭЗХАХБ-ын Санхүүгийн Боловсролын Олон Улсын Сүлжээ зэрэг олон улсад хэрэгжиж буй санаачлагууд санхүүгийн боловсролыг дэмжих өргөн хэмжээний хөтөлбөрийнхөө хүрээнд шилжин суурьшигчдад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Шилжин суурьшигчдад зориулсан санхүүгийн боловсролын хөтөлбөрүүдэд ихэвчлэн олон улсын, засгийн газрын, төрийн бус болон хувийн салбарын түншүүдийг хамтад нь оролцуулдаг.

Индонези улс санхүүгийн боловсролын талаарх үндэсний стратегийг 2013 онд баталсан. Энэ нь Дэлхийн Банктай хамтарсан хөтөлбөрийн үр дүнд бий болсон нотолгоонд суурилсан ба амжилт гаргах боломжтой шилжин суурьшигчид санхүүгийн томоохон шийдвэрүүдтэй тулгарах үед чиглэсэн сургалтыг явуулдаг. Санхүүгийн боловсрол олгох Мороккогийн Сангаас Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагатай түншлэн Морокко дахь цагаачдад чиглэсэн санхүүгийн боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулсан. Румын улсад Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагаас Мастер Карт Сантай хамтран цагаачид, дүрвэгчдийн шинэ улс оронд дасан зохицох явдлыг дэмжих зорилгоор хамтарсан санаачилгыг эхлүүлсэн нь хүүхэд, эмэгтэйчүүд болон тусгай хэрэгцээтэй иргэд зэрэг эмзэг бүлгийнхэнд эн тэргүүнд анхаарал хандуулдаг байна.

Санхүүгийн боловсрол сайтай цагаачдын хувьд ч санхүүгийн нэр томьёо, санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн онцлогууд нь танил биш байж болох талтай. Тэд өөрсдийнхөө төрөлх нутаг болон шилжин ирсэн улс орны аль алиных нь санхүүгийн байгууллагад итгэх итгэлгүй байж болно. Бичиг баримтгүй цагаачид, шинээр ирсэн дүрвэгчид санхүүгийн үйлчилгээ авахад шаардагдах мэдээлэл нь тэднийг илчилж, нутаг буцаахад хүргэнэ гэхээс айдаг. Санхүүгийн салбарт цагаачид болон төрөлх нутагтаа үлдсэн тэдний ар гэрийнхэнд хэрэг болох соёлын мэдрэмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ дутагдалтай байдаг.

Цагаачдын эдийн засгийн сайн сайхан байдалд санхүүгийн боловсролын нөлөөний талаарх баримт нотолгоо хоёр талтай байна. Катар дахь Энэтхэг цагаачдын талаарх судалгаанаас харахад санхүүгийн боловсрол нь тэдний санхүүгтэй холбоотой шийдвэрт бага ч гэсэн нөлөө үзүүлсэн байна. Австрали, Фижи, Шинэ Зеландад хийсэн судалгааны тайланд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрүүд нь албан ёсны банкны үйлчилгээг ашиглахад томоохон нөлөө үзүүлээгүй тухай дурджээ.

Дүрвэлт

Дүрвэгч иргэдийн тоо дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Дүрвэгч иргэд дэлхийн хамгийн ядуу, үйлчилгээ хамгийн хүртээмжгүй газар нутгаас ирэх хандлагатай бөгөөд тэд боловсрол эзэмших боломжгүй нөхцөлд тэдний эмзэг байдал улам хурцдаж байна.

НҮБ-ын Дүрвэгчдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар (НҮБДАЭДКГ)-ын хамгаалалтад 19.9 сая дүрвэгч байгаагийн 52% нь 18-аас доош насныхан байна. Ойрхи Дорнод дахь Палестины дүрвэгчдийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусламжийн агентлагийн хамгаалалт дор 5.4 сая Палестины дүрвэгчид байна. Дүрвэгчдийн 39% орчим нь ихэнхдээ Сахар орчмын Африкт байрлах сайтар зохион байгуулагдсан, өөрсдөө суурьших буюу шилжин суурьших хуаран, хамтарсан төвүүдэд байрладаг. Үлдсэн дүрвэгчдийн олонх нь хот суурин газруудад салангид байруудад амьдарч байна.


Үүн дээр нэмээд зөрчилдөөний улмаас 40 сая иргэн дотооддоо дүрвэж, тэдний хамгийн дийлэнх нь Арабын Бүгд Найрамдах Сири Улсад амьдарч байгаа ба байгалийн гамшгийн улмаас 19 сая хүн дүрвэсний дийлэнхийг Хятад улс орогнуулж байна.

“ Дүрвэгч иргэд дэлхийн хамгийн ядуу, үйлчилгээ хамгийн хүртээмжгүй газар нутгаас ирэх хандлагатай бөгөөд тэд боловсрол эзэмших боломжгүй нөхцөлд тэдний эмзэг байдал улам хурцдаж байна.

”

ЗУРАГ 3:

Бага орлоготой орнууд дахь өсвөр насны дүрвэгчдийн дөнгөж 11% нь дунд сургуульд суралцдаг
5-17 насны сургуульд хамрагдсан дүрвэгчдийн хувь,
боловсролын түвшингээр, 2017 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig4_2
Эх сурвалж: НҮБДАЭДКГ (2017).

Дүрвэгчдийн боловсролын хүртээмж, чанар хоцрогдолтой байна

Дүрвэгчдийн боловсролын статусыг тодорхойлох нь бэрхшээлтэй хэдий ч НҮБДАЭДКГ-ын тооцоолж буйгаар 2017 оны дүрвэгчдийн сургуульд хамрагдалтын түвшин бага сургуульд 61%, дунд сургуульд 23%-тай байна. Бага орлоготой орнуудад хамран сургалтын жин бага боловсролын түвшинд 50%, дунд боловсролын түвшинд 11% байна (Зураг 3). Ерөнхийд нь харахад 2017 оны байдлаар 5-17 насны ойролцоогоор 4 сая дүрвэгч сургуулиас завсардсан байна.

Дүрвэгчдийн сургуульд хамрагдалтын жин улс орнуудад маш ихээр ялгаатай байна. 2016 онд Этиоп дахь дүрвэгчдийн дунд сургуульд хамрагдалтын бохир жин дүүргээр ялгаатай буюу Самарад 1%, Жижигад 47% байсан байна. Пакистанд 2011 онд бага сургуульд хамрагдалтын цэвэр жин Афган дүрвэгчдийн хувьд (29%) үндэсний дундаж түвшингийн (71%) талаас ч

бага, харин Афган дүрвэгч охидын хамрагдалт (18%) хөвгүүдийн (39%) хамрагдалтын тэн хагаст хүрэхгүй бөгөөд мөн Афганистан дахь охидын бага боловсролд хамрагдалтын түвшингийн талаас ч бага хувьтай байжээ. Дүрвэгчид ихэвчлэн хүлээн авагч орнуудын нийгмийн үйлчилгээний хүртээмж муу газар нутагт суурьшдаг. Уганда дахь Өмнөд Суданы дүрвэгчид Баруун Нилийн ядуу дэд бүсэд суурьшиж байгаа ба 2016 онд тус дэд бүс нутагт дунд боловсролд хамрагдалтын цэвэр жин улсын дундаж үзүүлэлтийн талд ч хүрэхгүй байжээ.

Дүрвэгчдийн боловсролын чанарын талаар их мэдээлэл байхгүй бөгөөд мэдээлэл бүхий газруудад дүр зураг баргар байна. Кенийн Дадааб дүрвэгчдийн хуаранд бага сургуулийн багш нарын 8% нь мэргэжлийн Кени багш нар, харин 10 дүрвэгч багш тутмын 6 нь мэргэжлийн бус байна.

ДОТООДОО ДҮРВЭГЧ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ХАМРАГДАЛТЫН ЯВЦЫГ БҮРТГЭХЭД БЭРХШЭЭЛТЭЙ

Зөрчилдөөнд өртсөн олон улс оронд дотоодын дүрвэлт нь угийн хэцүү байдалд байгаа боловсролын тогтолцоог улам дордуулдаг. Зүүн хойд Нигерт хамгийн сүүлд хийсэн хэрэгцээг тодорхойлох үнэлгээний хүрээнд олж тогтоосноор 260 сургуулийн 28%-ийг бууны сүм, бөмбөг эсвэл гар хийцийн бөмбөгөөр эвдэлж сүйтгэсэн, 20%-ийг санаатайгаар галдан шатаасан, 32%-ийг дээрэмдэж тоносон бөгөөд 29% нь цэргийн болон зэвсэгт бүлэгтэй байршлын хувьд ойрхон байжээ.

НҮБДАЭДКГ-аас 2018 оны 1 дүгээр сарын байдлаар Украйнд 1.8 сая иргэд дотооддоо дүрвэсэн гэж мэдэгджээ. Дотоодын ихэнх дүрвэгчдийг байршуулж буй Днепр, Харьков, Киев, Запорижжиа хотуудад боловсролын байгууллагууд анги танхим болон хөрөнгө нөөцийн хомсдолтой тулгараад байна. Засгийн газраас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний хүрээнд дотооддоо дүрвэгчдэд зориулан сургуулиудыг нэмж байгуулан, улсын их, дээд сургуулиудыг зөрчилдөөний нутаг дэвсгэрээс нүүлгэж, элсэлтийн журмыг хялбаршуулж, сургалтын төлбөрийг улсаас дааж, зээл, сурах бичиг зэрэг урамшуулал олгожээ.

Байгалийн гамшиг нь ялангуяа Ази, Номхон Далайн орнуудад боловсролын үйлчилгээг тасалдуулж байна. Филиппин улсад жилд дунджаар 20 далайн хар шуурга дэгдэж байгаа ба галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт болон хөрсний нуралтын өндөр эрсдэлд байна. Тус улс гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж, далайн хар шуурганд тэсвэртэй байх зааварчилгаагаар сургуулиудыг хангаснаар боловсрол эзэмших хугацаа дунджаар 0.3 жилээр уртассан байна.

Дүрвэгчдийг үндэсний боловсролын тогтолцоонд хамруулах шаардлагатай

“

Газарзүй, түүх, хөрөнгө нөөцийн боломжтой байдал болон тогтолцооны чадавх нь тэгш хамруулах боловсролын хувьсан өөрчлөгдөж буй мөн чанарт нөлөөлж байна.

”

Хямралын үед ихэнх засгийн газрууд дүрвэгч хүн амд үндэсний боловсролын тогтолцоотой зэрэгцсэн тогтолцооны хүрээнд боловсрол олгох хариу арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гэвч үүнийг тогтвортой шийдэл биш хэмээн олон талын зөвшилцөлийн хүрээнд үзсэн байна. Дүрвэлт ихэвчлэн удаан хугацааны турш үргэлжилдэг. Зэрэгцсэн тогтолцоог хэрэгжүүлэх үед мэргэжлийн багш нар ихэвчлэн дутагдалтай байдаг. Шалгалтуудыг магадлан итгэмжилдэггүй.

Санхүүжилтийн эх үүсвэрүүдийг гэнэтийн шийдвэрээр хаах эрсдэл тулгардаг.

НҮБДАЭДКГ-ын 2012–2016 оны даян дэлхийн боловсролын стратеги нь улс орнуудыг дүрвэгч хүүхдүүдийг магадлан итгэмжлэгдсэн, сертификатжуулсан сургалтуудад хамруулах замаар тэдний боловсролын тасралтгүй байдлыг хангахыг анх удаа уриалсан. Үүний зорилго нь дүрвэгчдийг хоцрогдол нөхөх богино хугацааны сургалтын дараагаар хүлээн авагч орны хүүхдүүдтэй хамт нэг анги танхимд суралцуулж, шаардлагатай тохиолдолд насандаа тохирсон ангийн түвшинд элсэн суралцахад бэлтгэн үндэсний боловсролын тогтолцоонд бүрэн хамруулахад оршино.

Гэвч дүрвэгчдийг тэгш хамруулах байдал нь дүрвэлтийн нөхцөл байдлаас хамааран өөр, өөр байна. Газарзүй, түүх, хөрөнгө нөөцийн боломжтой байдал болон тогтолцооны чадавх нь тэгш хамруулах боловсролын хувьсан өөрчлөгдөж буй мөн чанарт нөлөөлж байна.

Зарим тохиолдолд тэгш хамруулах алхам удаан явцтай байна. 3.5 сая дүрвэгчийг хүлээн авдаг Турк улс эхлээд хувийн сургуулиудыг сургалтын түр төвүүд болгон магадлан итгэмжилж, улмаар тэдгээрийг шилжилтийн сургууль болгон ангилсан ба 2020 гэхэд Сири улсын хүүхдүүдийг улсын сургуульд бүрэн хамруулахаар зорьж байна. Бусад тохиолдолд засгийн газруудын үүрэг амлалт тасалддаг. Исламын Бүгд Найрамдах Иран Улсад Афганы дүрвэгчдийн тэгш хамруулалтын талаарх бодлого дөчин жилийн туршид бага зэрэг тасалдаж байсан байна.

Засгийн газрууд үүрэг амлалт өгсөн ч хэд хэдэн тохиолдолд тэгш хамруулалт бүрэн хэрэгжээгүй. Дүрвэгчид хүлээн авагч орны сургалтын хөтөлбөр, үнэлгээ болон сургалтын хэлний дагуу суралцах хэдий ч Кенийн дүрвэгчдийн хуаран мэт газарзүйн тусгаарлалт, Лебанон, Йордан дахь хоёр ээлжээр хичээллэх сургуулиудын адил чадавхын бэрхшээлийн улмаас боловсролд тэгш хамрагдаж чадахгүй байна. Грек гэх мэт хөрөнгө нөөц ихтэй орнуудад үндэсний тогтолцоогоор дамжуулан дүрвэгчдэд боловсрол олгоход бэрхшээлтэй тулгарсан.

Хэд хэдэн нөхцөлд дүрвэгчдэд боловсролыг тусад нь олгосон хэвээр байна. Палестинийн боловсролын тогтолцоо бол онцлог жишээ юм. Бүгд Найрамдах Танзани Улс дахь Бурунди дүрвэгчид, Тайланд дахь Мьянмарын Карен дүрвэгчид албан бус олон нийтийн эсвэл хувийн сургуульд тусдаа суралцдаг.

ТЭГШ ХАМРУУЛАЛТЫГ ХАНГАХАД НИЛЭЭД БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ШААРДЛАГАТАЙ

“

Шаардлагатай баримт бичгийн бүрдэл дутуу, хэлний бэрхшээл, далд зардлууд нь тэгш хамруулалтад сэргөөр нөлөөлдөг.

”

Үндэсний боловсролын тогтолцоонд дүрвэгчдийг тэгш хамруулахтай холбоотой үүсдэг бэрхшээлүүд нь чадавх сул, зохицуулалт, төлөвлөлтийн талаарх эрэлт хэрэгцээ өндөр нөхцөлүүдэд ихээр мэдрэгддэг. Баримт бичгийн бүрдүүлэлт дутуу байхаас эхлээд хэлний мэдлэгийн түвшин хязгаарлагдмал байдал, боловсрол тасалдсан болон ядуурал хүртэлх асуудлуудыг төлөвлөгөө боловсруулахдаа тооцож үзэх шаардлагатай.

ЮНЕСКО-ийн Боловсролын Төлөвлөлтийн Олон Улсын Хүрээлэнгээс дүрвэгчид, дотоодын дүрвэгчдийн нэн тэргүүний хэрэгцээнд анхаарсан шилжилтийн боловсролын төлөвлөгөөний удирдамжийг боловсруулсан. Хамгийн түрүүнд Чад улс удирдамжийн дагуу төлөвлөгөөг 2013 онд боловсруулсан. 2018 онд Чад улсын Засгийн газар 19 хуаран болон дүрвэгчдийн амьдарч буй газар нутагт 108 сургуулийг улсын ердийн сургууль болгон өөрчилсөн.

Дүрвэгчдийн бичиг баримтын бүрдэл ихэнх тохиолдолд дутуу байдаг нь тэднийг үндэсний боловсролын тогтолцоонд хамрагдахад бэрхшээлтэй болгодог. Йорданд дүрвэгчид сургуульд суралцахын тулд ‘үйлчилгээний карт’-тай байх ёстой байсан ба тус картыг авахад төрсний гэрчилгээ шаарддаг байжээ. Харин 2016 оны сүүлээс эхлэн Йордан улс хүүхдүүдийг үйлчилгээний картгүйгээр улсын сургуульд суралцах боломж бүрдүүлжээ.

Тухайн улсын хэлийг мэдэхгүй байх нь бас нэг бэрхшээл болдог. Руанда улс дахь Бурундианы дүрвэгчид зургаан сар хүртэлх хугацаанд үргэлжлэх цогц чиг баримжаа олгох сургалтад хамрагдаж, англи хэлний зохих түвшинд хүрсний дараа улсын сургуульд элсэн суралцах боломжтой болдог. Герман улсад зохион байгуулдаг бэлтгэл ангиуд нь тус нэмэртэй ч сургалтанд удаан хугацаагаар хамрагдах нь дүрвэгчдийг боловсролын тогтолцооноос гарахад хүргэдэг. Дүрвэгчдийн хэлний хэрэгцээ нь зөвхөн хэл ярианы харилцаа биш мөн хэл ярианы бус харилцааны асуудал тул тэд хүлээн авагч нутгийн иргэдтэй харилцаж байж л шинэ хэл сурдаг.

Шилжилтийн, боловсрол нөхөн олгох, хоцрогдол арилгах, эрчимжүүлсэн зэрэг олон янзын хөтөлбөр нь дүрвэгч хүүхдүүдэд боловсролд шинээр хамрагдах эсвэл сургуульд эргэн ороход нь хэрэгтэй. Норвегийн Дүрвэгчдийн Зөвлөлийн Дадааб дахь эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөр Кенийн найман жилийн сургалтын хөтөлбөрийг дөрвөн жил болгон хялбаршуулж, элсэх болох төгсөх боломжтой хэд хэдэн үе шатыг тогтоосон байна. Энэ нь охидын хамрагдалтыг нэмэгдүүлээгүй ч хөвгүүдийн боловсролд хамрагдах хувийг нэмэгдүүлсэн байна. Уг нь ийм төрлийн хөтөлбөрүүдийг засгийн газраас хэрэгжүүлж, боловсролын салбарын төлөвлөгөөндөө тусгадаг байх шаардлагатай.

Боловсролыг үнэ төлбөргүй олгодог газар ч сурах бичиг, тээвэрлэлт зэрэг зардал өндөр байх талтай. Ливанд нэгэн туршилтын төслийн хүрээнд тээврийн зардалд бэлэн мөнгө олгож, хүүхэд хөдөлмөр эрхлэхийн оронд сургуульд сурахад зарцуулагдсан алдагдсан орлогыг нөхөн олгосон нь хичээлийн ирцийг долоо хоногт 0.5-аас 0.7 өдрөөр буюу 20%-аар нэмэгдүүлжээ. Турк улсын Засгийн газар нөхцөлт бэлэн мөнгөний дэмжлэгийг өргөжүүлж дүрвэгчдэд олгодог болсноор 2018 онд Сирийн 368,000 хүүхэд тус дэмжлэгт хамрагдсан байна.

ТЭГШ ХАМРУУЛАЛТЫГ АМЖИЛТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАГШ НАР ГОЛ ҮҮРЭГТЭЙ

Дүрвэлтийн нөлөөнд автсан бүхий л газар нутаг багшийн ялангуяа, мэргэшсэн багшийн хомсдолтой тулгардаг. Турк улс дахь Сирийн суралцагчдыг сургуульд бүрэн хамруулахад нэмэлтээр 80,000 багш шаардагдана. Герман улсад нэмж 18,000 сурган хүмүүжүүлэгч, 24,000 багш хэрэгтэй байна. Угандад дүрвэгчдэд боловсрол олгоход бага сургуулийн 7000 багш шаардлагатай байна.

“

Дүрвэлтийн нөлөөнд автсан газар нутагт ажиллаж байгаа багш нарт анги дүүргэлт өндөртэй, насны хувьд холимог эсвэл олон янзын хэлтэй суралцагч бүхий анги танхимд хэрхэн хичээл заах талаарх сургалтанд хамрагдах хэрэгцээ тулгардаг ч ийм төрлийн дэмжлэгийг хаа нэг л үзүүлдэг.

”

Багш нарын тэгш боломжийг хангасан, хүлээлтэд нийцэх нөхөн олговор нь хангалттай тооны багшаар хангах, тэднийг ажилд авах, ажлын байранд тогтвортой ажиллуулах, урамшуулахад ихээхэн дэмжлэг болно. Гэсэн хэдий ч хангалтгүй төсөв, богино хугацаат санхүүжилтийн мөчлөгтэй засгийн газрууд, хүмүүнлэгийн түншүүд цалингийн зардлыг санхүүжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг. Дүрвэгч багш нарыг сайн дураар багшлуулан тэтгэлэг олгох нь түгээмэл боловч багш нарын цалингийн ялгаатай байдал нь бэрхшээлтэй асуудал үүсгэж болзошгүй.

Дүрвэлтийн нөлөөнд автсан газар нутагт ажиллаж байгаа багш нарт анги дүүргэлт өндөртэй, насны хувьд холимог эсвэл олон янзын хэлтэй суралцагч бүхий анги танхимд хэрхэн хичээл заах талаарх сургалтанд хамрагдах хэрэгцээ тулгардаг ч ийм төрлийн дэмжлэгийг хаа нэг л үзүүлдэг. Ливанд багш, сургуулийн бусад ажилтнууд өдөр тутам дүрвэгч хүүхдүүдтэй ажилладаг ч тэдний зөвхөн 55% нь өмнөх хоёр жилд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна. Кенийн Какума хуаран дахь багш нарыг дэмжих зорилгоор хэрэгжүүлдэг аргачлалд үндэсний их, дээд сургуулиудаас олгодог албан ёсны багшлах диплом, сертификаттай хөтөлбөрүүдээс гадна Онцгой Байдлын Үеийн Боловсролын Агентлаг дундын Сүлжээнээс боловсруулсан хямралын нөхцөлд ажиллаж байгаа бага сургуулийн багш нарт зориулсан сертификатгүй, албан бус сургалт мөн багтдаг.

Дүрвэгчдийн томоохон хэмжээний урсгалаас үүдэлтэй багшийн хомсдолыг нөхөхийн тулд:



Дүрвэгч багш нар багшлах эрхийн талаарх мэргэжлийн бодлого, журмын үлмаас ихэнхдээ үндэсний сургалтын хөтөлбөрүүдэд хамрагддаггүй. Зарим улс орон дүрвэгч багш нарыг эргэж багшаар ажиллахад дэмжлэг үзүүлдэг. Чад улс Суданы багш нарыг үндэснийхээ сургуулиудад ажиллуулах зорилгоор сургалтанд хамруулж, сертификат олгосон байна. Германы Потсдамын Их Сургуулийн Дүрвэгч багш нарын хөтөлбөр нь Сири болон бусад улсын дүрвэгч багш нарыг сургуульд эргэж багшлах боломжийг бүрдүүлэхийг зорьдог.

Дүрвэлтээс үүдсэн сэтгэцийн эмгэгт стрессийн тархалтын түвшин өндөр орлоготой орнуудын суралцагчдын дунд 10%-25%-тай байхад бага, дунд орлоготой улс орнуудад 75% хүртэл үзүүлэлттэй байна. Хүүхдүүдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай үед сургууль нь эдгээр тусламж үйлчилгээг үзүүлэх цорын ганц газар болно. Гэвч сургуулийн түвшин дэх арга хэмжээнд тусгай мэргэшсэн сэтгэл засалчид шаардлагатай ба тэдний үүргийг гүйцэтгэхэд багш нарын үр чадвар дутагдах юм. Харин багш нар суралцагчидтай харилцах, нийгэм-сэтгэлзүйн сайтар бэлтгэсэн үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх замаар аюулгүй бөгөөд дэмжлэгт орчин бүрдүүлж нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлж болох юм. Тэдэнд анги танхимын зохион байгуулалт болон холбон зуучлах арга замын талаар мэргэжлийн дэмжлэг шаардлагатай.

ДҮРВЭГЧДЭД СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ХЭРЭГТЭЙ

Бага насны хүүхдийн боловсрол, асаргаа (БНХБА) зэрэг тохиромжтой үйл ажиллагаа нь хүчирхийлэл бүхий нөхцөлд байгаа бөгөөд тогтвортой, халамж анхаарал хандуулсан, эерэг дэмжлэгтэй орчин дутагдалтай бага насны хүүхдэд нэн чухал. Гэвч дүрвэлтэд өртсөн олон янзын нөхцөл байдалд бага насны хүүхдүүдийн сурах хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Дунджаас дээгүүр болон өндөр орлоготой найман орныг хамруулсан судалгаанд бага насны дүрвэгч, орогнол хүсэгч хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагыг хангах талаар хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ маш сул байгаа нь үндэсний бодлого боловсруулахдаа тэргүүлэх асуудлуудыг тодорхойлоогүй, төлөвлөлт, хэрэгжилтийн шатанд хариуцлага алдагдсаныг илтгэн харуулж байна. Хүмүүнлэгийн болон дүрвэгчдэд чиглэсэн хариу арга хэмжээний талаарх 26 төлөвлөгөөг хянан үзэхэд бараг тэн хагас нь тав хүртэлх насны хүүхдүүдийн сурах үйл ажиллагаа, боловсролыг огт тусгаагүй, гуравны нэгээс бага нь сургуулийн өмнөх боловсрол эсвэл БНХБА-ны чиглэлээрх үйлчилгээг тусгайлан дурдсан байна.

Ихэвчлэн ТББ-үүд энэхүү сул орон зайг нөхдөг. Олон улсын аврах үйл ажиллагааны хорооноос Илааршуулах анги танхим-сургуулийн өмнөх боловсролын багшийн хөтөлбөрийг Бурунди болон Бүгд Найрамдах Танзани улс дахь хуарангуудад буй Конго хүүхдүүдэд зориулан түршсэн. Тус хөтөлбөрийг 2014 онд Ливаны нөхцөл байдалд тохируулан өөрчилснөөр одоогийн байдлаар сургуулийн өмнөх насны 3200 хүүхдэд үйлчилгээ үзүүлж, 128 багшийг бэлтгээд байна. Хөтөлбөрийг дөрвөн сар түршилтын байдлаар хэрэгжүүлсний дараагаар гурван настай оролцогчдын булчингийн хөдөлгөөний, нийгэм-сэтгэл зүйн болон гүйцэтгэлийн үр чадвар төдийгүй бага насны хүүхдийн түвшний бичиг үсэг, тоо тооллын чадвар нь сайжирсан байна.

Зарим улс орнууд хэд хэдэн орон нутгийн болон ТББ-ынхантай түншлэлийг бий болгосон байна. Этиоп улсын Засгийн газар дүрвэгчдийн хуарангууд дахь бага насны хүүхдийн асаргаа болон боловсролын 80 төв, Аддис Абаба дахь 150 улсын болон хувийн цэцэрлэг дэх 3-6 насны дүрвэгч таван хүүхэд тутмын гуравт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Герман улсын Засгийн газар дүрвэгч, орогнол хүсэгчдэд зориулсан боловсролын цогц төлөвлөгөөг баталж, үндэстэн дамнасан талуудтай түншилж, БНХБА-ны хөтөлбөрийг өргөтгөх, ажилтнуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор 2017-2020 онд ойролцоогоор 400 сая еврогийн хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ДҮРВЭГЧДИЙН БОЛОВСРОЛ ТОМООХОН ЭРСДЭЛД БАЙНА

Олон улсын эрх зүйн баримт бичгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй дүрвэгч хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхийг хангадаг боловч зохистой тусламж үйлчилгээ маш ховор байдаг. Хөгжлийн бэрхшээлийг гаднаас нь хараад, эмнэлгийн дүгнэлтээр эсвэл өөрийн мэдээлснийг үндэслэн тодорхойлдог нь дүрвэгч иргэдийн дундах хөгжлийн бэрхшээлүүдийн мөн чанар болон түвшинг маш доогуур тогтооход хүргэсэн. Сүүлийн үеийн шинэ механизмууд нь Вашингтон Группээс боловсруулсан асуултууд зэрэг чадварт суурилсан системтэй асуултуудыг ашиглаж байна.

“

Дүрвэлт явагдсан нутаг дэвсгэрүүдэд тусгай сургуулиуд тун цөөн бөгөөд төлбөртэй байна.

”

Хөгжлийн бэрхшээлийн тохиолдол нь бие эрхтний хөгжлийн бэрхшээл болон боломжит тохируулгат орчноос шалтгаалан олон янз байна. Пакистан улс дахь Афган иргэдийн дунд хийсэн судалгаанаас харахад харааны бэрхшээлтэй иргэд сургуульд хамрагдах магадлал өндөр (52%) байхад өөртөө үйлчлэх боломжгүй бэрхшээлтэй иргэдийн хувьд магадлал хамгийн бага хувьтай (7.5%) байна.

Орон зай, барилга байгууламжийн хувьд хүртээмж доогуур, багш бэлтгэх сургалт дутмаг зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд томоохон бэрхшээл болж байгаа талаар Индонези, Малайзийн судалгаанууд харуулж байна. Дүрвэлт явагдсан нутаг дэвсгэрүүдэд тусгай сургуулиуд тун цөөн бөгөөд төлбөртэй байна. Нийгэмд гадуурхагдах, цагаачлалын эсвэл засгийн газрын эрх баригчдаас татгалзсан хариу авахаас айж эмээдгийн үлмаас хөгжлийн бэрхшээлийг нуугдмал байлгадаг эсвэл огт мэдээлдэггүй. Гэвч иймэрхүү бэрхшээлтэй асуудлуудыг шийдэх боломжтой юм. Йорданы жишээнээс харахад дүрвэгчдийн шинэ хуарангууд хүртээмжтэй дэд бүтцийг ихээхэн хэмжээгээр байгуулж байна.

Хүлээн авагч болон дүрвэгч иргэдийн давуу талуудыг тодорхойлж, хамтран ажиллах нь нэн чухал. Уганда улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Үндэсний Холбооны нэгэн төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй дүрвэгч иргэдийг хөгжлийн үйл ажиллагаанд оролцуулахыг зорьж байна. Уганда улсын Дүлий Иргэдийн Үндэсний Нийгэмлэг нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургуулиудыг хоёр хуарангийн ойролцоо ажиллуулж байна.

ТЕХНОЛОГИ НЬ ДҮРВЭГЧ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ БОЛОМЖТОЙ

Албадлагын үлмаас бий болсон дүрвэлт боловсролын тогтолцоонд ихээхэн ачаалал үүсгэдэг. Чадлын цараа, хурд, хөдөлгөөнт мөн авсаархан байдал зэргийг харгалзсан технологийн шийдлүүд нь боловсролын түгээмэл нөөцийн хомсдолыг нөхөхөд маш тохиромжтой байж болно. НҮБДАЭКГ-аас Водафон (Vodafone) компанитай хамтран санаачилсан Инстант Нетворк Скуулс (Instant Network Schools) хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Конго Улс, Кени, Өмнөд Судан, Бүгд Найрамдах Танзани Улсын 40,000 суралцагч, 600 багшийг интернет, эрчим хүч, цахим хичээлийн агуулгаар хангаж байна.

“

Дүрвэгсдийн зөвхөн 1% нь дээд боловсрол эзэмшдэг.

”

Ийм төрлийн хөтөлбөрүүдийн нэг дутагдалтай тал нь сургалтын материалууд нь үндэсний сургалтын хөтөлбөртэй уялдаагүй байдаг явдал юм. Гэхдээ Ливаны сургуулийн өмнөх боловсролын 2015 оны сургалтын хөтөлбөрийн дагуу хийгдсэн онлайн материалуудыг санал болгодог Tabshoura (Шохой) санаачилга зэрэг зарим онцгой тохиолдлууд байна. Энэхүү хөтөлбөр нь Муудле (Moodle) сургалтын удирдлагын систем дээр суурилсан бөгөөд араб, англи, франц хэл дээрх хувилбаруудтай.

Технологи нь мөн нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг. Айдиас Бокс (Ideas Box) багцыг Хил хязгааргүй номын сан ТББ, НҮБДАЭКГ хамтран боловсруулсан бөгөөд энэ нь боловсролын агуулгын зэрэгцээ мэдээлэл, соёлын талаарх материалыг агуулдаг. Конго улсын дүрвэгчдийг хүлээн авч буй Бурунди дахь хоёр хуаранд хийсэн чанарын үнэлгээгээр сургалтын тус багцын хэрэглээ нь дүрвэгчдийн дасан зохицох чадварт нь эерэг нөлөө үзүүлсэн гэж дүгнэжээ.

Ихэнх хөтөлбөрүүд багшийн мэргэжил дээшлүүлэх асуудлыг дэмждэг. Нигерт Нокиа (Nokia)-тай хамтран хэрэгжүүлж буй ЮНЕСКО-ийн багшийн боловсролын төсөл нь бага сургуулийн багш нарт хичээл төлөвлөлт, хичээлийг сэдэлжүүлэх асуултууд тавих, өөрсдийн багшлах үр чадварт дүгнэлт хийх, англи хэл, бичиг үсэгт тайллын хичээлүүдээр сурагчдын үнэлгээ хийхэд тусалдаг.

Технологийн чиглэлээрх санаачлагууд мөн бэрхшээлтэй тулгардаг. Тэдгээр санаачлагуудад урьдчилан өндөр хэмжээний хөрөнгө оруулахыг шаарддаг бөгөөд газар бүрт тохиромжтой эрчим хүчний хангалт, холбоос байдаггүй. Хамгийн чухал нь технологи албан боловсролд хамрагдалтыг орлож чадахгүй. Олон улсын байгууллагууд ийм төрлийн санаачлагуудыг илүү сайтар зохицуулалттай, дүрвэгчдийг үндэсний боловсролын тогтолцоонд тэгш хамруулах зорилгыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах хэрэгтэй.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОЛОН ТӨРЛИЙН САНААЧЛАГУУД ДҮРВЭГЧДИЙН ЗАРИМ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАЖ БАЙНА

Их, дээд сургуульд суралцах боломжтой байх нь дүрвэгчдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлээд зогсохгүй бага, суурь боловсролын үйлчилгээний хүртээмж, тогтвортой суралцах байдалд нөлөөлдөг. Харамсалтай нь дүрвэгчдийн дээд боловсролд хамрагдалт ердөө 1%-тай байна. Онцгой байдлын үед боловсролын хүртээмжийн асуудлыг даруй үл ойшоож, дүрвэлт урт хугацаанд сунжирсан нөхцөлд л анхаарал хандуулан зохицуулахыг хичээдэг. Дүрвэгчдийн дээд боловсрол эзэмших эрхийг ихэвчлэн үл ялгаварлан гадуурхалт хэмээн өргөтгөн тайлбарладаг.

Технологид суурилсан санаачлагуудаар дамжуулан дүрвэж буй хүн амд хүрэх боломжтой. НҮБДАЭКГ болон Женевийн Их Сургуулиас хамтран хэрэгжүүлж буй Хямралын Үеийн Суралцахуй Консорциум нь 2010 оноос хойш танхимын сургалтыг онлайн сургалттай уялдуулан 6500 суралцагчдад хүрээд байна.

Дүрвэгчдэд зориулсан олон улсын тэтгэлэгт хөтөлбөр болох Альберт Эйнштейний нэрэмжит Дүрвэгчдийн Сургалтын Санаачлага Сан (ДССС)-гаас дүрвэгчдэд зориулсан тэтгэлгийг НҮБДАЭКГ-аар дамжуулан 1992 оноос хойш олгож байна. Энэхүү тэтгэлгийг дүрвэгчдийн хөдөлгөөн, боловсролын хэрэгцээ шаардлагад үндэслэн аль ч улс орны иргэдэд олгодог. Одоогийн байдлаар Этиоп, Бүгд Найрамдах Иран Улс, Ливан, Турк зэрэг улсын иргэд тус хөтөлбөрт хамгийн их хамрагдаж байна.

Бусад тэтгэлэгт хөтөлбөрүүд нь өндөр орлоготой орнуудад суралцах боломжийг олгодог. Канадын Дэлхийн Их Сургуулийн Үйлчилгээний Дүрвэгч оюутны хөтөлбөр нь дүрвэгчдийг суурьшуулах, сургуульдаа суралцахад нь дэмжлэг үзүүлэх хүсэлтэй их, дээд сургуулиуд дээрх хороодыг дэмжиж, ажилладаг. 1978 оноос хойш тус хөтөлбөрийн хүрээнд 39 орны 1800 дүрвэгчийг Канадын 80 коллеж, их, дээд сургуульд хамруулан сургажээ.

Судлаач эрдэмтдэд мөн дэмжлэг хэрэгтэй. Эрсдэлд Өртсөн Эрдэмтэн Судлаачдын Хөтөлбөрийн хүрээнд судалгаа хийх, багшлах түр хугацааны орон тоог хамгаалалт шаардлагатай судлаачдад зориулан гаргадаг. Британийн Нэгдсэн Вант Улсын Эрсдэлд Өртсөн Эрдэмтэн Судлаачдын Хөтөлбөрийн Зөвлөл (ЭӨЭСХЗ) өөрийн улс орондоо аюулд өртөөд буй эрдэмтэн судлаачдад яаралтай дэмжлэгийг үзүүлдэг.

Тус дэмжлэгийн үр өгөөжийг нийт ард иргэдэд түгээх ёстой. ДССС-гийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдаас илүүтэйгээр уугуул иргэдийг зорилтот өгөөж хүртэгсэд хэмээн авч үздэг. Дүрвэгч судлаач эрдэмтдийг дэмжих сүлжээ нь мөн чадавхыг хөгжүүлэх асуудлыг дэмждэг. ЭӨЭСХЗ нь Ирак, Арабын Бүгд Найрамдах Сири Улс болон Зимбабве улсад судлаачид, багш нарын чадавхыг дахин бүрдүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

Дотооддоо дүрвэгч иргэдэд бусад дүрвэгчдийн адил боловсрол эзэмшихэд сорилт бэрхшээлүүд тулгардаг

“

Дотооддоо дүрвэсэн багш нар ихэвчлэн захиргааны хүндрэл бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн хөлсөө авах боломжгүй болж байна.

”

Дотоодын дүрвэлтийн талаарх НҮБ-ын Чиглүүлэх Зарчмуудад хүн бүрийг боловсрол эзэмших эрхтэй талаар дурдсан ч чадавх болон улс төрийн нөхцөл байдал асуудлуудыг тодорхойлох, шийдлүүдийг зохицуулахад саад болж байна. Дотооддоо дүрвэгчдийн боловсролд тулгарч буй бэрхшээлүүдэд эрх зүй, боловсрол болон захиргааны талаас авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээнүүд нь дүрвэгчдэд чиглэсэн арга хэмжээнүүдтэй ижил төстэй байна.

2017 оны байдлаар 6.5 сая дотоодын дүрвэгч бүхий Колумбын Засгийн газар эрх зүйн хамгаалалтын хүрээнд анхаарал хандуулсан. 2002 онд Үндсэн хуулийн цэц орон нутгийн боловсролын эрх баригчдад хандан дүрвэгч хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхийг хүндэтгэн хандахыг зааварчилсан. 2004 онд шүүхээс дотоодын дүрвэгчдийн боловсрол эзэмших зэрэг үндсэн эрхүүд зөрчигдөж байгаа талаар албан ёсоор

мэдээлсэн.

Дүрвэлтээс үүдэн олон тооны хүүхэд, өсвөр үеийнхний боловсрол эзэмших явц зогсож, тэднийг боловсролын тогтолцоонд эргэн оруулахад дэмжлэг хэрэгтэй болдог. Афганистанд Хямралд Өртсөн Хүүхдүүд ТББ-аас олон нийтэд суурилсан эрчимжүүлсэн хөтөлбөрийг Кабул хотод болон хотын эргэн тойрны албан бус суурьшлын төвүүдэд амьдарч буй дотоодын дүрвэгч сургууль завсардсан хүүхдүүдэд чиглэн хэрэгжүүлж, тэднийг 6 дугаар анги төгсөх болон албан боловсролд шилжин суралцахад нь дэмжлэг үзүүлж байна.

Арабын Бүгд Найрамдах Сири Улсын жишээнээс харахад дотооддоо дүрвэгч багш нар өөрсдийн харьяа дүүргийн захиргааны удирдлага дор хамааралтай хэвээр үлддэг нь тэдний цалин авах асуудлыг ерөнхийд нь боломжгүй байдалд хүргэдэг байна. Ирак улсад 44 түнш байгууллага 15 засаг захиргааны нэгжид үйлчилгээг хүргэж, 5200 багшид тэтгэлэг, урамшуулал олгож байгаа ч зохицуулалт муу байгаа нь үйлчилгээний тасалдал, багшийн цалингийн зэрэглэлийн ялгаатай байдал болон түнш байгууллагуудын дунд бэрхшээлтэй байдлыг үүсгэж байна.

Байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлт нь боловсролын тогтолцоог урьдаас бэлтгэлтэй, хариу үйлдэл үзүүлдэг чадавхтай байхыг шаардаж байна

Боловсролын салбарын төлөвлөгөө нь амьг насан алдах, дэд бүтэц эвдэрч сүйдэх, байгалийн гамшгийн улмаас дүрвэх зэрэг эрсдэлийг тусгаж, боловсролын үйлчилгээ нь онцгой байдлын хариу үйлдэл үзүүлэх үеэс эхлэн сэргээн босгох үе хүртэлх хугацаанд аль болох тасралтгүй байх нөхцөлийг хангах шаардлагатай. 2017 онд НҮБ-ын Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Газраас Гамшгийн эрсдэлийг бууруулах, Боловсролын салбарын тэсвэртэй байдлын талаарх олон улсын эвсэлтэй хамтран Сургуулийн Цогц Аюулгүй Байдлын хүрээг шинэчлэн боловсруулсан. Тус цогц хүрээний гурван тулгуур бүрэлдэхүүн нь суралцах аюулгүй орчин, сургуулийн гамшгийн менежмент болон гамшгийн эрсдэлийг бууруулах боловсрол юм.

Номхон далайн арлын олон оронд цаг уурын өөрчлөлтийн эрсдэлийг боловсролын төлөвлөлтөд тусгадаг. 2011 онд Соломоны арлын Гамшгийн бэлэн байдал, онцгой байдлын боловсролын талаарх бодлогод суралцагчид онцгой байдлын өмнө, явцад болон дараа сургалтын аюулгүй орчинд сурч боловсрох эрхтэй бөгөөд бүх сургууль онцгой байдлын үед ашиглах сургалтын байнгын бус орон зайг тодорхойлсон байхыг баталгаажуулахыг зорьсон.

Хэдхэн арван жилийн дотор цаг уур нь дүрвэлтийн үндсэн шалтгаануудын нэг болж магадгүй байна. Дэлхийн Банкнаас 2050 он гэхэд дэлхий дээр 140 сая хүн цаг уурын өөрчлөлтийн улмаас дүрвэнэ гэсэн тооцоолол хийжээ. Байгалийн гамшигт өртөх эмзэг байдлыг бууруулах зорилгоор зарим орнууд бодлогын арга хэмжээг аль хэдийн авч хэрэгжүүлж эхлээд байна. Кирибатигийн Засгийн газрын дахин байршуулалтын талаарх урт хугацааны үндэсний стратегийн нэгэн хэсэг болох 'эмх цэгцтэй, тайван байдлаар шилжин суурьших' бодлого нь ард иргэдийн мэргэшлийн байдлыг сайжруулж, улмаар хилийн чанадад асаргаа сувилгаа зэрэг чиглэлээр боломжит ажлын байртай болоход шаардлагатай чадавхыг олгоход чиглэж байна.

Олон янз буюу ялгаатай байдал

Олон янз буюу ялгаатай байдалд ач холбогдол өгдөг боловсрол нь нийт улс үндэстнүүдэд чухал бөгөөд энэ нь ялгаатай байдлыг үнэлэн дэмждэг, нэр хүндтэй, чанартай боловсролыг бүх нийтэд олгох боломж бүхий тэгш хамрагдалттай нийгмийг цогцлооход нь улс орнуудад дэмжлэг болдог.

Цагаач, дүрвэгчдийг зарим тохиолдолд хувь хүний чанараас нь илүүтэйгээр тухайн бүлгийн онцлог шинжүүдийн талаарх ойлголтод тулгуурлан үнэлж дүгнэдэг. Нэн ялангуяа хэрэв гаднаас харахад тэд уугуул иргэдээс илт ялгагддаг бол тэднийг 'өөр' хэмээн ялган үздэг өрөөсгөл хандлага, хуучинсаг үзэл нь ялгаварлан гадуурхалтад хүргэж улмаар чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй болгодог.

Өрөөсгөл хандлага, хуучинсаг үзлийн эсрэг бодлого журмууд байсан ч боловсролын олон тогтолцоонд эдгээр сөрөг хандлагууд оршоор байна. АНУ-д цагаач гэр бүлээс гаралтай суралцагчдын эсрэг байгууллагын түвшин дэх ялгаварлан гадуурхалт байгаа нь бага насны хүүхдүүдэд чиглэсэн хос хэлний хөтөлбөр байдаггүй, төрөлх хэлээр нь бичиг үсгийн шалгалтыг авдаггүй зэргээс харагдаж байна.

Олон нийтийн зүгээс үзүүлж буй хандлага нь цагаачдын өөрийгөө ухамсарлах чадвар болон сайн сайхан байдалд нь нөлөөлдөг. Цагаачид ялгаварлан гадуурхалтыг мэдрэх нь тэднийг сэтгэлзүй хямрах, санаа зовних болон өөрийгөө доогуур үнэлэхэд хүргэдэг. Цагаачид уугуул иргэдтэй харьцуулахад хүлээн авагч оронд өөриймсөг байж чаддаггүй талаар 2014 оны Дэлхийн Үнэт Зүйлийн Талаарх Судалгаанд дурджээ.

Боловсролын түвшин нь цагаач, дүрвэгч иргэдэд хандах хандлагад нөлөөлдөг

“

Зохиомол дүрслэлээс бодит баримтыг ялган салгаж ойлгох улс төрийн ойлголт мэдлэг, шүүмжит сэтгэлгээний үр чадваруудыг олгосноор боловсрол нь хэвлэл мэдээлэл дэх сөрөг дүр зураглалыг өөрчлөхөд нөлөөлж чадна.

”

Иргэдийн боловсролын түвшин нь тэдний цагаачдад хандах хандлагатай хамааралтай байдаг. Боловсролын түвшин өндөртэй иргэд үндэс угсаагаар ялгаварлах нь бага төдийгүй соёлын олон янз байдлыг илүү үнэлж, шилжилт хөдөлгөөний эдийн засагт үзүүлэх үр нөлөөг илүү эерэгээр хүлээн авдаг байна. Судалгаанаас үзэхэд их, дээд сургуулийн боловсролтой иргэд дунд боловсролтой иргэдээс хоёр пунктээр илүү хүлцэн тэвчих чадвартай, дунд боловсролтой иргэд бага боловсролтой иргэдтэй харьцуулахад мөн хоёр пунктээр илүү хүлцэн тэвчих чадвартай байна. Залуу үеийнхэн ялангуяа өндөр боловсролтой залуус цагаачдалд илүү эерэг хандлагатай байна.

Цагаач, дүрвэгчдийн талаарх хэвлэл мэдээлэл дэх сөрөг дүр зураг нь хуучинсаг өрөөсгөл хандлагыг дэврээж болзошгүй. Шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн асуудлаарх хэвлэл мэдээллийн агуулгууд нь хэт сөрөг, туйлширсан байдаг. Тухайлбал, Канад, Бүгд Найрамдах Чех Улс, Норвеги, Британийн Нэгдсэн Вант Улсын жишээнээс үзэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд цагаач, дүрвэгчдийг соёл, аюулгүй байдал болон нийгмийн халамжийн асуудалд ноцтой аюул занал болж байна хэмээн дүрсэлдэг. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хэвлэл мэдээллийн агуулгууд ихэвчлэн өрөөсгөл ойлголтыг төрүүлсэн, цагаач, дүрвэгчдийн үзэл бодол, дуу хоолойг тусгаагүй төдийгүй зохисгүй нэр томъёо ашигласан байдаг. Зохиомол дүрслэлээс бодит баримтыг ялган салгаж ойлгох улс төрийн ойлголт мэдлэг, шүүмжит сэтгэлгээний үр чадваруудыг олгосноор боловсрол нь хэвлэл мэдээлэл дэх сөрөг дүр зураглалыг өөрчлөхөд нөлөөлж чадна.

Тэгш хамран сургалт нь боловсролын бодлого, тогтолцооны цөм байх ёстой

Улс орнууд боловсролын тогтолцоон дахь олон янз буюу ялгаатай байдлын асуудлыг шийдвэрлэхдээ уусган нэгтгэх, олон соёлын нэгдэл/интеграцилал, соёл хоорондын харилцаа/тэгш хамрагдалт гэх мэт өөр, өөр аргууд ашигладаг. Соёлд уусган нэгтгэх нь цагаач, шилжин суурьшигч иргэдийн өөрсдийн соёлын үндсэн чанар, итгэл үнэмшилд сөрөг үр дагавартай байдаг. Харин соёл хоорондын харилцаа нь суралцагчдыг бусад соёл төдийгүй хүлээн авагч нийгэмд эрх тэгш бус байдлыг бий болгодог байгууллагын түвшин дэх саад бэрхшээлийг ойлгож мэдэхэд тусалдаг.

Цөөхөн тооны улс орон олон соёлын эсвэл соёл хоорондын боловсролын талаар баримтлах тодорхой бодлоготой байдаг. 2015 оны байдлаар нийт хүн амынх нь 15%-ийг 15 хүртэлх насны цагаач хүүхдүүд эзэлдэг Ирланд улсад 2010-2015 онд баримтлах Соёл хоорондын боловсролын стратегийг боловсруулсан бөгөөд энэхүү стратеги нь боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын чадавхыг хөгжүүлэх, хэлний ур чадварт дэмжлэг үзүүлэх, иргэний нийгэмтэй түншлэлийг бий болгох болон хяналт-шинжилгээг сайжруулах зорилготой юм. Энэхүү стратеги нь тэрчлэн саад бэрхшээлүүдийг арилгаж, төлбөрийг халж, сургуулиудыг элсэлтийн бодлогуудыг хэвлэн нийтлэх шаардлагыг тавьсан. Европын Парламентаас хийсэн судалгаагаар нь Ирланд, Швед улс нь Европдоо цагаачдын боловсролын талаарх хяналт-шинжилгээ, үнэлгээний хамгийн сайн тогтолцоотой нь тогтоогдсон.

Улс төрийн нөлөө нь соёл хоорондын боловсролын бодлогуудыг дутуу үнэлэхэд хүргэж болзошгүй. Нидерланд улсад цагаачдын талаарх сөрөг хандлагууд Данийн нийгэмд үнэнч чанарт суурилсан интеграциллын бодлогыг бий болгоход нөлөөлж, соёл хоорондын боловсролын оронд иргэний боловсролын хүчээл орохоор шинэчлэн өөрчилсөн.

Цагаач суралцагчдын дасан зохицох өөриймсөг мэдрэмжийг хөгжүүлэх өөр нэгэн чиглэл нь төрөлх эх оронтой нь харилцаа холбоог хадгалдаг үндэсний цөөнхийн сургуулиуд юм. Эдгээр нь Польш улсын жишээн дэх тухайн үндэстний засгийн газраас удирдан зохион байгуулдаг эсвэл зохицуулдаг сургуулиуд, Япон дахь Бразилчууд, Саудын Араб дахь Филиппинчүүдийн жишээ болох цагаач иргэдийн байгуулсан хувийн сургуулиуд болон төрөлх эх орны хэл зүйн болон соёлын өвийг дамжуулж байдаг албан бус боловсролын сургуулиуд юм.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ НЬ ИЛҮҮ ТЭГШ ХАМРУУЛСАН ШИНЖТЭЙ БОЛЖ БАЙНА


Сургалтын хөтөлбөр, сурах бичгүүд нь хуучинсаг ерөөсгөл ойлголтыг бууруулж, цагаачдын дасан зохицох өөриймсөг мэдрэмжийг хөгжүүлдэг. Бусад орны түүхээс суралцах нь 2016 онд зохион байгуулсан Олон Улсын Иргэний ба Иргэншлийн боловсролын судалгаанд хамрагдсан 22 орны 12-т үндэстний бүлгийн эрхийг баталгаажуулахад чиглэсэн эерэг хандлага төлөвшихөд нөлөөлсөн гэж дүгнэсэн байна.

Олон улс орон нийгмийн олон янз буюу ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөртөө тусгах нь нэмэгдсээр байна. Олон соёлын талаарх бодлогын индексийг судлах судалгаанд хамрагдсан өндөр орлоготой 21 улс орноос зөвхөн Австрали, Канад улс 1980 онд сургалтын хөтөлбөртөө олон соёлын

ЗУРАГ 4:

Сургалтын хөтөлбөртөө соёлын олон янз байдлыг тусгасан улс орны тоо нэмэгдэж байна

Өндөр орлоготой 21 оронд сургалтын хөтөлбөртөө олон соёлын асуудлыг тусгасан байдал, 1980–2010 он



ДБХШ StatLink: http://bit.ly/jiq5_2

Тэмдэглэл: Олон соёлын талаарх тодорхойлолт нь үндсэн тайлангийн Хүснэгт 5.1 дэх соёл хоорондын харилцааны талаарх тодорхойлолттой ижил төстэй.

Эх сурвалж: Westlake (2011).

асуудлыг тусгасан байжээ. 2010 он гэхэд олон соёлын асуудлыг улс орнуудын гуравны хоёр нь ямар нэгэн байдлаар хөтөлбөртөө тусгасан бөгөөд Финлянд, Ирланд, Шинэ Зеланд болон Шведэд бүрэн интеграцчилсан байна (**Зураг 4**).

2015 онд 38 өндөр орлоготой орны 27 нь соёл хоорондын боловсролыг тусгайлсан хичээлээр олгодог, сургалтын хөтөлбөртөө тусгасан эсвэл, энэ хоёр хувилбарыг хоёуланг хэрэгжүүлсэн байна. Олон соёлын болон соёл хоорондын үнэт зүйлсийг бүх хичээлийн агуулгад тусгах боломжтой. Түүхийн хичээлийн хөтөлбөрт ихэвчлэн үндэстэн угсаатныг тусгайлан судалдаг бол Герман улсын газарзүй, Англи улсын иргэний боловсрол хичээлүүд зэрэг нь өөр байна. Орчин цагийн зарим сурах бичигт шилжилт хөдөлгөөнтэй холбоотой маргаантай асуудлуудыг тусгаагүй байна. Мексик улсад сурах бичгүүдэд бичиг баримтгүй цагаачид болон АНУ-тай холбогдох харилцааг огт дурддаггүй. Харин Кот-д'Ивуарт 2002 оны улс төрийн хямралаас хойш мэддэг болсон цагаач, дүрвэгчид болон дүрвэлтийн талаарх асуудлуудыг сурах бичигт дурддаг болсон.

Сургалтын хөтөлбөрийг орон нутгийн түвшинд өөрчлөн нутагшуулах боломжтой. Тухайлбал, Канадын Альберта дүүрэгт сургалтын материалуудыг цагаач, дүрвэгчдэд хичээл заах, тэдний суралцах үйл явцад дэмжлэг болох байдлаар өөрчилсөн бөгөөд ялангуяа Карен, Сомали болон Өмнөд Суданы иргэдэд тусгайлан чиглүүлсэн байдаг. АНУ-д сургуулийн удирдлагууд нь олон янз буюу ялгаатай байдалд ач холбогдол өгдөг тохиолдолд суралцагчид өөр соёл бүхий суралцагчидтай илүү идэвхтэй харилцах хандлагатай байдаг байна.

Багшийн зааж буй хичээлийн үйл ажиллагаанд суралцагчдын шүүмжит сэтгэлгээний үр чадварыг хөгжүүлэх зорилгоор олон үргальч үзэлд нээлттэй хандах дасгалуудыг тусгах шаардлагатай. Туршлага хуримтлуулах болон хамтран суралцах үйл явц нь соёл хоорондын харилцааг сайжруулах, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх байдлыг нэмэгдүүлэх, өрөөсгөл хуучинсаг хандлагыг бууруулахад дэмжлэг үзүүлдэг.

ОЛОН ҮНДЭСТНИЙ СОЁЛ БҮХИЙ АНГИД ХИЧЭЭЛ ЗААХАД БАГШ НАРЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТ НЬ ИХЭНХ ОРОНД ЗААВАЛ ЯВУУЛАХ СУРГАЛТАД ТООЦОГДДОГҮЙ

Олон үндэстний соёл бүхий суралцагчидтай ангид хичээл заахад багш нарт дэмжлэг хэрэгтэй боловч Франц, Ирланд, Итали, Латви, Испани болон Их Британий Нэгдсэн Вант Улсад ярилцлагад хамрагдсан багш нарын 52% нь олон үндэстний хүүхдүүдтэй үр дүнтэй ажиллахад удирдлагын зүгээс хангалттай дэмжлэг үзүүлдэггүй гэжээ. Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт олон янз буюу ялгаатай байдлыг тусгаж буй нь улс улсад өөр байна. Нидерланд, Шинэ Зеланд болон Норвеги улсад олон янзын гарал үүсэлтэй суралцагчдад дэмжлэг хэрхэн үзүүлэх талаарх хичээлийг багш бэлтгэх сургуульд заавал судалдаг бол Европын бусад оронд ийм төрлийн хичээл нь ихэвчлэн сонгох хичээл байдаг.

Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд нь практик арга зүйгээс илүүтэй ерөнхий мэдлэг олгоход анхаардаг. 49 орны 105 хөтөлбөрт хийсэн судалгаанаас үзэхэд эдгээр хөтөлбөрийн ердөө тавны нэг нь багш нарыг соёл хоорондын зөрчлүүдийг ойлгон шийдвэрлэж, сэтгэлзүйн засал болон шаардлагатай суралцагчдад холбон зүүчлэх үйлчилгээ үзүүлэх боломжуудын талаар ойлголттой болгон бэлтгэдэг. Энэ чиглэлээр багш нарын мэргэжлийг байнга дээшлүүлж байх шаардлагатай. 2013 онд ЭЗХАХБ-аас хийсэн Сургах болон суралцахуйн талаарх олон улсын судалгаанаас харахад 34 улсын бүрэн бус дунд боловсролын багш нарын ердөө 16% нь өмнөх жилдээ олон соёлын болон олон хэлний талаарх сургалтад хамрагджээ.

Цагаач гаралтай багш нарын үзүүлсэн үр нөлөөний талаар маш цөөхөн судалгаа байгаа ба эдгээр судалгаанууд нь эхний болон дараагийн үеийн цагаач суралцагчид эсвэл цагаач болон үндэстний цөөнхийн багш нарыг ялган харуулж чадаагүй. Зарим нотлох баримтуудаас үзэхэд олон үндэстнээс бүрдсэн багш нартай байх нь цагаач суралцагчдын амжилт, өөртөө итгэлтэй байдал болон аюулгүй байдалдаа санаа зовохгүй байдалд нь эерэг нөлөөтэй байна. Гэсэн хэдий ч цагаач гаралтай багш нар Европ дахь нийт суралцагчдын бүрэлдэхүүнтэй харьцуулахад нилээн бага байна. Цагаач багш нарын хувьд мэргэжлээрээ ажиллахад мөрдөгдөж буй ялгаврал бүхий бодлогууд болон ажилд авахад тулгардаг гадуурхалт зэрэг нь зарим тохиолдолд энэхүү хомсдолыг улам ихээр өдөөдөг байж болзошгүй.

ХҮЧИРХИЙЛЛИЙН ШИНЖТЭЙ ХЭТ ТҮЙЛШИРСАН ҮЗЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД БОЛОВСРОЛ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ

Хүчирхийллийн шинжтэй хэт туйлширсан үзэл, террорист хандлага, иргэншилтэй болон иргэншилгүй иргэдэд халдах нь даруй шилжилт хөдөлгөөн, дүрвэлт өрнөхөд хүргэж байхад өндөр орлоготой орнуудын олон нийтийн үзэл бодол шилжилт хөдөлгөөнийг терроризмтой холбон асуудлыг улам дэврээж байна. Гэвч ийм тайлбар нь үндэслэл муутай бөгөөд гадаадын иргэдийн өдөөсөн дайралт нь уугуул иргэдтэй харьцуулахад өчүүхэн төдий ба радикал өөрчлөлтөд хүрэх зам олон хэлбэртэй байж болно.

Хэт туйлширсан үзлийг бий болохоос урьдчилан сэргийлэх нь терроризмын эсрэг хамгаалалтын үндэс болдог. Хэт туйлширсан үзэлтнүүд нэн ядуу бөгөөд хамгийн эмзэг бүлгийнхэнд нөлөөлөх замаар эмзэг байдлын аюултай тойргийг бий болгох, түүнийгээ буруугаар ашиглахын тулд хөгжил дэвшлийн явцад тулгарч буй саад бэрхшээлүүдийг дэвэргэж эсвэл илүү хурцадмал болгох хандлагатай байдаг.

Боловсрол нь олон янз буюу ялгаатай байдлыг хүндэтгэх, энх тайван, эдийн засгийн хөгжлийг дэмжих замаар радикал үзлийг сааруулдаг. Хүчирхийлэгч хэт туйлширсан үзэлтнүүд боловсролыг аюул заналхийлэл хэмээн үзэж, сургуулиудыг довтлох үндсэн бай болгодог бөгөөд Нигер дэх Боко Харам бүлэглэлийн дайралт үүний тод жишээ болно.

“

Боловсрол нь олон янз буюу ялгаатай байдлыг хүндэтгэх, энх тайван, эдийн засгийн хөгжлийг дэмжих замаар радикал үзлийг сааруулдаг.

Эсрэгээрээ боловсролд хамрагдахгүй байх нь радикал үзэлд автах өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Боловсролын үр өгөөжийг хүртэхгүй байх нь мөн ижил хэмжээний хор хохиролтой. Арабын найман оронд ажилгүйдэл нь эдийн засгийн хөгжлийн талаарх хүлээлтэд урам хугарсан эрдэм боловсролтой иргэдийн дунд радикал үзэл түгэх хүчин зүйл болсон байна.

”

Олон улс орон сургалтын хөтөлбөртөө хүчирхийлэл бүхий хэт туйлширсан үзлээс урьдчилан сэргийлэх талаарх агуулгыг тусгах хүчин чармайлт гаргасан хэдий ч сургалтын материалууд нь хөтөлбөртэй тэр бүр уялдаагүй. Дэлхий даяар холбогдох арван сурах бичгийн нэг нь зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шийдвэрлэх болон эвлэрэх механизмын талаарх асуудлуудын аль нэгийг тусгасан нь 1950-аад оноос хойш гарч буй бага зэргийн өссөн үзүүлэлт юм.

Багш нар хүлцэн тэвчих хандлагыг дэмжин хөгжүүлж чадах ч тэдэнд зохистой сургалт хэрэгтэй. Сурган хүмүүжүүлэх аргууд тухайлбал, үе тэнгийнхэн нэг нэгнээсээ суралцах, нэгнийхээ туршлагыг судлах, багаар ажиллах, дүрд тоглох болон шүүмжит сэтгэлгээ, нээлттэй ярилцах үр чадварыг сэдэлжүүлсэн бусад арга зүй хамгийн үр дүнтэй байдаг. Түүнчлэн багш нар суралцагчдаа мөрдөж шалгах эсвэл аюулгүй байдлыг нь хангах гэж хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж болохгүй.

Сургуулиуд боловсролын салбарын бус талуудтай хамтран хүчирхийлэлт хэт туйлширсан үзлээс урьдчилан сэргийлэх санаачлагуудыг хэрэгжүүлэх тохиромжтой газар байдаг. Индонези зэрэг улсын зарим хөтөлбөр хохирогчдын санал бодлыг ашиглан сургалтын сэдвүүдийг суралцагчдад илүү хамааралтай, онцлог болгож байна. Хүчирхийлэлт хэт туйлширсан үзлийн эсрэг боловсрол нь жендерийн мэдрэмжтэй, охид эмэгтэйчүүдийн оролцоог хангасан байх хэрэгтэй. Зарим тохиолдолд эмэгтэйчүүд боловсролын ийм төрлийн санаачилга, хөтөлбөрүүдийг чиглүүлэн ажилладаг. Тухайлбал, Пакистан улсын Хайбер-Пахтунхва дүүрэгт нэгэн эмэгтэйчүүдийн байгууллага холбон зуучлалт, зөрчилдөөнийг хувирган өөрчлөх үр чадваруудыг 35,000 эмэгтэйчүүд, 2000 залууст олгосон байна.

Албан бус боловсрол уян хатан тэсвэртэй нийгмийг бий болгоход чухал боловч орхигдмол үүргийг гүйцэтгэж байна

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн талаарх боловсрол олгох, ойлголт мэдлэгийг бий болгох үйл ажиллагаа нь сургуулийн хананы гадна ч өрнөж байдаг. Албан бус боловсрол маш олон төрлийн хэлбэр болон зорилготой байдаг. Харамсалтай нь засгийн газрууд энэхүү үйлчилгээг хүргэх нь ховор байдгаас энэ асуудлаарх системтэй мэдээлэл хязгаарлагдмал байна.

Олон нийтийн төвүүд нь шилжилт хөдөлгөөний талаарх албан бус боловсрол олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Турк улсад Юва Нийгэмлэг ТББ нь олон нийтийн төвүүдээр дамжуулан хэлний сургалт, ур чадварын сургалт семинаруудыг зохион байгуулдаг. Соёлын асуудлаарх чиглүүлэгчид, брокерууд орчуулгын үйлчилгээ үзүүлж, боловсролын тогтолцоог удирдан чиглүүлэхэд тусалдаг. Швед улсын Линкопинг хотын захиргаа Сомали, Араб хэлний мэдлэгтэй багш нарыг бэлтгэж, тэднийг Хамтдаа суралцахуй хөтөлбөрийнхөө хүрээнд 'зуучлагчид' болгон ашигладаг байна. Бразилийн Сан Пауло хотод хэрэгжүүлсэнтэй адил ксенофоби буюу гадаадынхныг үзэн ядах үзлийн эсрэг боловсролын арга хэмжээг хот суурин газруудад авч хэрэгжүүлж болох ч үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд цагаач иргэдийг оролцуулах хэрэгтэй.

Урлаг болон спорт нь албан бус боловсролын маш хүчирхэг хэрэгсэл юм. Норвеги, Испанийн олон нийтийн фестивалиуд нь соёл хоорондын солилцоог идэвхжүүлэх орон зай болдог. Өмнөд Африкийн Кайзер Чийфс (Kaizer Chiefs) хөл бөмбөгийн багаас гадаадын иргэдийн улс оронд оруулж буй эерэг хувь нэмрийг тодотгон харуулсан сошиал мэдээллийн хэрэгслийн томоохон кампанит ажлыг өрнүүлсэн.

Оюутнууд болон мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөн

Даяаршиж буй энэ дэлхийд залуус хилийн чанадад суралцаж, үр чадвартай мэргэжилтнүүд авьяас чадвараа ашиглан ажил хөдөлмөр эрхлэх боломжийг хил дамнан эрэлхийлж байна. Ур чадвартай мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөн нь хувь хүн, байгууллага болон улс оронд маш том үр ашиг, зардал, эрсдэлийг дагуулдаг.

Дээд боловсролыг олон улсын чанартай болгох нь олон хэлбэрээр хэрэгжиж байна

Дээд боловсролыг олон улсын чанартай болгох гэдэгт ‘академик тогтолцоо, институцууд, тэрчлэн хувь хүмүүсийн хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг олон улсын академик орчинд нийцүүлэх’-ийг хамруулна. Үүнд оюутнууд, факультетийн багш нар тухайн оронд болон хилийн чанадад нөлөөлөл бүхий хичээлүүд, хөтөлбөрүүд болон институциудын шилжилт хөдөлгөөнийг хамааруулан ойлгоно.

“

Олон улсын оюутнуудын тэн хагас нь англи хэлээр ярьдаг таван улсад, харин Азийн гурван улсын гадаадад суралцах оюутнууд нийт Азийн оюутнуудын 25%-ийг эзэлж байна.

Олон улсын оюутнуудын тэн хагас нь англи хэлээр ярьдаг Австрали, Канад, Шинэ Зеланд, Их Британийн Нэгдсэн Вант Улс болон АНУ-ыг зорьж байна. Франц, Герман дахь олон улсын оюутнуудын эзлэх хувь 8% болон 6%-аар тус, тус өссөн байгааг англи хэлээр олгодог бакалаврын дараах хөтөлбөрүүд нэмэгдсэнтэй зарим талаар холбон тайлбарлаж болох юм. Хятад, Энэтхэг болон Бүгд Найрамдах Солонгос Улс 2016 онд гадагшаа чиглэсэн олон улсын шилжилт хөдөлгөөний 25%-ийг эзэлж байв. Европ тив нь 2016 онд тус шилжилт хөдөлгөөний 23%-ийг эзэлж байгаагаараа дээд боловсролын салбарын хоёр дахь том илгээгч бүс нутаг болж байгаа хэдий ч 0.9 сая Европын шилжин суралцаж буй оюутнуудын 76% нь бүс нутагтаа суралцаж байна.

”

Оюутнууд өөрийн орны хамгийн чанартай их, дээд сургуульд элсэн суралцах боломж бий эсэх, эх орондоо болон гадаадад суралцах төлбөрөө төлж чадах эсэх болон чанартай боловсролыг эзэмших эсэхээс шалтгаалан дээд боловсролыг хаана эзэмших шийдвэрээ гаргадаг.

Оюутнуудын ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх бодлого нь мөн нэг хүчин зүйлд тооцогдож байна. 2011–2014 онд Их Британийн Нэгдсэн Вант Улсыг зорих Энэтхэг оюутнуудын тоо бодлого журамд өөрчлөлт орж, төгсөлтийн дараах ажлын визэнд хязгаарлалт тавигдсаны улмаас бараг 50%-аар буурсан бөгөөд харин Австралид 70%, АНУ-д 37%-аар тус, тус нэмэгдсэн байна. Хятад, Герман зэрэг зарим улс орон хөдөлмөрийн зах зээл дээрх үр чадварын хомсдолыг нөхөх зорилгоор олон улсын оюутнуудыг авч үлдэх бодлого баримталдаг.

Их сургуулиудын хувьд орлогоо нэмэгдүүлэх нь олон улсын оюутнуудыг элсүүлэх үндсэн шалтгаан болдог. 2016 онд АНУ-ын эдийн засагт олон улсын оюутнууд 39.4 тэрбум ам.долларыг оруулсан. Төрөлтийн түвшин буурч, хүн амын насжилт явагдаж буй Япон зэрэг Азийн хэд хэдэн оронд дээд боловсролын салбар нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн тулд олон улсын оюутнуудыг ихээр элсүүлж байна.

Мексик, АНУ зэрэг улс гадаад оюутнуудын хөтөлбөрийг соёлын дипломат харилцаа, хөгжлийн тусламжийн хэлбэрээр ашигладаг. Бразил, Саудын Араб зэрэг оюутан илгээгч орнууд нь гадаадад суралцахыг хөгжлийн стратеги болгон санхүүжүүлдэг.

Олон улсын түвшин дэх шилжилт хөдөлгөөнд байгаа факультетийн багш нарт элит их сургуулиудын эрэн хайсан багш судлаачид, тухайн орны дотоодын багш судлаачдын хоосон орон зайг нөхөх зорилгоор ажиллуулж буй багш нар эсвэл докторын зэрэг хамгаалсан улс орондоо үргэлжлүүлэн ажиллаж буй багш судлаачдыг хамруулж ойлгоно. Институцийн шилжилт хөдөлгөөний улмаас уламжлалт оюутны шилжилт хөдөлгөөн буурах ч олон янзын боловсролын эрэлт хэрэгцээтэй олон оюутанд үйлчлэх боломжтой болно. Маш олон төрлийн онлайн сургалтууд нь ялангуяа хөгжиж буй орнуудад боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Салбар кампусууд, бүс нутгийн боловсролын нэгдсэн төвүүд бүхий хилийн чанад дахь, хил дамнасан эсвэл хил хязгааргүй хөтөлбөрүүд нь оюутнуудыг эх орондоо олон улсын түвшний боловсрол эзэмших боломжийг бүрдүүлж байна.

Боловсролын стандартуудыг уялдуулах, боловсрол, мэргэшлийн зэргийг хүлээн зөвшөөрөх нь дээд боловсролыг олон улсын чанартай болгоход дэмжлэг үзүүлдэг

Оюутнуудын шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор их, дээд сургуулиуд хосолсон болон хамтарсан зэрэг олгох хөтөлбөр хэрэгжүүлэх, кредит цаг шилжүүлэх, стратегийн түншлэл болон их, дээд сургуулиудын холбоог байгуулах зэрэг нарийвчилсан харилцаа холбоо үүсгэх, гэрээ хэлэлцээр байгуулах боломжтой. Улс орнууд боловсролын стандартууд болон чанарын баталгаажуулалтын механизмуудыг уялдуулах ажлыг хоёр талт, бүс нутгийн болон олон улсын түвшинд ихээр хийдэг болоод байна.

Боловсролын зэрэг олгох нийтлэг стандартууд, чанарын баталгаажуулалт, боловсрол, мэргэшлийн зэргийг хүлээн зөвшөөрөх механизм болон олон улсын оюутан солилцооны сургалтын хөтөлбөрүүд нь Европ болон түнш орнуудыг 2010 онд Европын Дээд Боловсролын Чиглэл (ЕДБЧ) байгууллагыг байгуулах боломжийг бүрдүүлсэн. Энэ нь 1999 оноос эхлэн хэрэгжүүлж буй Болонийн Үйл явцын оргил үе байсан ба өнөөгийн байдлаар тус үйл явцад Европын Комисс, Европын Зөвлөлөөс гадна 48 орны их, дээд сургуулиуд, чанарын баталгаажуулалтын агентлагууд, оюутан, ажиллагсад болон ажил олгогч нар хамрагдаж байна. Лисбоны Харилцан Хүлээн Зөвшөөрөх Конвенци нь ЕДБЧ-д нэгдсэн улс орнуудын боловсрол, мэргэшлийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлуудыг зохицуулдаг ба тус конвенцийг 53 орон соёрхон баталсан.

Зүүн Өмнөд Азийн улс үндэстэн (ASEAN), Зүүн Африкийн орнуудын нийгэмлэг зэрэг бүс нутаг нь эдгээр санаачилгын жишгийг дагаж байна. Дээд боловсролын талаарх бүс нутгийн гуравдугаар бага хурлын үеэр Латин Америк болон Карибын орнууд дээд боловсролын чиглэлд бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар санал нэгдсэн. Дээрх санаачлагуудыг ажил хэрэг болгох зорилгоор ЮНЕСКО-оос Дээд боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх даян дэлхийн конвенцийн төслийг боловсруулж, 2019 онд батлуулахаар ажиллаж байна.

ЕВРОП ДАХЬ ОЮУТАН СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ЗҮҮН ӨМНӨД АЗИТАЙ ТУРШЛАГАА ХУВААЛЦАЖ БАЙНА

Оюутан солилцооны хөтөлбөрүүдийг бүс нутгийн түвшинд институцчилах нь оюутны богино хугацаат шилжилт хөдөлгөөн хийх боломжийг ихээр өргөжүүлж байна. 1987 оноос эхлэлтэй бөгөөд 2014 онд Ерасмус+ хэмээн өөрчлөгдсөн Ерасмус хөтөлбөрийн хүрээнд оюутнууд 3-12 сарын хугацаанд Европын аль нэг улсад шилжин суралцаж, суралцсан хугацааны кредитийг үндсэн сургууль нь дүйцүүлэн тооцдог. Тус хөтөлбөр нь оролцогчдын соёл хоорондын ойлголт мэдлэг, ур чадвар болон хөдөлмөр эрхлэх боломжуудыг нэмэгдүүлээд зогсохгүй Европт нийгмийн эв нэгдлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой.

Судалгаанд оролцсон 10 оролцогч тутмын 9 нь энэ нь тэдний тэсвэр хатуужил, нээлттэй үзэл бодол, хүлцэн тэвчих чадваруудыг нэмэгдүүлсэн гэжээ. Европ дахь оюутны шилжилт хөдөлгөөн нь тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлсэн талаарх баримт нотолгоо мөн байна. Гэвч оюутнуудын шилжилт хөдөлгөөн хийх боломжийг тодорхойлогч хүчин зүйлүүдийг хянан үздэг үнэлгээнүүд нь тэгш боломжийн хувьд илүү нарийн дүр зургийг харуулж байна. Erasmus+ хөтөлбөрт Их Британийн хувьд өндөр мэргэжил боловсролтой эцэг эхчүүдтэй оюутнуудын 4.4% нь оролцсон бол үр чадварын түвшин багатай эцэг эхчүүдтэй оюутнуудын 2.8% нь хамрагдсан байна. Энэхүү зөрүү цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нэмэгдсээр байна.

2015 онд Зүүн Өмнөд Азийн улс үндэстэн (ASEAN), Европын Холбоо хамтран Европын холбооноос ASEAN бүс нутгийн дээд боловсролд дэмжлэг үзүүлэх (SHARE) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь бүс нутгийн түвшинд дээд боловсролын тогтолцооны уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Оюутнуудын шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл нь бүс нутгийн оролцогч талуудын нягт хамтын ажиллагаа хомс байгаагаас үүдэлтэй байна. Европтой харьцуулахад кредит цагийг шилжүүлэн тооцох тогтолцоо нь ASEAN-ны улс орнуудын хувьд маш их ялгаатай байна.

Мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрөх нь олон улсын хөдөлмөрлөх хүчний шилжилт хөдөлгөөний үр өгөөжийг ихээр нэмэгдүүлдэг

Мэргэжлийн үр чадварыг харилцан хүлээн зөвшөөрөх нь чадварлаг боловсон хүчний шилжилт хөдөлгөөний үзүүлэх үр өгөөжийг дэмжихийн зэрэгцээ улам нэмэгдүүлдэг. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад дээд боловсролтой цагаачдын гуравны нэг гаруй нь өөрсдийн хийж буй ажилд шаардагдах үр чадвараас илүү өндөр чадвартай байдаг бол энэ үзүүлэлт нь уугуул иргэдийн хувьд дөрөвний нэгтэй тэнцэхээр байна. АНУ дахь коллеж төгссөн цагаач иргэдийн өөрийн мэргэшил, үр чадвараас доогуур түвшний хөдөлмөр эрхлэлтээс болж алдагдсан орлогын дүнгээс тооцвол жил бүр алдагдсан татварын орлогын хэмжээ 10.2 тэрбум ам.доллар байна.

Гэвч мэргэжлийн үр чадвар, боловсролын зэргийг хүлээн зөвшөөрөх тогтолцоо нь цагаачдын хэрэгцээ шаардлагад нийцэх түвшинд хөгжөөгүй эсвэл хэсэгчилсэн байдалтай байдаг. Энэхүү тогтолцооны үйл явц нь нарийн төвөгтэй бөгөөд цаг хугацаа, өртөг зардал ихээр шаарддаг тул цөөн тооны хүмүүс л хүсэлт гаргадаг. Үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд үнэлгээний агентлагууд, лиценз олгогч байгууллагууд, мөн их, дээд сургуулиуд тавигдах шаардлага болон журам дүрмийнхээ уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй. Засгийн газрын зүгээс холбогдох байгууллагуудыг шударга, ил тод журмын хүрээнд ажиллах болон тэргүүн туршлагуудыг дагаж мөрдөн ажиллах явдлыг баталгаажуулах боломжтой. Дани улсын жишээнээс харахад боловсрол, мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрөх хууль ёсны эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх нь энэхүү боломжийг ашиглах хүмүүсн тоо болон үр ашгийг нэмэгдүүлдэг байна. 2012 онд Герман улсад баталсан хуулийн дагуу гадаадын иргэд оршин суух эрх, иргэншлийн статусаас үл хамааран үр чадвараа хүлээн зөвшөөрүүлэх боломж бүрдсэн.

Ихэнх оронд ажлын сул орон тоо байдаг ч мэргэжлийн үр чадвар нь хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдолд цагаачид багш, сувилагч зэрэг дүрэм журмын хүрээнд зохицуулагддаг ажил мэргэжил хууль ёсоор эрхлэх боломжгүй байна. Хэсэгчилсэн байдлаар хүлээн зөвшөөрөх нь мөн тустай. Өргөдөл гаргагчид шалгалтад тэнцэж, зохих удирдлага хяналтын дор тодорхой хугацаанд ажиллаж, эсвэл зарим үйл ажиллагааг эрхлэх эрхээ түтгэлзүүлж болно. Европын Холбооны Мэргэжлийн үр чадварын талаарх удирдамжийн хүрээнд зарим чиглэлийн мэргэжилтнүүдийг батлагдсан үр чадваруудыг хангасан тохиолдолд Европын Холбооны нутаг дэвсгэрийн хаана ч ажиллах боломжийг олгодог. Ийм төрлийн эрхийг автоматаар олгон хэрэгжүүлэхэд улс төрийн хүчин чармайлт, хөрөнгө нөөц ихээр шаардагдах тул ийм төрлийн гэрээ хэлэлцээр цөөн байдаг.

БАГШИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН НЬ ҮР ӨГӨӨЖ БОЛОН ЭРСДЭЛ ДАГУУЛДАГ

Багш нар бага цалин, ажилгүйдэл, улс төрийн тогтворгүй байдал, ажиллах нөхцөл байдал мүү болон дэд бүтцийн хомсдол зэрэг хүчин зүйлээс шалтгаалан шилжин суурьших сонирхолтой байдаг. Гэвч энэ мэргэжлээр ажиллахад

ихэвчлэн тухайн улсын тодорхойлсон мэргэшил, үр чадварын шаардлагуудад нийцэх шаардлагатай болдог тул цагаачдын хувьд нилээн сорилт болдог.

Багшийн мэргэжилд шаардагдах үр чадваруудад голчлон хэлний шаардлагууд тавигддаг тул ихэвчлэн хэл, соёлын хувьд ижил төстэй орнуудын дунд шилжилт хөдөлгөөн илүү өрнөдөг. Персийн булангийн Хамтын ажиллагааны зөвлөлийн орнуудад багшийн цалин өндөр байдаг тул Египет болон бусад Арабын орнуудын багш нар очиж ажилласнаар тус бүс нутгийн боловсролын тогтолцоог өргөжүүлэн сайжруулахад хувь нэмрээ оруулсан байна. Харин улс орнууд араб хэлний оронд англи хэл дээр хичээл заах болсноор англи хэлтэй багш нар Египет, Йорданы багш нарын оронд ажилладаг болжээ.

Багш нарын шилжилт хөдөлгөөний улмаас илгээж буй орнуудад багшлах боловсон хүчний хомсдол үүсэж, харилцан хамааралтай асуудлууд ар араасаа бий болж байна. Тухайлбал, Их Британид Жамайка, Өмнөд Африк зэрэг улсаас багш нарыг авч ажиллуулдаг. Үүний хариуд Өмнөд Африкт багшлах боловсон хүчний дутагдал үүсэхэд Зимбабве зэрэг орноос багш нарыг авч ажиллуулдаг байна. Карибын орнуудад сүүлийн арван жилүүдэд багшлах боловсон хүчний шилжилт хөдөлгөөн нилээдгүй байсан нь Их Британи болон АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй ажил олголтоос тодорхой хэмжээнд шалтгаалж байна.

Багш нараа гадагшаа илгээснээр тухайн улсын багш бэлтгэхэд болон боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын хувьд төдийгүй боловсролын системд бүхэлд нь ихээхэн хэмжээний гарз хохирол учирдаг. Үүний улмаас илгээгч орнуудын ашиг сонирхолд тулгуурласан олон улсын санаачлагууд бий болсны нэг нь Хамтын нөхөрлөлийн орнуудын багш нарыг ажиллуулах талаарх протокол юм. Гэвч тус протокол нь заавал хэрэгжүүлэх ёс зүйн дүрэм биш тул цагаачлах сонирхолтой байгаа багш нарт хувь хүнийх нь хувьд хориг тавьдаггүй.


Багшийг ажилд авах асуудлыг олон улсын түвшинд хэрэгжүүлэх нь арилжааны байгууллагуудын сонирхлыг татсан ашигтай бизнес болж байна. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг нарийн зохицуулах ажил бараг хийгддэггүй бөгөөд энэ үйл ажиллагаанд хамрагдах төлбөрийг өндрөөр тогтоох хандлагатай ба зохистой мэдээллээр хангахгүйн улмаас шилжин явж буй болон хүлээн авагч орнуудын аль алинаас бүртгэлийн талаар лавлах асуудал их гардаг байна.

УР ЧАДВАРТАЙ АЖИЛТНУУДЫГ АЛДАХ НЬ ЯДУУ БУУРАЙ УЛС ОРНУУДАД ХОХИРОЛТОЙ БАЙХ ТАЛТАЙ

Латин Америкаас Гренада, Гуяана, Карибын орнууд, Европоос Албани болон Малта, Сахар орчмын Африкийн орнуудаас Эритриа болон Сомали зэргийг оролцуулсан нийт 174 улс орон, газар нутгийн дөрөвний нэг гаруйн хувьд өндөр үр чадвартай иргэдийн цагаачлалын түвшин 20%-аас дээш байна (**Зураг 5**).

Чинээлэг гүрнүүд үр чадвар өндөртэй ажилтнуудын төлөө идэвхтэй өрсөлддөгөөс болж илгээгч орнууд үр чадвартай ажилтнуудын хомсдолд орсноор тухайн орны хөгжил дэвшилд саад учрах асуудал хөндөгдөж байна. Гэвч мөнгөн гүйвүүлгын үр нөлөөллөөс гадна үр чадвартай ажилтнуудын шилжилт хөдөлгөөний хэтийн төлөв нь илгээгч орнуудын боловсролд зарцуулах хөрөнгө оруулалтад ихээхэн түлхэц үзүүлэх боломжтой байна. Тус тайланд зориулан хийсэн дүн шинжилгээнээс харахад өндөр үр чадвартай цагаачлагчдын түвшин 14% байх нь хүн капиталын хуримтлалд хамгийн дээд зэргийн эерэг үр нөлөөг бий болгодог байна. Шилжин явсан болсон хүлээн авагч орнуудын онцлог шинжүүдийг харгалзан үзсэний дараа цагаачлалын хэтийн төлөв нь 174 орноос 90 орны хувьд туршлага, мэдлэг хуримтлуулах явдалд цэвэр ашиг хуримтлуулсан байна.

Зарим улсад, ялангуяа Азийн орнуудад иргэд үнэ цэнэтэй үр чадварыг эзэмшин гадаадаас буцаж ирэх нь нэмэгдсээр байна. Филиппинд эх орондоо эргэн ирж буй иргэдийг урамшуулах бодлого баримталж, тэднийг мэргэжлийн үр чадвараа хүлээн зөвшөөрүүлэх үйлчилгээ болон амжилттай ажиллаж буй ажил олгогчидтой холбон зуучилдаг байна.

ЗУРАГ 5:**Хэд хэдэн оронд өндөр үр чадвартай таван хүн тутмын нэг нь цагаачилдаг***Үр чадвартай цагаачлагчдын түвшин, сонгогдсон улс орноор, 2010 он*ДБХШ StatLink: http://bit.ly/fig6_1

Эх сурвалж: Deuster and Docquier (2018).

ЦАГААЧ, ДҮРВЭГЧДИЙН ХУВЬД ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ НЬ ГОЛ АРГА ХЭРЭГСЭЛ БОЛДОГ

Цагаач, дүрвэгч иргэдэд чиглэсэн техник, мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын хөтөлбөрүүдэд нөлөөлж буй хоёр асуудал байна.

Нэгдүгээрт, цагаач, дүрвэгч иргэдийн ТМБС-д хамрагдан үр чадвараа хөгжүүлэх эрэлтийг маш олон саад бэрхшээл бууруулдаг. Анх ирсний дараах ажилгүйдэл болон үр чадвартай нь үл нийцэх ажил хөдөлмөр эрхлэх зэрэг нь үр чадвартаа оруулах хөрөнгө оруулалтыг бууруулдаг. Ирланд, Литва зэрэг улсад бичиг баримтгүй цагаачид болон орогнол хүсэгчид ажил хөдөлмөр эрхлэхийг хуулиар зөвшөөрдөггүй тул тэд мэргэжлийн сургалтад хамрагдах сонирхолгүй болдог. Сургалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хэт олон болон элсэн суралцахад тавигдах шаардлагууд зэрэг нь ТМБС-ын тогтолцоог чиглүүлэхэд төвөгтэй болгож байна. Гэсэн хэдий ч ТМБС-ын байгууллагууд болон хөдөлмөр эрхлэхэд зуучлах төрийн үйлчилгээ нь цагаачдыг холбогдох ажил олгогчидтой зуучилж, ажлын туршлага хүримтлуулахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Герман улсын 'Welcome mentors' зөвлөх ажилтнууд жижиг, дунд бизнесүүдэд шинээр шилжин суурьшигчдаас үр чадвартай ажилтнуудыг сонгон шалгаруулахад тусалдаг ба 2016 онд 3441 дүрвэгч иргэнийг холбогдох сургалтад хамруулжээ.

Хоёрдугаарт, өмнө эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь дүрвэгчдийн баталгаат ажлын байртай болох эсвэл цаашид үргэлжлүүлэн сурч боловсрох боломжуудыг хаадаг. Цагаач, дүрвэгчид боловсролын баримт бичиг, гэрчилгээгээ биедээ авч явах магадлал бага байдаг ба улс орнуудын техникийн боловсролын тогтолцоонууд нь ихээхэн ялгаатай байдаг тул ТМБС-ын зэргүүд нь бусад боловсролын түвшний зэрэгтэй харьцуулахад илүү тохиромж муутай байх талтай. 2013 онд Норвеги улс тодорхойлох баримт бичиггүй иргэдийн боловсролыг хүлээн зөвшөөрөх журам баталсан ба 2013 онд боловсрол, үр чадвар нь үнэлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн дүрвэгчдийн

талаас илүү хувь нь тохирсон ажлын байр олсон эсвэл цаашид үргэлжлүүлэн суралцсан байна. Боловсрол, үр чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх асуудлуудыг засгийн газар хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан шийдвэрлэх боломжтой. Үндэстэн хоорондын боловсролыг хүлээн зөвшөөрөх гэрээнүүдийг Арабын Бүгд Найрамдах Сири Улс, Египет, Ирак, Йордан болон Лебаноны хооронд байгуулсан байдаг.

КРЕДИТ: Шаллендра Яшвант/Хүүхдийг Ивээх Сан
Мина (11 настай), 5 дугаар анги, Боеунг Качанг арал, Кох Конг аймаг, Камбож.



ТХЗ 4-ийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ

ТХЗ 4-ийг дэмжих боловсролын хяналт-шинжилгээний хүрээ нь боловсролын хөгжлийн талаарх хамгийн түвэгтэй асуултуудын заримыг ажиглалтын түвшинд түр орхисон ч нилээд өндөр эрмэлзэл бүхий билээ. Энэхүү хүрээ нь анхаарал татсан асуудлуудыг ил гарган тодорхойлж, улс орнуудыг эдгээр асуудлуудын хяналт-шинжилгээнд хөрөнгө оруулахыг сануулах үндсэн үүрэг хүлээдэг. Үүнтэй зэрэгцэн улс орнуудын тоон мэдээллийг харьцуулах боломжтой байдлыг сайжруулах зорилгоор олон улсын хөгжлийн агентлагууд, улс орнууд, санхүүжүүлэгч байгууллагууд болон мэргэжилтнүүдийн нягт хамтын ажиллагааг шаарддаг үйл явц болох үзүүлэлт, стандартууд болон аргачлалуудыг боловсруулахад ихээхэн чармайлт гарган ажиллаж байна.

“

2018 оны байдлаар дөрвөн үзүүлэлтийн хэрэгжилтийг анх удаа тайлагнаж байгаагийн үр дүнд нийт 43 үзүүлэлтийн 33-ын хүрээнд мэдээлэлтэй болж байна.

”

ТХЗ 4-ийн хэрэгжилтийг хэмжих олон улсын түвшний 11 үзүүлэлт байдаг. ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн 8 үзүүлэлтийг дангаар хариуцсан бөгөөд Олон Улсын Харилцаа Холбооны Эвлэл (ОУХХЭ)-тэй мэдээлэл, харилцааны технологи (МХТ)-ийн талаарх нэг үзүүлэлтийг тодорхойлоход хамтран ажиллаж байна. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн талаарх нэг үзүүлэлтийг НҮБ-ын Хүүхдийн Сан хариуцдаг бол ЭЗХАХБ нь тэтгэлгийн тусламжийн талаарх нэг үзүүлэлтийг хариуцдаг. Нэмэлт 32 сэдэвчилсэн үзүүлэлтийг тооцвол ТХЗ 4-ийн хяналт шинжилгээний хүрээ нь нийт 43 үзүүлэлттэй.

ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн нь ЮНЕСКО-той хамтран хуралдуулдаг ТХЗ 4-Боловсрол 2030-ын үзүүлэлтүүдийн Техникийн Хамтын Ажиллагааны Бүлэг (ТХАБ)-ээр дамжуулан гишүүн орнууд болон агентлагуудтай хамтран олон улсын түвшний болон сэдэвчилсэн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг боловсруулдаг. 2018 оны байдлаар дөрвөн үзүүлэлтийн (насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдах хөтөлбөрт хамрагдалт, бэлгийн цогц боловсрол, сургуулийн түвшин дэх хүчирхийлэл болон дайралтад өртсөн сургуулиуд) хэрэгжилтийг анх удаа тайлагнаж байгаагийн үр дүнд нийт 43 үзүүлэлтийн 33-ын хүрээнд мэдээлэлтэй болж байна. Сургалт явуулах хэл, нөөцийн хуваарилалт болон багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх үзүүлэлтүүдийн хүрээнд ажил үргэлжлэх эсвэл эхлэх бэлтгэл хангагдаж байна

Мөн ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэнгээс зохицуулалтаар хангадаг Суралцахуйн Хяналт-шинжилгээний Олон Улсын Эвсэл нь эн тэргүүнд унших болон математикийн хичээлээрх хамгийн бага түвшний чадвар, насанд хүрэгчдийн бичиг үсгийн чадвар, цахим бичиг үсгийн чадвар зэрэг нарийвчилсан үр дүнгийн үзүүлэлтүүдийн талаарх үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.

ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэнгээс унших болон математикийн хичээлээрх чадварыг уялдаа хамаарлыг тодруулах, харьцуулахад чиглэсэн гурван хувилбар бүхий стратегийг хэрэгжүүлж байна. Эхнийх нь Латин Америк болон баруун Африкийн сонгогдсон орнуудын суралцагчдыг бүс нутгийн болон олон улсын түвшний үнэлгээнд хамруулж, нарийвчилсан харьцуулалт гаргах зорилгоор хэрэгжүүлэх санаачилгыг дэмждэг. Хоёрдугаарт олон төрлийн үнэлгээний агуулгуудын зураглалыг гаргасан ба үүний хүрээнд мэргэжилтнүүд судалгаанд багтсан дасгал, даалгавруудыг хүнд, хөнгөний түвшингээр ангилж, тайлагналтын хэмжээст үзүүлэлтэд оруулах юм. Гуравдугаарт статистик аргачлалуудыг ашиглан чадварын үнэлгээний уялдаа хамаарлыг тодорхойлох үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

2000-2015 оны Бүх нийтийн боловсролын санаачилгын хэрэгжилтийг дүгнэн үзэх нь


2015 оны Бүх нийтийн боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан (БНБХШДТ) нь БНБ-ын хэрэгжилтийн мэдээлэл, баримтад үнэлгээ хийсэн ч ихэвчлэн 2012 оны тоон мэдээлэлд тулгуурласан. Шинэчилсэн үнэлгээг 2015 оны тоон мэдээлэлд тулгуурлан хийсэн бөгөөд энэ нь БНБ-ын санаачилгын хүрээнд гарсан чухал ач холбогдолтой ахиц амжилт төдийгүй тодорхойлсон хүрэх үзүүлэлтүүдийн түвшинд хүрээгүй талаарх дүгнэлтийг өөрчлөөгүй ч өмнөх үйл ажиллагаагаа дүгнэн үзэж 2030 он руу чиглэсэн чухал ажил байлаа.

Үндсэн хоёр үр дүн илүү анхаарал татаж байна. Бага боловсролын төгсөлтийн талаарх БНБ-ын хоёрдугаар зорилтын хувьд авч үзвэл хамрагдалт болон төгсөлтийн хувь 1997 оныг хүртэлх хугацаанд томоохон өөрчлөлтгүй байсан бол 2008 оныг хүртэлх хугацаанд бага боловсролын хамран сургалтын бохир жин, цэвэр жин болон бага сургуулийн төгсөх анги хүртэлх элсэлтийн бохир жин нилээн эрчимтэй өссөн боловч түүнээс хойш зогсонги байдалд орсон байна (Зураг 6а). Харин жендерийн тэгш эрхийн талаарх тавдугаар зорилтын хувьд 2005 онд хүрэх ёстой байсан тэгш байдлын талаарх үзүүлэлтэд хүрч чадаагүй ч 1990-ээд болон 2000-аад оныг хүртэл амжилттай хэрэгжиж, 2009 онд бага, суурь боловсролын түвшинд жендерийн тэгш байдал бүрэн хангагдаж, 2015 онд залуучуудын бичиг үсгийн боловсролын үзүүлэлтийн хувьд жендерийн тэгш байдал бараг бүрэн хангагдсан байна. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин ялгаатай хэвээр буюу бичиг үсэг үл мэдэх хүмүүсийн 63%-ийг эмэгтэйчүүд эзэлсэн байгаа ч дээд боловсролын түвшинд жендерийн хамаарал урвуу буюу эрэгтэйчүүдийн хамрагдалт бага байна (Зураг 6б).


ЗУРАГ 6:

2000-2015 онд дэлхийн хэмжээнд жендерийн тэгш байдлын хувьд тасралтгүй амжилт гарсан боловч бүх нийтээрээ бага боловсрол бүрэн эзэмших байдалд томоохон өөрчлөлт гараагүй

а. Бага боловсролын хүртээмж, оролцоо болон төгсөлтийн талаарх сонгогдсон үзүүлэлтүүд, 1990–2015 он



б. Хамран сургалтын бохир жин болон бичиг үсэгт тайлагдалтын хувь дахь жендерийн тэгш байдлын тохируулсан индекс, 1990–2015 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig7_1

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн.

Цагаач, дүрвэгч иргэдийн боловсролын нөхцөл байдлын хяналт-шинжилгээ олон тооны бэрхшээлийг тодруулж байна

ТХЗ-ын хяналт-шинжилгээний хүрээ нь үзүүлэлтүүдийг эмзэг байдалтай холбоотой олон янзын шинж байдлаар задлан үзүүлэхэд ихээхэн анхаарч байна. Гэвч цагаач, дүрвэгч иргэдийн боловсролын нөхцөл байдлын талаарх системтэй тоон мэдээлэл хангалтгүй байна. Дэлхийн Банкны Бичил тоон мэдээллийн каталоги дахь өрхийн бараг 2500 судалгааны 2000 гаруй нь боловсролын талаарх мэдээлэл агуулж буй ч эдгээрээс ердөө долоон судалгаа тутмын нэг нь шилжилт хөдөлгөөн, үүнээс бага хувь нь дүрвэлтийн талаарх мэдээлэлтэй байна.

“

Шилжин суурьшиж буй өрхүүд байнгын хөдөлгөөнд байдгаас өрхийн судалгааны тооллого хийхээр очиход байдаггүй эсвэл хэлний бэрхшээл болон хууль эрх зүйн асуудлуудын улмаас ярилцлагад хамрагдах боломжгүй байдаг.

”

Шилжин суурьшиж буй өрхүүд байнгын хөдөлгөөнд байдгаас өрхийн судалгааны тооллого хийхээр очиход байдаггүй эсвэл хэлний бэрхшээл болон хууль эрх зүйн асуудлуудын улмаас ярилцлагад хамрагдах боломжгүй байдаг. Тэрчлэн шилжилт хөдөлгөөний урсгал хурдацтай өөрчлөгдөж болох тул түүвэрлэлтийн хүрээ энэ өөрчлөлтийг нэн даруй тусгах боломжгүй байдаг. Дүрвэгчдийн хувьд дүр зураг арай өөр: дүрвэгчдийн хуарангуудад мэдээллийг илүү зохион байгуулалттай цуглуулах боломжтой боловч дүрвэгчдийн дөчөөс бага хувь, түүнээс ч цөөн дотоодын дүрвэгчид эдгээр хуаранд амьдардаг.

Цагаач, дүрвэгчдийг стандарт, ерөнхий зорилготой судалгаануудад хамруулах нөхцөлийг хангахад түүвэрлэлт болон тоон мэдээлэл цуглуулах асуудлуудыг үргэлж бүрэн шийдвэрлэж чадахгүй байх талтай. Стандарт судалгаанууд шилжилт хөдөлгөөний үзэгдлийн хурдацтай зэрэгцэж чаддаггүй бөгөөд давтамж багатай хийгддэг тул тухайн цаг үед шаардлагатай байж болох мэдээллийг боловсруулах боломжгүй байдаг. Иргэдээ илгээж буй болон тэднийг хүлээн авч буй орон нутгийг холбосон судалгаанд тулгуурласан асуулгууд, мөн санамсаргүй түүвэрлэлтэд тулгуурлан мэдээлэл түргэвчилсэн байдлаар цуглуулах зэрэг уян хатан аргачлалууд нь илүү үр дүнтэй байдаг. Эцэст нь хэлэхэд, асуулгууд нь боловсрол-шилжилт хөдөлгөөний хөдөлгөгч хүч эсвэл илгээгч орон дахь мэргэшлийн онцлог шинж чанаруудыг бүрэн тусгаж чадахгүй байх талтай.

2016 оны 3 дугаар сард НҮБ-ын Статистикийн Хорооны дэргэд Дүрвэгч болон дотооддоо дүрвэгчдийн статистик мэдээлэл хариуцсан экспертийн баг ажиллаж эхэлсэн. 40 гишүүн орон, дор хаяж 15 бүс нутаг, олон улсын байгууллагаас бүрдсэн тус баг нь мэдээлэл цуглуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргасан. ЮНЕСКО, НҮБДАЭДКГ-аас хамтран үнэ төлбөргүй бөгөөд нээлттэй эх сурвалж бүхий вебд суурилсан аргачлал болох дүрвэгчдийн боловсролын удирдлагын мэдээллийн системийг улс орнуудад дүрвэгчдийн боловсролын талаарх мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайлагнахад дэмжлэг болох зорилгоор боловсруулж байна.



Бага, дунд боловсрол

ЗОРИЛТ 4.1

2010-2014 онд төрсөн хүүхдүүдийг ТХЗ-ын үеийнхэн хэмээн авч үзэж болох юм. Эдгээр хүүхдүүдийн хамгийн ахмад нь 2015 онд 5 нас хүрч, ихэнх улс орны хувьд 2015/16 оны хичээлийн жил буюу ТХЗ-ын үе (2015-2030) эхлэхэд сургуулийн өмнөх боловсролд элсэн суралцаж байх ёстой. Эдгээр хүүхдүүдийн хамгийн бага нь 2030 онд 16 нас

“ ТХЗ-ын үеийнхэн 2030 он гэхэд бүх нийтээр дунд боловсрол эзэмшсэн байхын тулд одоогийн насны бүлгийнхэн бага сургуульд цаг хугацаандаа элсэн суралцах шаардлагатай.


буюу бүрэн бус дунд боловсролыг төгсөх боломжит хамгийн сүүлийн насанд хүрэх болно. ТХЗ-ын үеийнхэн 2030 он гэхэд бүх нийтээр дунд боловсрол эзэмшсэн байхын тулд одоогийн насны бүлгийнхэн бага сургуульд цаг хугацаандаа элсэн суралцах шаардлагатай. Дэлхийн түвшинд бага боловсролын нэгдүгээр ангийн тохируулгат элсэлтийн цэвэр жин 2017 онд 86% байсан.

2017 оны байдлаар бага боловсролын насны 64 сая хүүхэд буюу 9% нь сургуулийн гадна байсан бол 61 сая бүрэн бус дунд боловсролын насны өсвөр үеийнхэн (16%), 138 сая бүрэн дунд боловсролын насны залуу үеийнхэн (36%) мөн сургуульд хамрагдаагүй байна. Бага

боловсролын энэ үзүүлэлт нь 2008 оноос хойш бараг өөрчлөгдөөгүй байна. Сахар орчмын Африкийн улс орнуудын бага сургуулийн наснаас бусад үзүүлэлтэд эзлэх хувь өсөж байна. Бусад бүсэд ялангуяа, Баруун Азид зөрчилдөөний улмаас хүүхдүүд сургуулиа орхиход хүрч байна (Зураг 7).

ЗУРАГ 7:

Сахар орчмын Африкийн улс орнуудын сургуулиас гадуурх дэлхийн хүн амд эзлэх хувь нэмэгдэж байна
Сургуулиас гадуурх хүн амын тархалт бүс нутгаар, 2000–2015 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig8_2
Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн.

Дөрөвдүгээр ангийн суралцагчдаас таван жил тутам авдаг Олон Улсын Унших Чадварын Судалгаа нь сурлагын амжилтын талаарх олон улсын түвшний үзүүлэлтийн хүрээнд улсуудыг харьцуулах боломжтой үндсэн шинэ

мэдээллийг гаргаж байна. Исламын Бүгд Найрамдах Иран Улсын чадвар эзэмшилтийн доод түвшинд хүрсэн сурагчдын хувь 2001 онд 56% байсан бол 2016 онд 65% хүрсэн буюу жилд нэг арай хүрэхгүй пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Морокко, Оман зэрэг зарим улс 2030 оны зорилтот түвшинд хүрэхүйц сайжирсан үзүүлэлттэй байгаа бол Азербайжан, Саудын Араб, Өмнөд Африк зэрэг улсад чадвар эзэмшилтийн доод түвшинд хүрсэн үзүүлэлттэй суралцагчдын эзлэх хувь өсөөгүй байгаа нь зорилтот түвшинд хүрэхэд нэн бэрхшээлтэй болохыг илтгэн харуулж байна.

БОЛОВСРОЛ 2030 ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД ТӨГСӨЛТИЙН ХУВИЙГ ШИНЭЭР ТООЦООЛОХ НЬ

2013–2017 оны өрхийн судалгааны мэдээллийн дагуу сургууль төгсөлтийн үзүүлэлт нь бага боловсролын түвшинд 85%, бүрэн бус дунд боловсролын түвшинд 73%, бүрэн дунд боловсролын түвшинд 49% тус, тус байна. Гэвч өрхийн судалгаа болон хүн амын тооллогуудын мэдээлэл нь цаг хугацааны хувьд хоцордог ба олон төрлийн эх сурвалжууд хоорондоо зөрүүтэй мэдээллээр хангах нь бий.

Эрүүл мэндийн хяналт-шинжилгээний жишээтэй үялдуулан БХШД тайлангийн баг төгсөлтийн үзүүлэлтийг тооцоолох загварыг боловсруулсан. Ахиу насны бүлгийн төгсөлтийн үзүүлэлтийг буцаан тооцоолсноор тухайн орны үзүүлэлтийн өргөтгөсөн урт хугацааны дүр зургийг гаргах боломжтой. Тус үзүүлэлтийн одоогийн түвшинг хамгийн сүүлийн үеийн тоон мэдээллээс богино хугацааны тоо баримтыг түшиглэн тооцоолж болно. Энэхүү аргачлал нь хамгийн сүүлийн үеийн бэлэн байгаа бодит хэмжигдэхүүнээс илүүтэйгээр бүх тоон мэдээллийн эх сурвалжууд дахь ерөнхий дүр зураг, чиг хандлагуудыг нийцүүлэх байдлаар тооцоолдог.



ЗОРИЛТ 4.2

Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол, асаргаа нь танин мэдэхүйн болон нийгэм-сэтгэлзүйн хөгжилд маш чухал бөгөөд эмгэгт хүргэхүйц хямралын нөхцөлд нэн чухал хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.

Сургуульд элсэх албан ёсны наснаас өмнөх нэг жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдсан байдлын талаарх олон улсын түвшний үзүүлэлт нь бага орлоготой орнуудад 42%, өндөр орлоготой орнуудад 93%-тай байгаа бөгөөд дэлхийн дундаж түвшин 69% буюу удаан боловч тогтмол өсч байгаа чиг хандлагатай байна. Эсрэгээрээ, зарим оронд нэг жил, өөр бусад оронд дөрвөн жил үргэлжлэх сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 2017 онд 50%-д хүрчээ (Зураг 8).


Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн талаарх олон улсын түвшний нэг үзүүлэлт нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (БНХИ)-ээр

Бага нас

ЗУРАГ 8:

10 хүүхдийн 7 нь бага сургуульд элсэн орохоос өмнөх нэг жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна

Сургуульд элсэх албан ёсны наснаас өмнөх нэг жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдсан байдал ба сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин, 2000–2016 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig9_2

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн.

тодорхойлогддог бөгөөд үүнийг ихэвчлэн НҮБ-ын Хүүхдийн Сангийн Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа (ОУТС)-ны мэдээллээр тооцоолдог. НҮБ-ын Хүүхдийн Сангаас БНХИ-ийн аргачлалыг нягталж, сул талуудыг анхааран авч үзэж байгаа бөгөөд энэхүү үйл явцыг 2018 оны сүүлээр дуусгахаар төлөвлөж байна.

Таван жилийн хугацаанд хоёр удаагийн ОУТС-нд оролцсон улс орнуудын үр дүнгээс харахад бичиг үсэг, тоо тооллын чадварын зохих түвшинд байгаа 3-4 насны хүүхдүүдийн эзлэх хувь жилд дунджаар нэг пункт арай хүрэхгүй хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэсэн хэдий ч сургуульд ороход 'бэлэн' байх болон 'хөгжлийн хувьд зохих түвшинд' байх нь ойлгоход ярвигтай ойлголт бөгөөд дэлхий даяар үүнийг өөр, өөр байдлаар тайлбарладаг. Улс орнууд өөрсдийн хэрэгцээг хангах, тогтолцооны бүтэц, соёлын онцлог шинжүүдэд нийцсэн хэмжигдэхүүнийг ашиглах боломжтой байх хэрэгтэйг үгүйсгэхгүй.

Гэвч сургуульд бэлтгэгдсэн байдалд хяналт-шинжилгээ хийдэг үндэсний тогтолцоо бараг байдаггүй. Улс орнууд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүний нөөц, сургалт, барилга байгууламж, сургалтын хөтөлбөрийн стандартуудад хяналт-шинжилгээ хийх (жишээ нь, Энэтхэг улсын 2013 оны Бага насны хүүхдийн асаргаа, боловсролын талаарх үндэсний бодлого) эсвэл хөтөлбөрийн үр нөлөөлөлд үнэлгээ хийх (жишээ нь, АНУ-ын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн Үндэсний Тайлагналын Тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг) үндэсний тогтолцоо, бодлого журмуудтай байх нь илүү түгээмэл байдаг. Дэлхийн Банкны Боловсролын үр дүнг илүү чанартай болгох тогтолцооны аргачлалын бага насны хүүхдийн хөгжлийн модулиас харахад бага, дунд орлоготой 34 орны ердөө найм нь хүүхдүүдийн талаарх мэдээллийг дөрвөн чиглэлийн үзүүлэлт (танин мэдэхүй, хэлзүй, бие эрхтний болон нийгэм-сэтгэлзүйн хөгжил)-ийн хүрээнд цуглуулсан байна.

Өмнөд Африкийн 2014 оны Үндэсний сургалтын хөтөлбөрт албан бус, ажиглалтын, явцын үнэлгээг бага насны хүүхдийн суралцахуй болон хөгжлийн зургаан чиглэлээр авч үздэг ба аливаа оноо, хувиар илэрхийлээгүй боловч бага боловсролын бэлтгэл ангийн бэлэн байдлыг баримтжуулдаг байна. 2014 оноос хойш хуучин Югославын Бүгд Найрамдах Македони Улс сургуулийн өмнөх боловсрол, асаргааны төвд хамрагдсан бүх хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн хавтаст тэмдэглэгээг тогтмол хөтөлдөг болжээ.



ЗОРИЛТ 4.3

Техник, мэргэжлийн, дээд болон насанд хүрэгчдийн боловсрол

“

Насанд хүрэгчдийн боловсролд хамрагдалтын талаарх олон улсын түвшний үзүүлэлтийг албан болон албан бус боловсролын боломжуудыг ажил мэргэжилтэй холбоотой эсэхээс үл хамааруулан тусгахаар шинэчилсэн.

”


Насанд хүрэгчдийн боловсролд хамрагдалтын талаарх олон улсын түвшний үзүүлэлтийг албан болон албан бус боловсролын боломжуудыг ажил мэргэжилтэй холбоотой эсэхээс үл хамааруулан тусгахаар шинэчилсэн. Үйлчилгээ үзүүлэгчдийн олон янзын төрөл болон тооноос шалтгаалан ажиллах хүчний судалгаанд захиргааны мэдээллийг эх сурвалж болгон ашиглахыг илүүд үздэг боловч эдгээр судалгааны асуултууд улс орнуудад өөр, өөр байдаг бөгөөд шинэчилсэн үзүүлэлтийн тодорхойлолттой зөвхөн цөөн тооны асуултууд нийцэж байна. Асуултуудыг стандартчилан харьцуулах боломжтой тоон мэдээлэл бүхий улс орнуудын тоог нэмэгдүүлнэ гэдэг нь хялбар ажил биш.

Европын Холбооны Ажиллах хүчний судалгаа нь судалгаа авахаас өмнөх сүүлийн дөрвөн долоо хоногт (олон улсын түвшний үзүүлэлтэд 12 сарын хугацааг авч үздэг) хамрагдсан албан боловсрол, сургалтыг тооцдог. Улс орнуудад өөр, өөр чиг хандлагатай боловч хамрагдалтын түвшин тогтвортой хэвээр буюу дунджаар 11% байна (Зураг

ЗУРАГ 9:

Европт насанд хүрэгчдийн боловсролд хамрагдах нь тогтвортой байгаа ч чиг хандлага улс орон бүрээр өөр, өөр байна

Насанд хүрэгчдийн боловсрол, сургалтад хамрагдалтын түвшин сүүлийн дөрвөн долоо хоногт, Европын Холбоо ба сонгогдсон зарим улс, 2008 - 2017 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig10_1
Эх сурвалж: Евростат (2018).

9). Египет, Йордан болон Тунис улсын Хөдөлмөрийн Зах Зээлийн Интеграцчилсан Судалгаа нь ажил хөдөлмөр эрхэлж буй иргэд, насан туршийн оролцоо болон ажил мэргэжилтэй холбоотой техник, мэргэжлийн боловсрол, сургалтыг л авч үздэг. Эдгээр судалгаанаас харахад техникийн үр чадвартай ажилтнуудын дунд жил бүрийн сургалтад хамрагдагсдын түвшин дөрөв хүртэл хувиар өссөн байна.

Дээд боловсролд хамрагдалтын бохир жин 2017 онд 38% хүрсэн боловч дээд боловсролын нийт өртөгт эзлэх хувийн зардлын түвшин нэмэгдсээр байна. Оюутны зээл, буцалтгүй зээл, нөхөн төлбөр, тэтгэлэг зэрэг хэлбэрээр олгож буй санхүүгийн тусламжаас харахад Европт дээд боловсрол харьцангуй өртөг багатай байхад Сахар орчмын Африкийн орнуудад хамгийн өндөр өртөгтэй байна. Ихэнх

оронд дээд боловсролын өртөг үндэсний дундаж орлогын 60%-аас дээш хувийг эзэлж байхад Гвиней болон Уганда улсад 300% байна.

Боловсролын ихэнх тогтолцоо нь санхүүгийн дэмжлэгийг зорилтот бүлэгт үзүүлэхийг зорьдог ч зорилтот бүлгийг тодорхойлж буй байдлын үр дүн маш их ялгаатай байна. Дэлхийн Банкны мэдээллээс үзэхэд бага, дунд орлоготой хэд хэдэн оронд хамгийн ядуу бүлэгт хамаарах өрхүүд хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдтэй харьцуулахад засгийн газрын тэтгэлэг авах магадлал багатай байна. Колумби, Вьетнам зэрэг оронд хэрэгжиж буй олон янзын аргачлал бүхий цогц бодлогын багц нь дан ганц тэтгэлэг олгох хөтөлбөртэй харьцуулахад илүү амжилттай байна.



Хөдөлмөр эрхлэх үр чадвар

ЗОРИЛТ 4.4

“
Өндөр орлогтой орнуудын насанд хүрсэн 10 иргэний 3 нь цахим шууданд баримт бичгээ хэрхэн хавсаргахыг мэдэхгүй байна.



МХТ болон цахим бичиг үсгийн чадварын талаарх олон улсын түвшний болон сэдэвчилсэн үзүүлэлтүүд нь бичиг үсэг, тоо тооллын чадвараас илүүтэйгээр дэлхий нийтэд ажил хөдөлмөр эрхлэхэд чухалд тооцогдох болсон үр чадварын талаарх мэдээллийг харуулахыг зорьж байна. Эдгээр үзүүлэлтүүдийн хүрээнд засгийн газрууд сургуулиас гадуур эзэмших үр чадваруудыг мөн тооцож үзэх шаардлагатай байна.

МХТ-ийн үр чадвартай залуучууд, насанд хүрэгчдийн талаарх олон улсын түвшний үзүүлэлт нь өрхийн судалгаан дахь судалгаа авахаас өмнөх

гурван сарын хугацаанд хийгдсэн өөрийн тайлагнасан сонгогдсон үйл ажиллагааны талаарх мэдээлэл дээр үндэслэдэг. Олон улсын харилцаа холбооны байгууллага (ОУХБ)-ын хамгийн сүүлийн үеийн мэдээллээс харахад файлыг хуулбарлах болон емейлд хавсаргах нь дунд орлоготой орнуудын судалгаанд хамрагдагсдын гурван хүн тутмын нэг нь хийж чаддаг цорын ганц үр чадвар байна. Тус үзүүлэлтүүд өндөр орлоготой орнуудад 58% болон 70%-тай байна (Зураг 10). Программчлал нь өндөр хөгжилтэй орнуудын хувьд ч хамгийн бага хийдэг үйлдэл хэвээр байна.

Цахим бичиг үсгийн үр чадварын талаарх олон улсын түвшний үзүүлэлт нь МХТ-ийн төхөөрөмжийг ашиглахаас өндөр үр чадварыг авч үздэг. Цахим бичиг үсгийн үр чадварын талаарх олон улсын түвшний шинэ хүрээ нь Европын Хорооны ДижКомп хүрээг өргөтгөж бага, дунд орлоготой улс орнуудын соёл, эдийн засаг, технологийн нөхцөлийг тусгасан жишээүүдийн илүү өргөн цогц агуулгыг багтаадаг болсон. Тухайлбал, фермерүүдэд шаардлагатай үр чадварт гар утас ашиглаж фирмийн аж ахуй эрхлэх, худалдан борлуулах шийдвэр гаргах, ухаалаг утасны аппликейшнээр дамжуулж худалдан авалт, борлуулалт хийх эсвэл зөөврийн компьютертэй холбогдсон чийг мэдрэх төхөөрөмж ашиглан мэдээллийн санд тулгуурласан усалгааны системийг бий болгох зэргийг хамруулж болно.


Зардал багатай бөгөөд үр дүнтэй аргачлалуудыг тодорхойлж эдгээр цогц чадамжуудыг хэмжих нь томоохон сорилт хэвээр байна. Цахим бичиг үсгийн үр чадварын талаарх үнэлгээнүүд нь зорилго, зорилтот бүлэг, агуулга, хэрэгжилт, зардал, хариуцлага хүлээх эрх бүхий байгууллагуудын хувьд ялгаатай байдаг. Жишээ болгон сонирхуулахад Франц улсад цахим бичиг үсгийн үр чадварыг үнэлэх үнэлгээнд иргэд үнэ төлбөргүй хамрагддаг ба үүний давуу, сул талуудыг оношлох, сургалтын нөөцийн талаарх зөвлөмжүүдийг гаргах нь дараагийн алхам байж болох юм.

Бизнесийн цогц чадамжийг үнэлэх талаарх зорилт 4.4-т үзүүлэлт тодорхойлоогүй байгаа ба дээрхтэй ижил төрлийн бэрхшээл тулгарч байна. Нийгэм, сэтгэлзүйн үр чадварууд болох шаргуу зан, өөрийгөө хянах чадвар зэрэг нь бизнес эрхлэхэд шаардлагатай олон төрлийн үр чадварын нэгэн хэсэг боловч тэдгээрийг хэмжихдээ соёл хоорондын ялгаатай байдлыг тайлбарлан ойлгоход хянамгай хандах шаардлагатай. ОУХАХБ-аас 10 болон 15 настай хүүхдүүдийн дунд хийх нийгэм, сэтгэлзүйн үр чадварын олон улсын судалгааг боловсруулж байна.

ЗУРАГ 10:

МХТ-ийн үр чадвар тэгш бус тархалттай хэвээр байна

Өмнөх гурван сард компьютер ашиглан тодорхой үйлдэл хийсэн насанд хүрэгчдийн хувь, улс орны орлогын бүлгээр, 2014–2017 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig11_1

Тэмдэглэл: Дундаж орлоготой улс орнуудын медианыг цөөхөн тооны улс орныг хамруулан тооцсон (дундаас доогуур орлоготой таван орон, дундаас дээгүүр орлоготой 15 орон). Эх сурвалж: ОУХБ-ын мэдээллийн сан.



ЗОРИЛТ 4.5

Тэгш боломж


Дэлхий даяар бага, дунд боловсролын түвшин дэх дундаж үзүүлэлтээр жендерийн тэгш байдал ерөнхийдөө хангагдсан байна. Гэвч дэлхийн дундажийн ард улс орны түвшин дэх жендерийн ялгаатай байдлууд нүүгдмал байна. 2016 оны байдлаар улс орнуудын 54% нь бага, бүрэн бус дунд боловсролын түвшинд жендерийн тэгш байдлыг хангаж чадсан бол 22% нь бүрэн дунд боловсролын түвшинд жендерийн тэгш байдлыг хангаж чадсан байна. Цаашилбал, жендерийн тэгш байдалд хүрч чадсан улсуудын зарим нь энэ байдлаа тогтвортой хадгалж чадахгүй байна.

Өөр нэг томоохон ялгаатай байдал нь байршил, орлогын түвшнээс хамааран сургууль төгсөлтийн хувь өөр, өөр байгаа явдал юм. Бага, дунд орлоготой орнуудын хөдөөгийн суралцагчдын хувьд бүрэн дунд боловсролыг дүүргэх боломж хот, суурин газрын үеийнхнийхтэй нь харьцуулахад дөнгөж тал хувьтай нь тэнцүү байна (Зураг 11).

ЗУРАГ 11:

Олон улс оронд нэн ялангуяа дунд боловсролын төгсөлтийн хувьд байршил, өрхийн аж байдлын түвшин дэх ялгаатай байдал арилахгүй хэвээр байна

Боловсролын түвшингээр сургууль төгсөлтийн хувь дахь жендер, байршил, аж байдлын тэгш байдлын индекс, 2014–2017 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig12_1

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн болон БХШД-ийн тайлангийн багийн өрхийн судалгаанд тулгуурласан тооцоолол

Байршилд тулгуурласан ялгаатай байдлыг хэмжихэд харьцуулах боломж бага байгаа нь саад учруулж байна: газар тариалан эрхлэх хөдөлмөрлөх хүчний эзлэх хувь, хүн амын тоо хэмжээ, хүн амын нягтаршил, үндэсний онцлогийг тусгасан шалгуур үзүүлэлтүүд эсвэл тэдгээрийн аливаа нэгдэл нь улс орнуудын түвшинд ‘хөдөө’, ‘хот’ гэсэн байршлын ангиллыг тодорхойлдог.

2016 онд зохион байгуулагдсан НҮБ-ын Хүн Амын Нутагшил, Сүүрьшлын Хөтөлбөрийн гуравдугаар бага хурлын дараагаар ТХЗ-уудын хяналт-шинжилгээг дэмжих зорилгоор хот, суурин газруудын хүн амд суурилсан олон

“

Бага, дунд орлоготой орнуудын хөдөөгийн суралцагчдын хувьд бүрэн дунд боловсролыг дүүргэх боломж хот, суурин газрын үеийнхнийхтэй нь харьцуулахад дөнгөж тал хувьтай нь тэнцүү байна

”

улсын тодорхойлолтыг боловсруулж, 2019 оноос мөрдөх гэж байна. Энэ нь захиргааны мэдээллийн ангиллуудыг зайнаас тандан судалсан тоон мэдээлэл болон хүн амын тооллогын дүнтэй харьцуулах юм. Гайхалтай нь Африк, Азийн хүн амын тэн хагасаас доош хувь хот, суурин газар амьдарч байгаа гэсэн тооцоолол улс орнуудын тодорхойлолтын дагуу гарч байхад 2018 оны тооцоолоос харахад 80%-аас дээш нь хот, суурин газарт амьдарч байна. Хөдөөгийн хүн амын боловсролын үр дүнгийн талаарх өнөөгийн тооцоололд үнэн хэрэгтээ хотод амьдардаг суралцагчдын мэдээллийг багтаадаг нь хөдөө орон нутгийн үнэн дүр зургийг бүрхэгдүүлэхэд хүргэх талтай.



ЗОРИЛТ 4.6

Бичиг үсэг ба тоо тооллын чадвар

2017 оны байдлаар дэлхийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин 86% хүрсэн боловч Сахар орчмын Африкийн орнуудад 65%-тай хэвээр байна. Залуучуудын бичиг үсэгт тайлагдалтад гарсан ахиц болон энэ насны бүлгийнхний хүн амд эзлэх хувь буурсантай холбоотойгоор 15-24 насны бичиг үсэг үл мэдэх залуучуудын бодит тоо сүүлийн жилүүдэд хурдтай буурч байгаа бөгөөд ялангуяа Ази тивд ахиц өндөр байна. Гэвч бичиг үсэг үл мэдэх 65 ба түүнээс дээш насны ахмад настны тоо өссөөр байна. Бичиг үсэгт тайлагдаагүй ахмад настны тоо бичиг үсэг үл мэдэх залуучуудаас бараг 40%-аар илүү байна (Зураг 12).


Өрхийн гишүүдийн нэг нь ч уншиж чаддаггүй өрхийн бичиг үсгийн ямар ч чадваргүй иргэдийг бичиг үсэгт тайлагдсан нэг ба түүнээс дээш тооны гишүүнтэй өрхөд амьдарч буй бичиг үсэгт арай тайлагдаагүй иргэдтэй харьцуулахад хөдөлмөрийн зах зээл болон амьдралын үр ашгийн чанарын хувьд илүү муу нөхцөлд байна.

Бичиг үсэг огт мэддэггүй иргэд хөдөө орон нутагт илүү олон байна. Чинээлэг орнуудад бичиг үсэгт огт тайлагдаагүй иргэд бичиг үсэгт арай тайлагдаагүй бүлэгтэй харьцуулахад насны хувьд харьцангуй ахмад байхад ядуу улс орнуудад энэ нь урвуу хамааралтай байна. Үүнийг ядуу орнуудад бичиг үсгийн чадваргүй ихэнх иргэд олон насны өрхийн гишүүдтэйгээ хамт нэг дор амьдардагтай холбон тайлбарлаж болох тул тэд өөрсдөөсөө насны хувьд залуу бөгөөд илүү боловсролтой гэр бүлийн гишүүдтэй хамт амьдардаг байх магадлалтай байдаг.

ЗУРАГ 12:

Бичиг үсэг үл мэдэх залуучуудаас бичиг үсэгт тайлагдаагүй ахмадуудын тоо 40%-аар илүү байна

Бичиг үсэг үл мэдэх залуучууд, ахмадуудын тоо, 2010–2016 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig13_1

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн.

Тиймээс бичиг үсгийн чадвар олгох хөтөлбөрүүдийг чинээлэг орнуудын хувьд ганцаараа эсвэл хоёулаа амьдардаг өрхийн ахмадуудад харин ядуу буурай орнуудад болон хөдөө орон нутагт ихэвчлэн амьдардаг нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг залуучуудад чиглүүлэх хэрэгтэй.



Тогтвортой хөгжил ба дэлхийн иргэншил


ЗОРИЛТ 4.7

Олон улсын харилцан ойлголт, хамтын ажиллагаа болон хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой энх тайвны боловсролын талаарх 1974 оны ЮНЕСКО-ийн Зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх зургаа дахь удаагийн зөвлөлдөх уулзалтад оролцсон 83 улсын нөхцөл байдалд суурилан Зорилт 4.7-ийн олон улсын түвшний үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнаж байна. Эдгээр улс орны 80 гаруй хувь нь дээрх зөвлөмжийн тэргүүлэх зарчмуудыг суралцагчдын үнэлгээнд, харин бараг бүх улс орон сургалтын хөтөлбөртөө тусгасан гэж мэдэгджээ. Гэвч улс орнуудын ердөө 17% нь эдгээр зарчмуудыг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт бүрэн тусгасан байна (Зураг 13).

ЗУРАГ 13:

Улс орнуудын ердөө 17% нь хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмуудыг багшийн мэргэжил дээшлүүлэх боловсролд бүрэн тусгажээ

1974 оны ЮНЕСКО-ийн Зөвлөмжид тусгагдсан зарчмуудыг боловсролын бодлого, багшийн боловсрол болон сургалтын хөтөлбөрт тусгасан улс орнуудын эзлэх хувь, 2012–2016 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig14_1
Эх сурвалж: ЮНЕСКО (2018).

Боловсролын Үр Дүнгийн Үнэлгээний Олон Улсын Холбооны 2016 оны Олон улсын иргэний болон иргэншлийн талаарх судалгаагаар ихэнхдээ өндөр орлоготой 24 орны наймдугаар ангийн сурагчдын ойлголт, мэдлэг, хандлага болон ухамсарлах чадварт дүн шинжилгээ хийжээ. Сурагчдын 35% нь дөрвөн түвшинд хамгийн өндөр оноо авч,

нийгэм, улс төрийн байгууллага, тэдэнд хяналт тавьдаг хууль болон институцийн механизмууд хоорондын үйл явцын уялдаа холбоог ойлгож байхад 13% нь хамгийн доод оноо авчээ.

11 улс 2009 болон 2016 оны судалгаануудын дүнг харьцуулахад огцом сайжирсан үзүүлэлттэй байгаа бол нэг ч улс орны хувьд огцом буурсан үзүүлэлт байхгүй байна. Оролцогчдын үндэс угсаа, арьс өнгөөр ялгаатай нийгмийн бүлгүүдэд чиглэсэн тэгш эрх, эерэг хандлагыг хүлээн зөвшөөрөх байдал мөн сайжирсан байна. Охид, иргэний боловсрол, улс төрийн асуудлуудыг сонирхдог сурагчид болон иргэний асуудлуудын талаарх мэдлэг өндөртэй сурагчид илүү эерэг хандлагатай байна. Хувьсах үзүүлэлтүүдийг тус бүрээр нь авч үзвэл эдгээр нь багш-сурагчдын харилцаа, иргэний боловсролын сургалт, сургууль болон анги доторх хэлэлцүүлэг нээлттэй байх зэрэг сургуулийн үйл явцын асуудлуудын талаарх эерэг хандлагуудтай илүү хамааралтай байна.



ЗОРИЛТ 4.а

Дэлхийн хэмжээнд сургуулиудын 69% нь үндны усны хангамжтай, 66% нь ариун цэврийн, 53% нь эрүүл ахуйн хувьд суурь болон түүнээс дээгүүр түвшний үйлчилгээтэй байна (Зураг 14). Йордан улсад сургуулиудын 93% нь үндны усны хангамжтай боловч дөнгөж 33% нь суурь түвшний ариун цэврийн байгууламжтай байна. Либанон улсад сургуулиудын бараг 93% нь суурь түвшний ариун цэврийн байгууламжтай байхад 60% нь үндны усны хангамжтай байна. Бага сургуулиудад дунд сургуулиудтай харьцуулахад үйлчилгээний чанар доогуур байна.


Сургалтын орчны аюулгүй байдал, тэгш хамран сургалтын талаарх цөөн тооны асуудлын хувьд дэлхийн түвшинд хяналт-шинжилгээг бүрэн хийдэг. Дээрэлхэлт зэрэг ойлголтын хувьд олон улсын түвшинд стандарт тодорхойлолт байхгүй бөгөөд судалгаанууд энэ асуудлыг олон янзаар авч үздэг. 11-15 насны хөвгүүдийн бараг 40%, охидын 35% нь дээрэлхэлтэд өртсөн талаарх тооцооллыг нэгэн судалгаагаар хийжээ. Бие махбодын шийтгэлийг хуулиар хориглосон улс орнуудын тоо 2014 онд 122 байсан нь 2018 онд 131 болж өсчээ.

Сургуулийн барилга байгууламж ба сургалтын орчин

ЗУРАГ 14:

10 сургууль тутмын 7 болон түүнээс цөөн сургууль суурь түвшний шаардлага хангах үндны усны хангамжтай

Үндны усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байдал үйлчилгээний түвшингээр, 2016 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig15_1

Тэмдэглэл: Тоог тоймлон авсан тул нийлбэр нь бүх тохиолдолд 100% биш.

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ (2018).

2013 - 2017 оны хооронд боловсролын салбарт 12,700 гаруй дайралт халдлага гарч 21,000 суралцагч, багш нарт хор хохирол үзүүлсэн талаар Боловсролыг Дайралт Халдлагаас Хамгаалах Дэлхийн Эвслээс мэдээлжээ. Албан ёсоор мэдээлсэн хэргүүдэд сургууль, суралцагчид, багш нарын бие махбодод халдсан эсвэл халдахаар заналхийлсэн,

“ 2013 - 2017 оны хооронд боловсролын салбарт 12,700 гаруй дайралт халдлага гарсан байна. ”

боловсролын байгууллагыг цэргийн зорилгоор ашиглах, хүүхдийг дайчлах, суралцагчид сургууль, их сургууль дээрээ болон ирж, очих замдаа зэвсэгт этгээдүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөх, их, дээд сургуулиудад халдах зэрэг багтаж байна. 28 улс дор хаяж 20 удаагийн халдлагад өртөж хохирсон бөгөөд Нигерь, Филиппин болон Иемен зэрэг улсын хувьд 1000 гаруй удаагийн халдлага болжээ.

Дээр дурдсан эвслийн тоон мэдээлэлд эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн халдлага болон зэвсэглэсэн этгээдүүд сургууль дээр гал нээх зэрэг тодорхой халдлагуудын талаарх баримт мэдээлэл байхгүй байна. АНУ-д 1999 оноос хойш 193 сургуулийн дор хаяж 187,000 суралцагч галт зэвсгийн халдлагын гэрч болжээ.



Сургалтын тэтгэлэг

ЗОРИЛТ 4.6


Хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдийн хүрээнд санхүүжигдсэн тэтгэлгийн хэмжээ 2010 оноос хойш 1.1-1.2 тэрбум ам.долларын орчим зогсонги байдалтай байна (үүнд суралцагчдын өөрсдийн хариуцсан зардал орохгүй). Гэвч тэтгэлэгт хамрагдсан хүмүүсийн тоо эсвэл хөгжлийн тусламжийн хөтөлбөрөөс гадуур олгосон тэтгэлэг хүртсэн хүмүүсийн тооны талаарх мэдээлэл байхгүй байна.

Бүс нутгаасаа гадагш суралцаж буй олон улсын оюутны эзлэх хувь нэмэгдэж байгаа ч Европын ихэнх оюутнууд нилээн эрчтэй солилцооны хөтөлбөрүүдийн хүрээнд бүс нутаг дотроо шилжин суралцаж байна. Тэдний гадагш чиглэсэн хөдөлгөөний хувь боловсролын түвшин өсөх тусам нэмэгдэж байгаа буюу бакалаврын түвшинд 3%, магистрын түвшинд 6%, докторын түвшинд 10%-ийн үзүүлэлттэй байна (Зураг 15).

ЗУРАГ 15:

Европт оюутны хөдөлгөөн боловсролын түвшин өсөх тусам нэмэгддэг

Гадагш чиглэсэн хөдөлгөөний хувь Боловсролын түвшинээрх Олон Улсын Стандарт Ангиллаар, Европын сонгогдсон орнуудаар, 2013 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig16_3

Тэмдэглэл: ISCED = Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (International Standard Classification of Education): бакалаврын зэрэг (ISCED 6); магистрийн эсвэл түүнтэй дүйцэх зэрэг (ISCED 7); докторын болон түүнтэй дүйцэх зэрэг (ISCED 8).

Эх сурвалж: Flisi et al. (2015).

“


Европын Холбооны дээд боловсрол эзэмшигчдийн 20%-оос доошгүй нь гурваас дээш сарын хугацаатай эсвэл Европын кредит шилжүүлэх тогтолцооны 15 кредит цагтай тэнцэх цагийг гадаадад судалсан байх ёстой байдаг.

”

2020 Европын Холбооны Дээд Боловсролын Сургалтын Хөдөлгөөнт Байдлын харьцуулах үзүүлэлтийн дагуу Европын Холбооны дээд боловсрол эзэмшигчдийн 20%-оос доошгүй нь гурваас дээш сарын хугацаатай эсвэл Европын кредит шилжүүлэх тогтолцооны 15 кредит цагтай тэнцэх цагийг гадаадад судалсан байх ёстой байдаг.

Оюутнуудын үндсэн сургуулиуд нь түр зуурын шилжилтийн үеийн кредитийг тооцсон талаарх мэдээллийг өгөх боломжтой бол хүлээн авагч улс орнууд боловсролын зэргийн шилжилтийн талаарх мэдээг өгөх шаардлагатай. Европын Холбооны улсууд энэ талаарх мэдээллийг заавал тайлагнах ёстой боловч эдгээр улсын оюутнуудын ихэвчлэн очиж суралцдаг Европ тивээс гаднах улсуудаас зөвхөн Австрали, Бразил, Канад,

Чили, Израйль, Шинэ Зеланд шаардлагатай мэдээллийг өгдөг байна. АНУ төдийгүй Хятад, Энэтхэг, Япон, Мексик болон Бүгд Найрамдах Солонгос Улс мэдээлэл өгдөггүй байна. Мэдээлэл дутмагийн улмаас одоогийн 20% гэсэн тооцоололд гадагш чиглэсэн хөдөлгөөнийг дутуу тусгасан байх магадлалтай.



ЗОРИЛТ 4.В

Багш нартай холбоотой үзүүлэлтүүдийн талаарх олон улсад харьцуулах боломжтой мэдээлэл цуглуулах нь бэрхшээлтэй хэвээр байна. Харьцангуй цөөн улс орон харьцуулах боломжтой мэдээллийг ялангуяа дунд боловсролын түвшинд багш нарын орон тооны талаарх хамгийн энгийн тодорхойлолтод үндэслэн гаргаж байгаа ба энэ нь хичээл зааж буй цаг, захиргааны албан тушаалд ажиллаж байгаа багш нарын тоо зэргийг орхигдуулсан байдаг.

Бага болон дундаас доогуур орлоготой орнуудад мэргэжлийн болон мэргэшсэн бага боловсролын багш нар нэн дутагдалтай хэвээр байна. Сахар орчмын Африкийн зарим оронд багш нарыг ажилд авах хувь өндөр байгаа ба багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцооны чадавх хязгаарлагдмал үед багшаар ажиллаж эхлэх үеийн стандартыг зөрчих тохиолдол их байна. Нигерь улсад бага боловсролын багш нарын 13% нь 2013 онд шинээр ажилд орсон бөгөөд тэдний ердөө 37% нь мэргэжлийн багш нар байна (Зураг 16).


Ажлын байрны эрэлт өндөр байгааг боловсролын салбарын тэлэлт хэмээн шууд үзэж болохгүй; энэ нь ажлаас гарсан багш нарыг нөхөх шаардлагатай хамааралтай байж болох юм. Ажлаас гарч байгаа багш нарын талаарх мэдээллийн найдвартай байдал янз бүр бөгөөд үүнийг тайлбарлахад түвэгтэй байдаг. Нарийвчилсан тооцооллыг гаргахад нэг бүрчлэн тодорхойлсон бүртгэлийн дугаар бүхий боловсон хүчний талаарх тоон мэдээлэл

Багш нар

ЗУРАГ 16:

Ажлын байрны эрэлт өндөр нөхцөлд багшийн боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд бэрх байна

Сахар орчмын Африкийн сонгогдсон орнуудын шинээр ажилд орсон багш нар болон тэдний мэргэжлийн байдлын хувь, бага боловсролоор, 2010–2014 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig17_1

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн.

шаардлагатай бөгөөд багш мэргэжлээр ажиллах шаардлага хангасан хувь хүн тус мэргэжлийн тогтолцоонд шинээр орох, гарах болон эргэн орох үед тэднийг бүртгэн хянах боломжтой болдог. Ажлаас гарч байгаа, шинээр болон эргэн ажилд орж байгаа багш нарын талаарх тоон мэдээллийг ялгаатай байдлаар гаргах шаардлагатай. Хүний нөөцийн эргэлтэд хяналт-шинжилгээ хийхэд үндэсний тогтолцоо болон үйлчилгээний төрөл олонтой тогтолцооны тухайд бүх төрлийн сургуулиудын талаарх мэдээлэл шаардлагатай. Гэвч боломжит мэдээллүүд нь ихэвчлэн орон нутгийн түвшинд (тухайлбал, Бразил улс) эсвэл зөвхөн улсын сургуулийн түвшинд (тухайлбал, Уганда улс) л байдаг.

Чили, Швед болон АНУ зэрэг улсын судалгаанд туршлага багатай, мэргэшлийн түвшин өндөртэй (тиймээс хаана ч ажилд орох боломж ихтэй), хөдөө орон нутгийн эсвэл илүү бэрхшээлтэй сургуульд хуваарилагдсан, цалин хөлс хангалтгүй авдаг эсвэл богино хугацааны гэрээт багш нарын хувьд ажлаас гарах хувь өндөр байгааг тогтоожээ. Гэсэн хэдий ч Австралид урт хугацааны туршид хийсэн судалгаанд ажлаас гарсан багш нарын олонх нь гэр бүлийн шалтгаанаар гарсан бөгөөд хоёр жилийн дотор мэргэжлээрээ эргэн ажиллаж байсан талаар дурджээ.

Боловсрол ба бусад ТХЗ-ууд

Баталгаат ажлын байр, ээлтэй хот, болон мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх зэрэг замаар шударга ёсыг тогтоох талаарх ТХЗ-уудын хэрэгжилтийг боловсрол хэрхэн эрчимжүүлдэг талаар тус тайланд тусгалаа.

Баталгаат ажлын байр, эдийн засгийн өсөлтийн талаарх ТХЗ 8-д хүрэхэд шаардлагатай мэргэшсэн нийгмийн ажилтнууд олон оронд дутагдалтай байна. Этиоп улсад ярилцлагад хамрагдсан төрийн албаны нийгмийн ажилтнуудын 60% нь холбогдох боловсрол, мэдлэг дутагдалтай талаар дурджээ. Зарим орнууд холбогдох сургалтуудыг нэмэгдүүлж байна: тухайлбал, Хятад улс 2020 гэхэд шинээр 230,000 нийгмийн ажилтан бэлтгэхийг зорьж байна. Өмнөд Африкт нийгмийн ажилтнуудын тоо 2010 оноос 2015 оны хооронд 70%-аар нэмэгдсэн байна.

Дэлхийн хүн амын тэн хагас нь хот, суурин газар амьдарч буй энэ үед ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих талаарх ТХЗ 11-ийг хэрэгжүүлэхийн тулд хот төлөвлөгчдөд албан бус суурин газруудыг сайжруулж, ирээдүйд өсөн нэмэгдэх чиг хандлагад бэлэн байх шаардлага тулгараад байна. Олон улс оронд төлөвлөлтийн чиглэлийн мэргэжилтүүд нэн дутагдалтай байна (Зураг 17). Энэтхэг улс 2011 онд 4500 төлөвлөлтийн мэргэжилтэнтэй байсан бол 2031 он гэхэд 300,000 хот, хөдөөгийн төлөвлөлтийн мэргэжилтнүүд шаардлагатай байна. Төлөвлөлтийн хөтөлбөрүүд нь материаллаг бааз, хүрээлэн буй орчин болон боловсрол зэрэг нийгмийн төлөвлөлтүүдийг үйлдүүлэх шаардлагатай. Малави, Мозамбик, Намиби зэрэг улс орны орон нутгийн түвшний албан тушаалтнууд төлөвлөлтийн талаарх чадавхыг сайжруулах шаардлагатай.

Энх тайван, шударга ёсыг цогцлоох талаарх ТХЗ 16-г хэрэгжүүлэхэд хууль сахиулахын ажилтнуудын боловсролд тавигдах шаардлага, сургалтыг сайжруулах хэрэгтэй ба энэ нь итгэлцэл бий болгож, ялгаварлан үзэх үзэл болон хүч хэрэглэх байдлыг багасгана. АНУ-д цагдаагийн ажилтнуудын дундаж сургалт 19 долоо хоногийн хугацаатай бол Герман улсад энэ нь 130 долоо хоног байна. АНУ-ын цагдаагийн газруудын ердөө 1% нь ажилтнуудаа дөрвөн жилийн их сургуулийн боловсролтой байхыг шаарддаг ба хүч хэрэглэх магадлал их сургуулийн боловсролтой цагдаагийн албан хаагчдын дунд бага байдаг байна. Сингапур зэрэг зарим оронд цагдаагийн албан хаагчдын авилгалыг хязгаарлах зорилгоор сургалтад хамруулдаг бол Индонези зэрэг улсад цагдаагийн албан хаагчдын мэргэжлийн чадавхыг сайжруулах зорилгоор олон улсын түнш байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

Дэлхий даяар 4 тэрбум хүн шударга ёсыг хүртэж чадахгүй байгаа нь эрх зүйн чадавхыг бүрдүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна. Эрх зүйн боловсрол улс орнуудад харилцан адилгүй байна. Сургалт ихэвчлэн гурваас таван

ЗУРАГ 17:

Африк болон Азид хот төлөвлөлтийн ажилтнууд хэт цөөн байна
100,000 хүн амд ногдох хот төлөвлөлтийн ажилтнуудын тоо ба хотжилтын хувь, сонгогдсон орнуудаар



ДБХШ StatLink: http://bit.ly/fig18_2

Тэмдэглэл: Хот төлөвлөлтийн ажилтнуудын тоо 2011 он, хотжилтын түвшинг 2014 оны мэдээллийн сангаас авсан.

Эх сурвалж: НҮБЭЗНАГ (2014); НҮБ-ын Хүн Амын Нутагшил, Суурьшлын Хөтөлбөр (2016).

жилийн хугацаатай боловч эрх зүйн боловсролын чиглэлээрх зэрэг нь өндөр орлоготой орнуудад хүртэл шүүгч болох урьдчилсан шалгуурт тэр бүр багтдаггүй. Зарим оронд тухайлбал, Франц улсад шүүгчдийн томилгооны дараагаар тэднийг мэргэжлийн ур чадварын эрчимжүүлсэн сургалтад хамруулдаг байна. Гана, Йордан зэрэг улсад шүүгчдэд зориулсан үргэлжлүүлэн суралцах боловсрол, сургалтын байгууллагууд байдаг.

Санхүү


Боловсролыг санхүүжүүлэгч үндсэн гурван эх үүсвэр нь засгийн газар, хандивлагчид болон өрхүүд юм. Тус тайланд зориулан хийсэн дүн шинжилгээгээр дэлхий дахинд боловсролд жилд 4.7 триллион ам.долларыг зарцуулдаг гэсэн тооцооллыг гаргасан. Үүний 3 триллион ам.доллар (нийт дүнгийн 65%)-ыг өндөр орлоготой орнуудад, харин 22 тэрбум ам.доллар (нийт дүнгийн 0.5%)-ыг бага орлоготой орнуудад зарцуулдаг (Зураг 18а) хэдий ч эдгээр орнуудын сургуулийн насны хүүхдүүдийн тоо бараг тэнцүү байна. Нийт зардлын 79%-ийг засгийн газар, харин өрхүүд 21%-ийг эзэлж байна. Хандивлагчид бага орлоготой орнуудын боловсролын нийт зардлын 12%-ийг, харин дунджаас доогуур орлоготой орнуудад 2%-ийг санхүүжүүлж байна (Зураг 18б).

“ Дэлхий дахинд боловсролд жилд 4.7 триллион ам.доллар, үүний 65%-ийг өндөр орлоготой орнуудад зарцуулдаг . ”


ЗУРАГ 18:

Боловсролд зарцуулсан 5 ам.доллар тутмын 4 ам.долларыг засгийн газар санхүүжүүлдэг

а. Боловсролын нийт зардал, улс орнуудын орлогын бүлгээр, санхүүжилтийн эх үүсвэрээр, 2014 эсвэл хамгийн сүүлийн байдлаар



б. Боловсролын нийт зардлын бүтэц, улс орнуудын орлогын бүлгээр, санхүүжилтийн эх үүсвэрээр 2014 эсвэл хамгийн сүүлийн байдлаар



ДБХШ StatLink: http://bit.ly/fig19_1

Тэмдэглэл: Дүн шинжилгээг дараах гурван таамаглалд үндэслэв: (а) төсвийн зардлын талаарх мэдээлэлгүй орнуудын зардлыг ДНБ-ээс тооцсон ба төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь болон боловсролд зарцуулсан төсвийн зардлын дундаж хувийг улс орнуудын орлогын бүлгээр гаргав; (б) тусламжийн зарцуулалтын 60%-ийг улсын төсөвт тусгасан (тиймээс засгийн газрын зардлаас үүнийг хассан), харин үлдсэн 40%-ийг бусад сүвгаар хуваарилсан гэж тооцов; (в) боловсролын нийт зардалд өрхийн эзлэх хувийг өндөр орлоготой орнуудад 18%, дундаж орлоготой орнуудад 25%, бага орлоготой орнуудад 33% хэмээн тус, тус тооцоолсон.

Эх сурвалж: БХШД-ийн тайлангийн багийн ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэн (засгийн газар, өрх) болон CRS доноруудын датабазад суурилан хийсэн дүн шинжилгээ.

Төсвийн зардал

2017 оны байдлаар боловсролд зарцуулсан ДНБ-ий медиан нь дэлхийн хэмжээнд 4.4% байсан нь Боловсрол 2030 Үйл ажиллагааны хүрээнд зөвлөсөн хамгийн доод босго үзүүлэлт болох 4%-аас дээгүүр байна. Бүс нутгийн түвшинд Зүүн болон Зүүн Өмнөд Азид 3.4%-аас Латин Америк, Карибын орнуудад 5.1% хүрсэн далайцтай байна. Боловсролд зарцуулсан нийт төсвийн зарцуулалтын медиан 14.1% байгаа нь хамгийн доод босго үзүүлэлт болох 15%-аас доогуур, харин бүс нутгуудаар харвал далайц нь Европ, Хойд Америкт 11,6%-аас Латин Америк, Карибын орнуудад 18% хүрсэн байна. Нийтдээ 148 орны 43 нь босго үзүүлэлтүүдийг хангахгүй байна.

Улсын төсвийн боловсролд зарцуулсан зардлаас бага боловсролд зориулсан зардлын медиан нь 35% байгаа ба далайцын хувьд бага орлоготой орнуудад 47%-аас өндөр орлоготой орнуудад 26% байна. Дэлхийн түвшинд нийт боловсролын салбарын зардлын дунд боловсролд хуваарилагдсан медиан нь 35% байгаа ба энэ үзүүлэлт нь бага орлоготой орнуудад 27%-аас өндөр орлоготой орнуудад 37% хүрсэн далайцтай байна. Европ, Хойд Америкийн орнуудад бага болон дунд боловсролын дараах шатны сурагч нэг бүрт ногдох төсөв ижил хэмжээтэй байна. Сахар орчмын Африкийн орнуудад дунд боловсролын дараах шатны сурагч нэг бүрт ногдох зардал нь бага боловсролын сурагчийнхаас 10 дахин илүү байна.

Цагаачдыг хүлээн авагч орнуудад олон нийтийн мэтгэлцээний гол сэдэв нь цагаачдын нийгмийн халамжид үзүүлж буй нөлөө сөрөг байна гэх явдал юм. Нэг талаас, цагаачид уугуул иргэдтэй харьцуулахад ихэвчлэн хөдөлмөрийн насных байдаг ч орлого доогуур учраас татварын орлогыг бага бүрдүүлдэг. Нөгөө талаас, цагаачид ихэвчлэн нийгмийн халамжаас хараат байж, боловсрол зэрэг төрийн үйлчилгээнд хамрагддаг. Хэдий тийм ч цагаачдын хүүхдүүдийн боловсролд улсын төсвийг зарцуулахыг хөрөнгө оруулалт хэмээн үздэг. Тэд амьдралынхаа нийт хугацаанд төрөөс хүртэхээсээ илүүтэйгээр татвар болон нийгмийн хамгааллын шимтгэлд хувь нэмрээ илүү их оруулдаг. Цагаачлалын төсөвт үзүүлэх үр дагавар нь эерэг ч бай, сөрөг ч бай ДНБ-ий 1% дотор багтахаар буюу харьцангуй бага байдаг.

Тусламжийн зарцуулалт

2016 онд боловсролд үзүүлэх тусламж 2002 онд бүртгэж эхэлснээс хойш хугацаанд хамгийн өндөр түвшинд хүрсэн. 2015 онтой харьцуулахад боловсролд үзүүлэх тусламжийн хэмжээ 13.4 тэрбум ам.долларт хүрсэн нь 1.5 тэрбум ам.доллар буюу 13%-ийн бодит өсөлттэй байсан. Суурь боловсролд үзүүлсэн тусламж нийт өсөлтийн гуравны хоёрыг эзэлж, харин дунд болон дунд боловсролын дараах шатны боловсролд үзүүлэх тусламж үүнээс бага хувиар өссөн дүнтэй байна. Иймд боловсролд үзүүлсэн нийт тусламжаас суурь боловсролын хүртсэн хувь хэмжээ хамгийн өндөр түвшинд буюу 45%-д хүрсэн.

“

Бага орлоготой орнуудын суурь боловсролын тусламжаас хүртэх хувь 2002 онд 36% байснаас 2016 онд 22% хүртэл буурсан.

”


Суурь боловсролын тусламжийн хуваарилалт хамгийн их хэрэгцээтэй байгаа орнуудад өнөөг хүртэл хуваарилагдаагүй байна. Бага орлоготой орнуудын суурь боловсролын тусламжаас хүртэх хувь 2002 онд 36% байснаас 2016 онд 22% хүртэл буурсан. Буурай хөгжилтэй орнуудын хүртэх хувь 2016 онд 34% байгаа нь 2004 оны оргил үе буюу 47%-аас буурсан үзүүлэлттэй байна.

Дундаас доогуур орлоготой орнуудад мөн төсөв нь хүрэлцэхгүй байна. Эдгээр орнуудын боловсролд олон талт хөгжлийн банкнаас олгох зээлийн хэмжээ бага байдаг. Тухайлбал, 2002-2017 онд Олон Улсын Хөгжлийн Нийгэмлэг (ОУХН)-ээс олгосон хөнгөлөлттэй зээлийн боловсролын медиан нь 10.5% байгаа хэдий ч Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ОУСБХБ)-ны хөнгөлөлттэй бүс зээл ердөө 6.4%-тай байна. Цаашилбал, ОУСБХБ-ны зээлээс боловсролын салбарын хүртэх хувь 2012 оны 8.2%-аас 2017 онд 4.7% хүртэл буурсан нь эрчим хүч, олборлолтын салбарын хувийн дөрөвний нэгтэй тэнцүү байна (Зураг 19). Дэлхийн боловсролын боломжуудыг санхүүжүүлэх олон улсын зөвлөлийн санаачилгаар дундаас доогуур орлоготой орнуудын боловсролд олгох хөгжлийн банкны зээлийг нэмэгдүүлэх зорилготой Боловсролын төлөөх Олон Улсын Санхүүгийн Байгууллагыг байгуулах саналаар хэлэлцүүлэг өрнөж байна.

ЗУРАГ 19:

Дэлхийн Банкны хөнгөлөлттэй бус зээлийн боловсролын салбарт ногдох хэмжээ буурч байна

ОУХН, ОУСБХБ-ны нийт зээлийн хувь, боловсролын салбарыг эрчим хүч, олборлох салбартай харьцуулсан, 2002–2017 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig19_9

Эх сурвалж: Дэлхийн Банкны сонгогдсон тайлангуудад суурилсан БХШД-ийн тайлангийн багийн дүн шинжилгээ.

ТУСЛАМЖИЙГ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ БУУРУУЛАХ АРГАЧЛАЛ БОЛГОН АШИГЛАХ НЬ

Гадны тусламж шилжилт хөдөлгөөнийг бууруулна гэсэн санаа нь бодлогын хүрээнд дэмжлэг авч байна. Илгээгч орнуудын зардал болон татварын дараах хуримтлалын орлогыг нэмэгдүүлснээр шилжилт хөдөлгөөн хийх гол хүчин зүйлийг саармагжуулах юм. Шилжилт хөдөлгөөний талаарх Европын үзэл баримтлал хийгээд зарим орнуудын тусламжийн бодлогууд тус санааг дэмждэг.

“
Боловсролын салбарт үзүүлж буй тусламж шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөлөл нь маш бага байдаг тул тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

”

210 орноос 22 донор (зорьсон нутаг) орныг зорих шилжилт хөдөлгөөний урсгалын талаарх нэгэн судалгаа нь томоохон тооны шилжин явагсдыг илгээж буй орнууд хамгийн ихээр гадаадын тусламжийг авсан байгааг дурджээ. Гэсэн хэдий ч үүний учир шалтгааныг тодорхойлоход бэрх байдаг. Хэрэв тусламж ядуу өрхүүдэд хүрдэг бол энэ нь тэдгээрийн шилжин суурьших зардлыг санхүүжүүлдэг байж болзошгүй. Мөн тусламж нь донор орнуудын талаарх мэдээллийг нэмэгдүүлж, шилжин суурьшигчдын үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар цагаачлал хийхийг дэмждэг байх магадлалтай. Тиймээс бодлого боловсруулагчид шилжилт хөдөлгөөнийг багасгахад тусламжийн гүйцэтгэх үүрэг нөлөөллийн талаарх өндөр хүлээлтээ бууруулах шаардлагатай болж байна.

Боловсролын салбарт үзүүлж буй тусламж шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх нөлөөлөл нь маш бага байдаг тул тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Боловсролын салбарт үзүүлж буй тусламж нь шилжилт хөдөлгөөнийг бууруулдаг байлаа ч энэ өөрчлөлт нь тийм ч хурдан хугацаанд харагдахгүй. Гэсэн хэдий ч илгээгч болон хүлээн авагч орнуудын аль алины хувьд шилжилт хөдөлгөөнд боловсрол чухал зүүчлэх үүрэг гүйцэтгэнэ. Хойд Америкаас ЭЗХАХБ-ын гишүүн орнуудыг чиглэсэн шилжилт хөдөлгөөний чиг хандлагын талаарх судалгаа нь тухайн орны тусламжаас үүдэлтэй орлогын өсөлт нь боловсрол түвшин доогуур шилжин суурьшигчдын хувьд гадагш нүүхэд нөлөөлөх хүчин зүйл болж байгаа талаарх санааг дурджээ. Гэвч орон нутгийнхаа сургууль зэрэг төрийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдал нь шилжилт хөдөлгөөнийг сааруулах магадлалтай байна. Ерөнхийдөө зорьж буй орны хүн ам зүйн онцлогууд тухайлбал, хүн амын нягтаршил, хотын хүн амын өсөлт, наснаас хамааралтай харьцаа үзүүлэлтүүд болон зорьж очсон улс орны боловсролыг дэмждэг байдал нь тусламжийн түвшнээс илүүтэйгээр шилжилт хөдөлгөөний түвшинд нөлөө үзүүлж байна.

БОЛОВСРОЛД ҮЗҮҮЛЭХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ

2017 онд хүмүүнлэгийн тусламж дөрөв дэх жилдээ дараалан өссөн дүнтэй буюу боловсролд үзүүлэх олон улсын хүмүүнлэгийн санхүүжилт 450 сая ам.долларт хүрсэн байна. Гэвч боловсролын хүмүүнлэгийн тусламжид эзлэх хувь 2.1% байгаа нь 4%-ийн зорилтот түвшнээс нилээд доогуур байна. Боловсролын эдгээр санхүүжилтээс хүртэх хувь бусад салбартай харьцуулахад ер нь бага байсаар ирсэн. Хэдий тийм ч 2016 оны Дэлхийн хүмүүнлэгийн дээд түвшний чуулганаар Боловсрол хүлээх боломжгүй хэмээх олон талт санг байгуулан онцгой байдлын үеийн боловсролд дэмжлэг үзүүлэх шинэ үүрэг амлалт авсан.


Дэлхийн түвшнээс орон нутгийн түвшин хүртэлх босоо давхаргууд мөн салбарууд болон оролцогч талуудын хоорондын хэвтээ давхаргууд бүхий олон давхар зохицуулалтын механизм нь хүмүүнлэгийн тусламжийн бүтцийг илүү ярвигтай болгож, онцгой байдлын хариу арга хэмжээ дэх боловсролын салбарын оролцоог нэмэгдүүлэхэд саад учруулж байна. НҮБ-ын зохицуулалттай дэмжлэг нь хоёр төрлийн зохион байгуулалттай байдаг. Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд улс орнуудад чиглэсэн ихэвчлэн нэг жилээс дээш хугацаатай стратегийг хэрэгжүүлдэг. Нэн яаралтай тусламж нь хурцадмал нөхцөл байдлын үед гурваас зургаан сарын хугацаанд яаралтай тусламж үзүүлэх зориулалттай байдаг. Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнүүдэд боловсролын салбарт хамааралтай зүйл хязгаарлагдмал байдаг ба тусламжийн хүсэлтэд ч боловсролын салбар тэр болгон тусгагдаад байдаггүй.

Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын талаарх тайлагнах үүрэгтэй тогтолцоо байхгүй тул боловсролын салбарын зарцуулалтыг бүрэн бүртгэхэд бэрх. ЭЗХАХБ-ын Хөгжлийн тусламжийн хорооны Зээлдэгчийн тайлагналын тогтолцооны мэдээллийн сан хүмүүнлэгийн тусламжийг салбараар ангилдаггүй ч 2016 онд дүрвэгчдийн боловсролд хөгжлийн тусламжаас 400 сая ам.долларыг зарцуулсан хэмээн дурдсан байна. Хүмүүнлэгийн харилцааны санхүүгийн хяналтын үйлчилгээг хариуцах НҮБ-ын сайн дурын ажлын алба боловсролын санхүүжилтийг бүртгэх оролдлого хийдэг ч 2017 оны нийт санхүүжилтийн 42%-ийг олон салбарын ангиллаар бүртгэсэн эсвэл тусгайлан ангилаагүй байгаа нь боловсролын зарцуулалтыг маш тодорхойгүй тооцоолж буйг харуулж байна.

Боловсролын санхүүжилт хомс байх нь улс төрийн хүсэл эрмэлзэл, босоо, хэвтээ зохицуулалтууд, хүмүүнлэгийн байгууллагын чадавх, мэдээлэл болон хариуцлагын механизм гэх мэт хэд, хэдэн чиглэлийн үйл ажиллагааны дутагдалтай холбоотой.

2015 оны өртөг тооцох судалгаанд 8.5% тэрбум ам.долларын санхүүжилтийн дутагдалтай, үүнийг олон улсын байгууллагаас нөхөх шаардлагатай хэмээн тооцоолсон. Энэ нь нэг хүүхдэд 113 ам.доллар ногдохоор байгаа буюу нэг хүүхдэд ногдох одоогийн хэмжээг 10 дахин нэмсэнтэй тэнцэх дүн юм. Боловсрол хүлээх боломжгүй сан нь жилд 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө босгож, боловсролын хүмүүнлэгийн тусламжид эзлэх хувийг 2021 он гэхэд 1.2%-

Хямралын нөхцөлд буй хүүхдүүдийн
боловсролын хамгийн энгийн хэрэгцээг
хангахад боловсролын салбарын
хүмүүнлэгийн тусламжид эзлэх хувийг ...



аар нэмэгдүүлэхийг зорьж байна. Тус сангийн түншүүд хөгжлийн тусламжийн хүмүүнлэгийн зорилтуудыг эрэмбэлэх эсвэл хүмүүнлэгийн тусламжийн зорилтууд дунд боловсролын салбарыг эн тэргүүнд авч үзэх замаар хөрөнгө босгох үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх шаардлагатай.

Төлөвлөгөөнд байгууллагуудын хэрэгжүүлж дадсан үйл ажиллагаанаас илүүтэйгээр тэгш хамран сургалт, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг олгох үйл ажиллагаануудыг тусгах шаардлагатай. Дэлхийн Боловсролын Кластераас хэрэгцээний үнэлгээ хийх удирдамжийг боловсруулсан. Томоохон шинэ оролцогч талын хувьд Боловсрол хүлээх боломжгүй сан нь түншлэгч талуудад хөтөлбөрийг боловсруулах, тэдний чадавхыг хөгжүүлэхэд энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх шаардлага тавих боломжтой.

Хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд үндсэн оролцогч талууд хоорондын болон талууд тус бүрийн дотоод зохицуулалтын хувьд бэрхшээлтэй тулгарсаар ирлээ. Боловсролын салбар нь олон салбарын оролцоог хангасан хүмүүнлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд голлох байр суурь эзлэх хэрэгтэй. Бангладеш улсын Рохинжагийн хямралд боловсролын үйл ажиллагааг хямралын эсрэг арга хэмжээний эхний үе шатнаас хэрэгжүүлж, улмаар боловсролын үйлчилгээг маш шуурхай хүргэсэн. Гэвч зохион байгуулалтын дутагдалтай байдлаас болж боловсролын бус үйл ажиллагаануудад хүүхдүүдийн ихэнх цаг зарцуулагдаж байсан тул сургалтын төвүүд заримдаа хүнгүй байх тохиолдол гарч байсан.

Хүмүүнлэгийн болон хөгжлийн оролцогч талуудын хамтарсан төлөвлөгөө гаргах шаардлагатай. Олон салбарын оролцоотой төлөвлөгөө нь Рохинжагийн хүмүүнлэгийн арга хэмжээнд боловсролын оролцоог хангахад тустай байсан хэдий ч Бангладешийн боловсролын тогтолцоонд үүнийг орхигдуулсан. Удаан үргэлжилсэн хямралын үрт хугацааны тусламжийн хөтөлбөрүүд нь санхүүжилтийн хомсдолтой байсан ба үндэсний боловсролын төлөвлөгөөнүүдэд уян хатан буюу зохицон нийцэх чадвар болон хямралын эсрэг авах арга хэмжээ бараг тусгагдаж байгаагүй. Богино хугацаат хүмүүнлэгийн боловсролын төлөвлөлтийн хүрээг бүтцийн асуудлуудтай илүү уялдуулах шаардлагатай. Тухайлбал, 2018 оны 5 дугаар сард Уганда улсын Засгийн газрын Дүрвэгч болон хүлээн авагч иргэдэд чиглэсэн боловсролын хариу арга хэмжээний төлөвлөгөөнд гурван жилийн хугацаанд 395 сая ам.долларыг хуваарилсан бөгөөд жилд 675,000 дүрвэгч, хүлээн авагч иргэдийн суралцагчдад хүрч үйлчлэх зорилго тавьсан.

Австрали, Канад, Норвеги болон Их Британи зэрэг донор улс нь үрт хугацаат санхүүжилтийн бүтцэд шилжсэнээр хүмүүнлэгийн түнш байгууллагуудад урьдчилан тооцоолох боломжит санхүүжилтийг хүргэх нөхцөлийг хангах бөгөөд Боловсрол хүлээх боломжгүй сан нь үрт хугацааны уян хатан арга замаар хүмүүнлэгийн болон хөгжлийн бодлогын салангид байдлыг нэгтгэхийг зорьж байна. Хүмүүнлэгийн тусламжийн хариуцлагатай байдлыг бэхжүүлэх шаардлагатай. Боловсрол хүлээх боломжгүй сан нь стратегийн үр дүнгийн бүтцийнхээ хүрээнд өндөр стандартын шаардлага тавьснаар ил тод, үр дүнтэй байдлыг бэхжүүлэн, зөвхөн эцсийн үр дүн төдийгүй ажиллах арга барил, үйл ажиллагааны үр ашигтай байдал зэрэг чухал үзүүлэлтүүдийг тусгасан.


Өрхийн зардал

Өрхийн оруулж буй хувь нэмрийн талаарх мэдээлэл дутмаг байгаа нь боловсролын нийт зардалд дүн шинжилгээ хийх боломжийг урт хугацаанд хязгаарлаж байна. ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэнгээс анх 2017 онд өрхийн мэдээллийг гаргасан хэдий ч агуулга нь хязгаарлагдмал хэвээр байна. Боловсролын нийт зардалд өрхийн оруулж буй хувь нэмэр бага болон дунд орлоготой орнуудад маш өндөр байдаг, үүнд Эль Сальвадор (50%) болон Индонези (49%) улсын жишээг дурдаж болно (Зураг 20).

ЗУРАГ 20:

Зарим бага болон дунд орлоготой оронд өрхийн боловсролын зардал өндөр байна

ДНБ-д эзлэх боловсролын зардлын хувь, санхүүжилтийн эх үүсвэрээр, улс орны орлогын бүлгүүдээр, сонгогдсон орнуудаар, 2014–2016 он



ДБХШ StatLink: http://bit.ly/fig19_13

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн Хүрээлэнгийн мэдээллийн сан.

Ерөнхийдөө өрхийн зардлын мэдээлэл зарим онцгой тохиолдлуудыг эс тооцвол жилээс жилд огцом өөрчлөгддөггүй. Чили улсад засгийн газраас боловсролын салбарт оруулж буй санхүүжилт хангалтгүйн улмаас оюутны томоохон бослого гарч, улмаар төрийн бодлогод өөрчлөлт оруулахад хүргэсэн. Үүний үр дүнд нийт боловсролын зардалд өрхийн зардлын эзлэх хувь 2005 онд 50% байсан бол 2015 онд 20%-аас доош хувь болтол буурсан.

Зөвлөмж

Тус тайлан нь засгийн газруудад шилжин суурьшиж буй хүн ам, тэдний үр хүүхдүүдийн боловсролын хэрэгцээнд уугуул иргэдтэй ижил түвшинд анхаарал хандуулахыг уриалж байна.

ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ДҮРВЭГЧ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Боловсролд үл ялгаварлах зарчмыг олон улсын гэрээ, конвенциудад хүлээн зөвшөөрсөн байдаг. Шилжин суурьшигч, дүрвэгч иргэдийн хувьд төрсний гэрчилгээ шаардах зэрэг ялгаварлан гадуурхсан саад бэрхшээл учруулахыг хориглохыг үндэсний хууль журамд тусгайлан заах шаардлагатай. Мөрдөгдөж байгаа дүрэм журам нь орон нутгийн эсвэл сургуулийн түвшний ажилтан, албан тушаалтан өөрөөр тайлбарлан ойлгох нөхцөл бүхий алдаатай эсвэл дутуу тусгасан эсвэл бүрхэг зохицуулалттай байх ёсгүй. Засгийн газрууд нь цагаач, дүрвэгчдийн боловсрол эзэмших эрхийг аливаа баримт бичиг, оршин суух эрх зэрэг шаардлагуудаас үл хамааран хуулийг онцгой нөхцөлөөр хэрэгжүүлэх зэрэг асуудлаас үл хамааран хамгаална.

Боловсрол эзэмших эрхийг хүндлэх явдлыг хууль тогтоомж, захиргааны үйл явцаас дээгүүр авч үзэх ёстой. Үндэсний удирдлагууд цагаач, дүрвэгчдэд тэдний эрх, сургуульд бүртгүүлэх үйл явцын талаар мэдээлэл олгох зорилгоор ойлголт мэдлэгийг түгээх кампанит ажлыг өрнүүлэх хэрэгтэй. Төлөвлөлт хариуцсан албан тушаалтнууд улсын сургуулиудыг албан бус суурин, ядуусын хороололд хүртээмжтэй байхаар нийцүүлэх, тэдгээр иргэдийг хот, суурин газрын дахин төлөвлөлтөд ялгаварлахгүй байх нөхцөлийг хангана.

ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ДҮРВЭГЧДИЙГ ҮНДЭСНИЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНД ХАМРУУЛАХ

Боловсролын зарим тогтолцоонд цагаач, дүрвэгч иргэдийг уугуул иргэдээс ялгаатай буюу түр суурьшигч эсвэл дамжин өнгөрч буй хүмүүс хэмээн үздэг. Энэ нь буруу үйлдэл юм; ингэх нь тэдний суралцах үйл явц, нийгэмшил болон ирээдүйн боломжуудад нь саад тотгор болж, олон янз байдлыг хөхиүлэн дэмжсэн, эв нэгдэлтэй нийгмийн төлөөх үйл явцыг доройтуулдаг. Төрийн бодлого нь эдгээр иргэдийг үндэсний боловсролын бүхий л түвшинд хамрагдахыг баталгаажуулах ёстой.

Цагаачдын оролцооны асуудал нь хэд хэдэн талтай. Сургалтын шинэ хэлний улмаас цагаач, дүрвэгч суралцагчид бэлтгэл үеийн хичээлүүдэд хамрагдах шаардлагатай болох хэдий ч тэднийг уугуул үе тэнгийнхнээс нь аль болох бага хугацаанд тусад нь суралцуулах хэрэгтэй. Боловсролын тогтолцоо нь цагаач, дүрвэгч суралцагч олон байдаг сурлагын амжилтаар доогуур түвшний хүүхдүүдийн бүлгийг ялгаатай ангиллаар хуваарилан сургахгүй байх хэрэгтэй. Олон улс оронд цагаач суралцагчид газарзүйн байршлын хувьд цөөхөн сургуульд төвлөрөн суралцдаг байдлыг харгалзан боловсролын бодлого төлөвлөгчид гэр, сургууль хооронд зорчих унааны тэтгэлэг, санамсаргүй түүврийн аргаар сургуулиудад хуваарилах зэрэг аргачлалыг ашиглаж оршин суух газрын тусгаарлалт нь боловсролын хувьд тусгаарлалтад хүргэхгүй байх нөхцөлийг хангах хэрэгтэй.

Засгийн газрууд дүрвэгчдийн боловсрол аль болох бага хугацаанд тасалдах байдлыг хангах хэрэгтэй. Онцгой нөхцөл байдлууд болох дүрвэгчдийн газарзүйн байршлын алслагдмал байдал, хүлээн авагч орны хүчин чадал хүрэхгүй байх зэрэг нь тэгш хамруулалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж болох ч засгийн газрууд сургуулиудад үндэсний сургалтын хөтөлбөрийг мөрдөхгүй байх эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн сертификатын түвшингээр суралцахгүй байх хугацааг хамгийн бага түвшинд байлгах хэрэгтэй. Учир нь энэ хугацаа урт байх тусам боловсрол эзэмших замыг эргэлзээтэй болгодог.

ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ДҮРВЭГЧ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭГ ОЙЛГОЖ, ТӨЛӨВЛӨХ

Цагаач, дүрвэгчдийн урсгал өндөр улс орнууд удирдлагын мэдээллийн системдээ эдгээр хүн амын талаарх мэдээллийг оруулж, түүний дагуу төлөвлөлт болон төсөвлөлтийг хийх хэрэгтэй. Цагаач, дүрвэгчдийг сургууль эсвэл ажил хөдөлмөр хийх боломжоор хангаж буй нь тэгш хамрагдалтыг бүрдүүлэх зөвхөн эхний алхам юм.

Сургуулийн орчинг суралцагчдын хэрэгцээнд нийцүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Шинэ хэлээр суралцах шаардлагатай болсон суралцагчдыг мэргэшсэн багшийн удирдлага дор бэлтгэл хөтөлбөрүүдэд хамруулах хэрэгтэй. Суралцах үйл явц нь тасалдсан иргэдийн хувьд түргэвчилсэн сургалтын хөтөлбөрт хамрагдах нь тэднийг холбогдох стандартыг нөхөж эзэмших мөн сургуулийн зохих түвшинд эргэн хамрагдах боломжийг олгоно. Хэрэв дүрвэгчдийг боловсролын үйлчилгээнд хамруулахын зэрэгцээ боловсролын шууд бус зардлыг төлөх нөхцөлт мөнгөн тэтгэмж зэрэг үр шимийг нь хүртэж болох нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамруулбал илүү амжилтанд хүрэх болно. Дотооддоо шилжин суурьшигчдын хувьд малчид, улирлын онцлогтой ажил эрхлэгчдийн хүүхдүүдэд засгийн газраас сургуулийн хуваарийг уян хатан байлгах, боловсролын бүртгэлийн тогтолцоо болон сургалтын хөтөлбөрийг тэдний ахуй амьдралтай үялдаатай болгон өөрчлөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Насанд хүрэгчдэд техник, мэргэжлийн боловсролоор дамжуулан үр чадвараа хөгжүүлэх, мөн тэднийг үр чадвараа дээшлүүлэхэд хөрөнгө оруулахыг мохоодог үр чадвар доогуур түвшин шаардсан ажил мэргэжил эсвэл сургалтын өндөр зардал зэрэг бэрхшээлт асуудлуудыг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тэдэнд санхүүгийн боловсролын хөтөлбөр хэрэгтэй ба энэ нь санхүүгийн байдлаа удирдах, мөнгөн гуйвуулгыг хамгийн үр дүнтэй байдлаар ашиглах, залилан болон санхүүгийн луйвраас зайлсхийх чадвартай болоход нь тусалдаг. Орон нутгийн захиргаанаас хэрэгжүүлэх албан бус боловсролын хөтөлбөрүүд нь нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх хүчин чармайлтыг дэмжих болно.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БҮХИЙ ӨРӨӨСГӨЛ ХАНДЛАГЫГ ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХИЙН ТУЛД ШИЛЖИН СУУРЬШИЛТ, ДҮРВЭЛТИЙН ТАЛААРХ ТҮҮХИЙГ БОЛОВСРОЛД ҮНЭН ЗӨВӨӨР ТУСГАХ

Тэгш хамруулсан нийгмийг бүтээх, иргэдийг хамтдаа амьдрахад туслахад тэвчин хүлцэхээс илүү ихийг шаарддаг. Засгийн газрууд боловсролын агуулга, түүний хэрэгжилтийг хянан үзэж, түүх болон өнөөгийн соёлын олон янз байдлыг тусгахын тулд сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, сурах бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай. Боловсролын агуулгад шилжилт хөдөлгөөний улс орны хөгжил, баялагт оруулж буй хувь нэмрийг онцгойлон тусгах хэрэгтэй. Мөн түүнчлэн хурцадмал байдал болон зөрчилдөөний учир шалтгаан, иргэдийг дүрвэх, эмзэг байдалд ороход хүргэсэн шилжилт хөдөлгөөний үр дагаврыг тодорхойлох хэрэгтэй. Сурган хүмүүжүүлэх олон төрлийн арга зүй нь олон янзын үзэл бодолд нээлттэй хандахыг дэмжих, хамтдаа амьдрахын үнэ цэнийг хөгжүүлж, олон янз буюу ялгаатай байдлын үр ашгийг хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Эдгээр арга зүй нь мөн ялгаварлан гадуурхалт бүхий өрөөсгөл ойлголтыг үгүйсгэж, шүүмжит сэтгэлгээг хөгжүүлснээр суралцагчид бусад соёлуудтай харилцахад тулгарч буй тодорхойгүй байдлыг даван туулдаг, цагаач, дүрвэгчдийн талаар хэвлэл мэдээллээр түгээсэн сөрөг ойлголтуудыг эсэргүүцдэг байх нь нэн чухал. Засгийн газрууд олон соёлын талаарх боловсролын эерэг түршлагаас суралцах хэрэгтэй.

ЦАГААЧ, ДҮРВЭГЧДИЙН БАГШ НАРЫГ ОЛОН ЯНЗ БУЮУ ЯЛГААТАЙ БАЙДАЛ, БЭРХШЭЭЛТ АСУУДЛУУДЫГ АНХААРАН АВЧ ҮЗЭХЭД БЭЛТГЭХ

Багш нарыг шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн улмаас ихээхэн хувиран өөрчлөгдөж буй сургуулийн орчин дахь өөрчлөлтийн эзэд болоход дэмжлэг хэрэгтэй.

Шилжилт хөдөлгөөний асуудлуудыг тусгасан багшийн боловсролын хөтөлбөрүүд нь одоогийн байдлаар сургалтын үндсэн хөтөлбөрийн нэг хэсэг бус харин түр зуурын нэмэлт хөтөлбөрийн хэлбэртэй байна. Засгийн газрууд олон янз, олон хэлт болон олон соёлт нөхцөл байдлыг удирдан зохицуулах үндсэн цогц чадамжууд болон чадварыг төлөвшүүлэх сургалтыг багш мэргэжлээр ажиллаж эхэлж буй багш нарын сургалт болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хөрөнгө оруулах шаардлагатай. Энэ нь тухайн нутаг дэвсгэрийн уугуул суралцагчдад мөн үр нөлөөтэй. Шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн талаарх ойлголт мэдлэгийг зөвхөн олон үндэстний суралцагчидтай анги танхимд ажилладаг багш нарт биш бүх багшид олгох хэрэгтэй. Урам зоригтой, дадлага түршлагатай багш нар, сургуулиудын

удирдлагуудыг анги танхим, сургуулийн орчин болон олон нийтийн дундах нийгмийн хэвшсэн хуучинсаг ойлголт, ялгаварлан гадуурхалт бүхий өрөөсгөл хандлага болон ялгаварлан гадуурхах үзэлтэй тэмцэж цагаач, дүрвэгч суралцагчдад өөртөө итгэх итгэл, тухайн нутаг, хүн амын бүлэгт харьяалагдах өөриймсөг мэдрэмжийг бэхжүүлэхэд шаардлагатай аргачлалаар хангах хэрэгтэй.

Дүрвэгчидтэй ажиллаж буй багш нар суралцагчид, эцэг эхчүүдэд тулгарч буй бэрхшээлүүдэд мэдрэмжтэй хандаж, тэдэнд хүрч үйлчлэх хэрэгтэй. Багш нар сэтгэлзүйч биш хэдий ч тэд стресс, сэтгэлзүйн хямрал зэргийг тодорхойлоход бэлтгэгдэж, тусламж хэрэгтэй хүмүүсийг мэргэжлийн ажилтан, тусламж үйлчилгээтэй холбон зуучилна. Хэрэв мэргэжлийн ажилтан үгүй бол зарим өрх боловсролын үйлчилгээнээс өөр ямар ч үйлчилгээнд хамрагдах боломжгүй үед багш нар зохих тусламж үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэгдсэн байх ёстой. Цагаач, дүрвэгчдийн багш нар болон дүрвэгч багш нар мөн нэмэлт стресст өртөж байдаг. Удирдлагын бодлого, журамд зарим багш нарын ажиллаж буй туйлын хэцүү нөхцөл байдлуудыг тодорхойлж, стрессээс ангижруулах арга хэмжээ авах, ёс суртахууны хэм хэмжээг хадгалах зорилгоор багш ажилтнуудын эрх тэгш байдлыг бодлого журмаар зохицуулах, баталгаажуулах төдийгүй, мэргэжил дээшлүүлэхэд хөрөнгө оруулах шаардлагатай.

ЦАГААЧ, ДҮРВЭГЧ ИРГЭДИЙН ЧАДАВХЫГ АШИГЛАХ

Цагаач, дүрвэгчид зөвхөн өөрсдийн болон гэр бүлийнхээ амьдрал төдийгүй хүлээн авагч улс орны болон буцаж очоогүй ч зайнаас эх орныхоо эдийн засаг, нийгмийг өөрчлөхөд туслах боломж бүхий чадавх, мэдлэгтэй байдаг. Энэхүү чадавхыг ашиглахын тулд тэдний эзэмшсэн боловсрол, мэдлэг болон мэргэжлийн ур чадвар (үүнд багш нарын ур чадварыг хамруулан ойлгоно) төдийгүй гэрчилгээжүүлэгдээгүй өмнөх сургалтыг илүү энгийн, хямд, ил тод, уян хатан механизмын хүрээнд хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Улс орнууд Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжилт хөдөлгөөний талаарх даян дэлхийн гэрээгээр боловсролын зэрэг, мэргэжлийн ур чадварыг харилцан хүлээн зөвшөөрөхтэй холбоотой хүлээсэн амлалт үүргээ биелүүлэх, Дээд боловсролын зэрэг хүлээн зөвшөөрөх талаарх даян дэлхийн конвенцийн хүрээнд дэх зөвшилцөлийг дуусгаж, түүнийг 2019 онд батлах хэрэгтэй байна. Үнэлгээний байгууллагууд, лиценз олгох эрх бүхий байгууллагууд, их, дээд сургуулиудаас засгийн газрууд, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай хамтран хоёр талт, бүс нутгийн болон олон улсын түвшинд шаардлага, журмуудыг нийцүүлэх хэрэгтэй. Боловсролын зэрэг олгох нэгдсэн стандарттай байх, чанарын баталгаажилтын механизм болон академик солилцооны хөтөлбөрүүд нь боловсрол, мэргэжлийг харилцан хүлээн зөвшөөрөх асуудалд дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

ХҮМҮҮНЛЭГИЙН БОЛОН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНД ЦАГААЧ, ДҮРВЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭГ ДЭМЖИХ

Олон улсын шилжин суурьшигчдын гуравны хоёр нь өндөр орлоготой орнуудад суурьшсан байхад 10 дүрвэгч тутмын 9 нь олон улсын түншлэгчдээс дэмжлэг хүсдэг бага, дунд орлоготой орнуудад амьдарч байна. Тэдний хэрэгцээг хангахад хүмүүнлэгийн тусламж дахь боловсролын эзлэх хувийг арав дахин нэмэгдүүлэх шаардлагатай. Олон улсын түвшинд Дүрвэгчдийн талаарх даян дэлхийн гэрээ, Дүрвэгчдэд зориулсан хариу арга хэмжээний талаарх цогц хүрээнд хүлээсэн үүрэг амлалтын илүү тогтвортой шийдэл нь дүрвэгчид болон хүлээн авагч хүн амыг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан орчинд суралцуулахад дэмжлэг үзүүлэх замаар хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламжийг хямралын эхний шатнаас үзүүлэх явдал юм. Хариу арга хэмжээний төлөвлөлтөд боловсролын үйлчилгээ ялангуяа, бага насны хүүхдийн боловсрол, асаргааг оруулах хэрэгтэй. Энэ нь орон байр, хүнс тэжээл, ус хангамж, ариун цэвэр, нийгмийн хамгаалал зэргийг хамруулсан цогц үйлчилгээ байх ёстой. Хандивлагчид эдгээр шинэчлэлүүдийг хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүддээ тусгах шаардлагатай. ‘Боловсрол хүлээх боломжгүй’ сангийн хүчин чадалд тулгуурлан тэд хэрэгцээний үнэлгээний чадавхаа бэхжүүлэх, хүмүүнлэгийн болон хөгжлийн салангид байдлыг уялдуулах болон урт хугацааны урьдчилан төлөвлөж болохуйц санхүүжилтийг хурдасгах төлөвлөлтөд нэгдэх хэрэгтэй.

Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол:

Х А Н А Х Э Р Э М Б У С Г Ү Ү Р Б А Р И Х Н Ъ

2019 оны Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан нь шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн боловсролд үзүүлэх үр нөлөөг хилийн дотор болон хил дамнан, сайн дураар болон албадлагад өртөн, хөдөлмөр эрхлэх болон боловсрол эзэмших зорилгоор хийгдэж буй хүн амын бүхий л төрлийн шилжилт хөдөлгөөний хүрээнд авч үзлээ. Тэрчлэн 2030 Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр дэх боловсролын зорилтуудын хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, ахиц дэвшлийг хянан үзлээ.

Өсөн нэмэгдэж буй олон янз буюу ялгаатай байдлын хүрээнд тус тайланд боловсрол нь тэгш хамрагдалтай нийгмийг хөгжүүлэх болон иргэдэд хүлцэж тэвчихээс цаадах алхмыг хийж, зэрэгцэн амьдрахад суралцахад хэрхэн тусалж болох талаар шинжлэн үзсэн. Боловсролыг эрх тэгш байдлаар олгох нь гүүр барьдаг байхад эрх тэгш бус үйлчилгээ нь цагаач, дүрвэгчид болон тэднийг хүлээн авагч иргэдийн дунд хана хэрмийг босгодог.

Шилжин суурьшигчид, дүрвэгчдийн талаарх даян дэлхийн шинэ хоёр гэрээ нь боловсролын гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрч, хэнийг ч үл орхигдуулах зарчмын талаарх дэлхий даяар хүлээсэн үүрэг амлалттай зорилтуудаа үялдүүлсэн.

Энэхүү тайлан нь дээр дурдсан даян дэлхийн хоёр гэрээний хувьд чухал аргачлал болно. Тайланд улирал даган шилжин суурьшигчид, хөдөөний сургуулийг нэгтгэх, соёл хоорондын сургалтын хөтөлбөр, үндэсний боловсролын тогтолцоонд дүрвэгчдийг тэгш хамруулах, тусгаарлалттай тэмцэх, боловсрол, мэргэжлийн түвшинг харилцан хүлээн зөвшөөрөх, сургуулийн санхүүжилтийг тодорхой асуудалд чиглүүлэх, хүмүүнлэгийн боловсролын тусламжийг илүү үр дүнтэй болгох болон олон үндэстний суралцагчидтай анги танхимд ажиллах багш нарыг бэлтгэх зэрэг бодлогын нэн чухал асуудлуудыг тусгасан.

Тус тайлан нь боловсролыг шилжилт хөдөлгөөн, дүрвэлтийн асуудлуудыг удирдан зохицуулах аргачлал, хэрэгтэй нэгний хувьд боломж хэмээн авч үзэхийг үлс орнуудад уриалж байна.

Боловсрол бол хүний эрх бөгөөд ядуурлыг бууруулах, тогтвортой байдал болон энх тайвны төлөөх өөрчлөлтийн хүч билээ. Ажил хөдөлмөр эрхлэхээр эсвэл суралцахаар, сайн дураараа эсвэл албадлагаар шилжин суурьшиж буй хүмүүс боловсрол эзэмших эрхээ ардаа үлдээдэггүй. 2019 оны Дэлхийн Боловсролын Хяналт Шинжилгээний Тайлан нь шилжин суурьшигчид, дүрвэгчдийн чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдахыг баталгаажуулах томоохон боломж, бололцоог онцлон тэмдэглэж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес

Тус тайланд гайхалтай боломжийн дүрслэлийг өнгө будгаар тодруулахын зэрэгцээ сурч боловсрох боломжгүй байдал хаана, яагаад үүсэж байгаа зэрэг асуудлаарх бидэнд байгаа шилжилт хөдөлгөөн болон боловсролын талаарх баримт нотолгоо, мэдээллийг хамтатган нэгтгэж үзүүлж байна. Энэ нь дэлхий нийтээрээ ТХЗ-уудыг хангахаар тэмцэж буй болон дэлхий даяар шилжилт хөдөлгөөний үр өгөөжийг нэмэгдүүлэхийг хичээж буй цаг мөчтэй давхцаж байна.

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын Ерөнхий захирал Виллиам Ласи Свинг (2008 оны 10 дугаар сарын 1 - 2018 оны 9 дүгээр сарын 30)

Тус тайлан нь Дүрвэгчдийн талаарх даян дэлхийн гэрээнд тусгасан боловсролын ач холбогдлын тухай тун сонирхолтой үндэслэл болон дүрвэгчдийг үндэсний боловсролын тогтолцоо, боловсролын салбарын төлөвлөгөөнд хамруулах шаардлагыг харуулж байна.

НҮБ-ын Цагаачдын Асуудал Эрхэлсэн Дээд Комиссар Филиппо Гранди

